Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ий орчмоос авсан агаарт азотын давхар исэл, хүхэрлэг хий MNS 4585:2025 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... С.Цэнджав  
 Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч..... М.Аягүл  
 Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга..... О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.  
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 35. Агаарын шинжилгээ ШТС орчим



Зураг 36. Агаарын шинжилгээ ил уурхай орчимд



**Зураг 37. Агаарын шинжилгээ баяжуулах үйлдвэр орчимд**



**Зураг 38. Агаарын шинжилгээ уурхайн ажилчдын байр орчимд**



**Зураг 39. Нефтийн бүтээгдэхүүний үлдэгдлийн шинжилгээ**

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он 2025 / № X79  
 Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас: "Хандгайт гол" ХХК  
 Дээжийн тодорхойлолт: Ерөө сум  
 Дээж авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл  
 Дээжийн тоо, төрөл: 2, Хөрс  
 Хүлээн авсан огноо: 2025 - 09 - 03  
 Дээжийн тодорхойлох үзүүлэлт: нефтийн бүтээгдэхүүн  
 Шинжилгээ хийж дууссан огноо: 2025 - 09 - 10

Үр дүн:

№	Дээж авсан цэгийн нэр	РН	Нефтийн бүтээгдэхүүн мг/кг
1	ШТС	8.85	8.6
	MNS 5850:2008 стандарт дахь хүлцэх агууламж /ХА/	-	20.0

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ний ШТС болон засварын газраас авсан хөрсний дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 5850:2008 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байлаа.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... С.Цэнджав  
 Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч..... М.Аягүл  
 Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга..... О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.  
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

**Зураг 40. ШТС-ийн талбайгаас агаарын шинжилгээ болон хөрсний нефтийн бүтээгдэхүүн тодорхойлох шинжилгээ**



9.2. Хөрсний шинжилгээний үр дүн

Зураг 41. Хөрсний агрохимийн үзүүлэлт

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / Х74-78

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

"Хандгайт гол" ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

5, Хөрс

Хүлээн авсан огноо

2025 - 09 - 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

агрохимийн үзүүлэлт

Шинжилгээний аргын стандарт

MNS 3310:1991

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 - 09 - 10

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд, мг/кг							
		РН	Сульфат	Цийг %	Нитрат	Аммоний азот	Ялзмаг	ЕС, мS/cm	Фосфор
1	Ил уурхай	9.83	73.0	1.17	6.2	34.3	2.4	18.33	28.4
2	Баяжуулах	7.35	57.2	1.08	5.5	27.2	0.9	76.4	24.3
3	Шимт хөрсний овоолго	6.24	61.5	1.01	8.0	32.8	0.2	22.5	19.7
4	Хаягдлын овоолго	9.16	41.8	1.11	10.4	44.6	1.5	12.7	28.8
5	Кемп	9.66	61.9	1.10	6.7	21.6	1.4	25.8	32.6
MNS 3297:2019 стандарт дахь ЗДХ		6-9	160.0	-	130.0	-	-	-	-

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ний орчмоос авсан хөрсний дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 3297:2019 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... *С.Цэнджав* ..... С.Цэнджав

Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч..... *М.Аягүл* ..... М.Аягүл

Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга..... *О.Ганбат* ..... О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.  
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг- 4. Баяжуулах үйлдвэрийн орчимд авсан хөрсний дээж



Зураг- 5. Кемп орчимд авсан хөрсний дээж



Зураг 42. Хөрсний хүнд металлын шинжилгээ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
 БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЭҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Увсдээр 2-д, Чингисийн ертөнчлөгөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот  
 Утас: 11-341818 И-мэйл: [bolcsel@bolcsel.com](mailto:bolcsel@bolcsel.com)

СОРИЛТЫН ДҮН

Дугаар ойл/№ : 2025/561-582  
 Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг/утас : "Хандгайт гол" ХХК  
 Сорьц авсан хүний нэр/агбан тугшаал : М.Ангуль БОШД-ийн зөхлөгч  
 Сорьцын тоо, төрөл : 2 хөрсний сорьц  
 Сорьц авсан огноо : 2025.09.10  
 Сорьцын тодорхойлолт : Сэлэнгэ аймаг, Ерөө сум  
 Шинжилгээний аргын стандартаг : САЭ А.01:2022  
 Шинжилсэн огноо : 2025.09.16  
 Хуудасны тоо : 1/1  
 Үр дүн



№	Сорьц авсан цэглэйн нэр	mg/kg						
		Кадмий (Cd)	Хар тугага (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронци (Sr)
1	Көмл	1.5	21	<0.005	<0.5	300	20	561
2	Уурхай	<0.05	38	<0.005	<0.5	350	30	352
	MNS 5850:2019/ЗДХ	3	100	2	150	300	100	800

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
 Хянаж баталгаажуулсан:



Ахлах шинжээч Б.Давасорон  
 БОШД-ний хэлтсийн дарга Б.Бэрхсэрлэнчав

Дуулиорголын харгалзахийг хариуцана  
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 43. Хаягдал усны шинжилгээ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № У123-124

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

"Хандгайт гол" ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

2, Хаягдал ус

Хүлээн авсан огноо

2025 - 09- 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

биогений элемент

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 – 09 - 08

Үр дүн:

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Орох мг/л	Гарах мг/л	MNS 4943:2015
MNS ISO 10523:2001	РН –орчин	7.61	7.52	<b>6.0-9.0</b>
MNS 6836:2020	Жинлэгдэх бодис, мг/л	650.0	<b>368.0</b>	<b>30.0</b>
MNS ISO 5815:2015	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, мгО/л	301.0	<b>44.5</b>	<b>20.0</b>
MNS ISO 6060:2001	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, мгО/л	848.0	<b>763.2</b>	<b>50.0</b>
MNS 1097:2023	Аммоны азот, мгN/л	8.12	<b>15.17</b>	<b>15.0</b>
MNS 6779:2019	Нитрит, мгN/л	0.367	<b>0.373</b>	
MNS 6834:2020	Нитрат, мгN/л	0.71	<b>1.20</b>	
MNS ISO 11083:2001	Хром6+, мг/л	0.564	0.428	<b>0.01</b>
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар, мгО/л	87.6	<b>56.1</b>	<b>20.0</b>
MNS ISO 6878:2001	Фосфор, мг/л	0.024	0.066	<b>1.5</b>
CAЗ У 21:2012	Өнгө	18.84	1.17	
Цэвэршилтийн хувь		85.22		

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ийн хаягдал усны химийн шинжилгээ хийж үзэхэд ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын MNS 4943:2015 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс жинлэгдэх бодис 12.27 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 2.22 дахин, химийн хэрэгцээт хүчилтөрөгч 15.26 дахин, нийт азот 1.12 дахин, перманганатын исэлдэх чанар 2.8 дахин тус тус их бөгөөд цэвэршилт 85.22 хувь байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... С.Цэнджав

Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч..... М.Аягүл

Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга..... О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 44. Баянголын усны шинжилгээ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № У119-120

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

"Хандгайт гол" ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

2, Баянгол гадаргын ус

Хүлээн авсан огноо

2025 - 09 - 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

гол ион, биогений элемент

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 - 09 - 08

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Дээд цэг	Доод цэг	MNS 4586:2024 I зэрэг
MNS ISO 10523:2001	РН –орчин	8.05	8.04	6.5-8.5
CA3 У 21:2012	Өнгө	-	-	
MNS 1097:2023	Кальци, мг/л	68.2	65.3	<25
MNS 1097:2023	Магни, мг/л	26.4	24.2	<10
MNS 1097:2023	Аммоны азот, мгN/л	0.59	0.67	0.2
MNS 4430:2005	Төмөр /нийт/, мг/л	0.12	0.18	<0.3
MNS 9297:2005	Хлор, мг/л	1.8	1.8	200
MNS 6271:2011	Сульфат, мг/л	116.6	114.4	<60
MNS 6779:2019	Нитрит, мгN/л	0.051	0.058	0.01
MNS 6834:2020	Нитрат, мгN/л	3.27	2.21	1.0
MNS 6831:2020	Гидрокарбонат	234.9	234.9	
MNS ISO 6059:2005	Хатуулаг, мг-экв/л	5.57	5.25	<7
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар, мгO/л	1.8	1.9	
MNS 6272:2011	Фтор, мг/л	0.39	0.55	0.5-1.5
MNS 1097:2023	Эрдэжилт, мг/л	469.1	467.6	<1000
CA3 У 20:2012	Na+K, мг/л	19.8	26.3	
MNS ISO 6878:2001	Фосфор, мг/л	Илрээгүй	Илрээгүй	0.05
MNS ISO 7888:1999	ЕС, µs/cm	581.0	589.0	
	Булингар, FNU	1.97	1.88	<5.0
MNS 6835:2020	Цахиур, мг/л	4.76	5.00	
MNS ISO 11083:2001	Хром+6, мг/л	Илрээгүй	Илрээгүй	<0.01

**Дүгнэлт:** Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ний ойр урсах Баянгол голын уснаас сорьц авч шинжилгээ хийж үзэхэд гадаргын усны MNS4586:2024 стандарт дахь зөвшөөрөгдөх хэмжээнээс кальци 2.61-2.73 дахин, магни 2.42-2.64 дахин, сульфат 1.91-1.94 дахин, нитритийн азот 5.1-5.8 дахин, нитратын азот 2.21-3.27 дахин тус тус давсан байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... С.Цэнджав

Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч..... М.Аягүл

Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга..... О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.  
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

06192

Зураг 45. Ундны усны шинжилгээ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № У121

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас: "Хандгайт гол" ХХК  
 Дээжийн тодорхойлолт: Ерөө сум  
 Дээж авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл  
 Дээжийн тоо, төрөл: 1, Ундны ус  
 Хүлээн авсан огноо: 2025 - 09 - 03  
 Дээжийн тодорхойлох үзүүлэлт: гол ион, биогений элемент  
 Шинжилгээ хийж дууссан огноо: 2025 - 09 - 04  
 Үр дүн:

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Худгийн ус	MNS 900:2010
MNS ISO 10523:2001	РН –орчин	7.61	6.5-8.5
CA3 У 21:2012	Өнгө		20 градус
MNS 1097:2023	Кальци, мг/л	161.8	100.0
MNS 1097:2023	Магни, мг/л	40.1	30.0
MNS 1097:2023	Аммоны азот, мг/л	Илрээгүй	1.5
MNS 4430:2005	Төмөр /нийт/, мг/л	Илрээгүй	0.3
MNS 9297:2005	Хлор, мг/л	23.0	350.0
MNS 6271:2011	Сульфат, мг/л	337.4	500.0
MNS 6779:2019	Нитрит, мг/л	0.026	1.0
MNS 6834:2020	Нитрат, мг/л	7.50	50.0
MNS 6831:2020	Гидрокарбонат	306.6	
MNS ISO 6059:2005	Хатуулаг, мг-экв/л	11.37	7.0
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар, мгО/л	2.7	
MNS 6272:2011	Фтор, мг/л	0.28	0.7-1.5
MNS 1097:2023	Эрдэжилт, мг/л	902.2	
CA3 У 20:2012	Na+K, мг/л	33.3	
MNS ISO 6878:2001	Фосфор, мг/л	0.049	3.5
MNS ISO 7888:1999	ЕС, µs/cm	1197.0	1000.0
	Булингар, FNU	Илрээгүй	5.0
MNS 6835:2020	Цахиур, мг/л	8.41	
MNS ISO 11083:2001	Хром+6, мг/л	Илрээгүй	

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ийн худгийн усанд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 900:2010 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс кальци 1.62 дахин, магни 1.34 дахин, хатуулаг 1.62 дахин их байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... С.Цэнджав  
 Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч..... М.Аягүл  
 Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга..... О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.  
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



Төслийн талбайд агаар, ус, хөрсний ерөнхий химп болон хөрсний хүнд металын шинжилгээ авсан.

Зураг 46. Баянголоос усны дээж авсан цэг



Зураг 47. Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдсэн бохир усны шинжилгээг авсан.



Хүснэгт 7. Хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний дээж	Сөрөг нөлөөлийн хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээний хэлбэр, зардал	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Хяналт шинжилгээ явуулах байршил	Тайлбар	Хэрэгжүүлсэн хувь
1	Агаар	Хүхэрлэг хий, азотын давхар исэл	152 500	10 сард	Кемп,	4 цэгт хэмжилт хийхэд агаарын чанарын стандарт MNS4585-2016 сатндартаас давсан үзүүлэлт гараагүй. Шинжилгээний үр дүнг хавсралтаар үзүүлэв.	100%
2	Ус	pH, перманганат, жинлэгдэгч бодис, кальци, магни, натри-кали, хлорид, сульфат, гидрокарбонат, аммонийн азот, нитритийн азот, нитратийн азот, фосфор, фтор, төмөр, эрдэсжилт, хатуулаг, цахилгаан дамжуулах чанар- усны температур	362000	10 сард	Баянгол Цэвэрлэгдсэн бохир ус	Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн , 1-р төрлийн чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Усан орчны чанарын үзүүлэлт MNS4586:1998” стандартын шаардлага хангаж байна.	100%
3	Хөрс	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилчих кали, карбонат,	233 500	10 сард	Кемп, Баяжуулах үйлдвэр	Дээж нь сул хүчиллэг урвалын орчинтой,	100 %

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАНДГАЙТГОЛ ХХК-ИЙН  
 MV-021595 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ БАЯНГОЛЫН ЭХ  
 ХӨНДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ

2025 он

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери				карбонатгүй, ялзмагийн агууламжаар их зэрэг, Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд зэрэг байна.	
	Хөрс	Эрүүл ахуйн шинжилгээ	100 000				100%
4	Ажлын хөлс	Унаа томилолтын зардал	1880 000				100%
Нийт			<b>2978 000 төг</b>				100 %


Хүснэгт 8. Төлбөрийн задаргаа

Хавсралт 1

"Хандгайт гол" ХХК-д хийгдэх Байгаль орчны цэмцгэлтэй хийх төлөвлөгөө

Дэлгэц тусгай	БЭГҮЙ	Хэмжээний үзүүлэлтүүр	Хийгдэх зурвэлтүүр	Нэг цэмцгэлтэй төлбөр			
Эвэрлэгдсэн	Амьсгалын усны	500, 1000, 1500, 2000 чөлөө	500	12000	5	60000	
	Биеийн усны		1000	12000	5	60000	
	Урьдчилсан		МУ10 зогсон Биеийн усны дүрэмтэй 24 шалбар	30000	1	30000	
	Төлөвлөгөөний зам 1		Хүдрийн ус MNS 000-2018	45000	1	45000	
	Төлөвлөгөөний зам 2		Хүдрийн ус MNS 000-2018	37000	2	74000	
Урвал	Урвалын усны	Трэнкэй усны цэмцгэлтэй	Толгой ус MNS 000-2018	38000	1	38000	
	Урвалын усны		Төлөвлөгөөний зам 1	44000	1	44000	
	Урвалын усны		Урвалын ус MNS 01-49-2013	10000	5	50000	
	Урвалын усны		Урвалын ус MNS 01-49-2013	12500	5	62500	
Урвалын усны	Урвалын усны	Итамы pH, галогенит, P2O5, K2O, Барилгын бүрэлдэвэр	pH	3500	5	17500	
	Урвалын усны		галогенит буюу Cl	8000	5	40000	
	Урвалын усны		нар гуагил, хос, хром, цайр, мөнгө, хэдэн	3000	5	15000	
	Урвалын усны		нар гуагил, хос, хром, цайр, мөнгө, хэдэн	MNS 5000-2013	45000	3	135000
	Урвалын усны		нар гуагил, хос, хром, цайр, мөнгө, хэдэн	MNS 5000-2013	30000	2	60000
Нийт урс						607000	

Хавсралт баталгаажуулсан:

УЦ/УОШ Төвийн  
 БОШЛ-ын эрхлэгч  
  
 /М.Аулүл/

Утас: 70363983  
 96862233

"Хандгайт гол" ХХК-ийн  
 Байгаль орчны менежер  
  
 /Б.Батчимор/

Утас: 91113625

Дээжний төлбөрийн баримт

УБЕХ мөнгө №:  
 Статистийн тав газар зааварснаар  
 УБЕХ-ны даргын 1986 оны 6-р сарын  
 3/205 тоот тушаалаар батлав.

Төлбөрийн даалгавар № **882**

**2025** он **08** сар **28** өдөр

Төлөгч	Хандгайт гол ХХК	Дансны дугаар		Дүн
		Дебет	Кредит	
Банк	Худалдаа хөгжлийн банк	960004000470042272		802,000.00
Хүлээн авагч	Сэлэнгэ УЦУОШТөв			
Банк	Төрийн сан	530090100130013013		
(Найман зуун хоёр мянган төгрөг 00 мөнгө)				... хэнгийн хувийн торгууль ... төг ... мөн
(мөнгөн дүн үсгээр)				
Төлбөрийн зориулалт: (Барааны болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн нэр)				
Байгаль орчны хяналт шинжилгээ төлбөр Хандгайт гол				Гүйлгээний утга
Дагалдах баримтын дугаар №				

ХАНДГАЙТ ГОЛ ХХК  
тамга

Дарга \_\_\_\_\_  
 Нягтлан бодогч \_\_\_\_\_

Банкинд гүйлгээ хийсэн  
 ... 2025-08 сар 28 өдөр  
 (тэмдэг, гарын үсэг)

УБЕХ мөнгө №:  
 Статистийн тав газар зааварснаар  
 УБЕХ-ны даргын 1986 оны 6-р сарын  
 3/205 тоот тушаалаар батлав.

Төлбөрийн даалгавар № **883**

**2025** он **08** сар **28** өдөр

Төлөгч	Хандгайт гол ХХК	Дансны дугаар		Дүн
		Дебет	Кредит	
Банк	Худалдаа хөгжлийн банк	960004000470042272		135,000.00
Хүлээн авагч	БОХЗТ Лаборатори			
Банк	Төрийн сан	980090100900013013		
(Нэг зуун гучин таван мянган төгрөг 00 мөнгө)				... хэнгийн хувийн торгууль ... төг ... мөн
(мөнгөн дүн үсгээр)				
Төлбөрийн зориулалт: (Барааны болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн нэр)				
Байгаль орчны хяналт шинжилгээний төлбөр Хандгайт гол				Гүйлгээний утга
Дагалдах баримтын дугаар №				

ХАНДГАЙТ ГОЛ ХХК  
тамга

Дарга \_\_\_\_\_  
 Нягтлан бодогч \_\_\_\_\_

Банкинд гүйлгээ хийсэн  
 ... 2025-08 сар 28 өдөр  
 (тэмдэг, гарын үсэг)

## Бүлэг 10. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга ХЭМЖЭЭ

Хандгайт гол ХХК-ийн хувьд 2025 онд сум орон нутагт 27170 000 төгрөгийн хандив тусламж үзүүлсэн байна.

### Хүснэгт 9. Өгсөн хандив тусламжийн мэдээлэл

Нийгмийн хариуцлагын гэрээний заалт		2025 он	
1	Улсын баяр наадам	3,000,000.00	
2	Хүүхдийн баяр	600,000.00	
3	Ахмадын баяр	1,000,000.00	
4	Цагаан сарын арга хэмжээ	2,000,000.00	
5	ТТДС-д оюутан сургах	Ирмүүн /IT инженер/	3,430,000.00
		Нарантуул /ХХҮҮТ-2/	2,140,000.00
7	Хүнс , хүнсний ногоо худалдан авалт	-	
	Мах, махан бүтээгдэхүүн худалдан авалт	21,787,950.00	
8	Ерөө сумын малчдад үнд ахуйн зориулалттай гүний 2 ширхэг худаг гаргаж, гүний худгийн барилга барьж хүлээлгэж өгсөн	10 000 000	
	Агуйтын аманд гарсан ой хээрийн түймэрт 15 хүний бүрэлдэхүүнтэй 5 хоног ажилласан.	5000 000	
	Нийт	27170 000	

### Зураг 48. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил

Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хандгайт гол” ХХК, “Улаан Овоо Түшиг Майнинг” ХХК-ийн нийлсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй баг Ерөө сумын “Агуйтын ам” байршилд гарсан 60 га талбайд гарсан гал түймэр унтраах ажилд 5 хоногийн хугацаанд ажилласан.



#### 1. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил



### Зураг 49. Малчдын худгийн байр барьсан байдал



Иргэн Ерөөлмаа хүсэлтээр шатаж байсан бууцыг тарааж өгсөн





## Бүлэг 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Уурхайн хэмжээнд 30 гаруй уул уурхай үйл ажиллагаа эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, байгаль орчны журмуудыг боловсруулан батлуулж, мөрдөж ажиллаж байна. Хавар хачигны вакцин Ерөө сумын эрүүл мэндийн төвөөр хийлгэсэн. Байгаль орчны мэргэжилтэн Б.Батчимэг ажиллаж байна. Бүх ажилчдын өвөл, зуны хувцас болон хамгаалах малгай, нүдний шилээр хангаж ажиллаж байна. Сумын 100”-н жилийн ойн баяр наадмын Сагсан бөмбөг, Хөл бөмбөгийн тэмцээнд багаараа оролцсон. Дархан хотын нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан шинжилгээнд хамруулсан. Ерөө сумтай хог хаягдлын гэрээ байгуулан сар бүр тээвэрлэж, хогний төлбөрийг төлж байна. Сойл инженеринг ХХК-иар 300 тм өрөмдүүлсэн. Ерөө сумын төвд ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулж ажилласан. Нийт 90 орчим хүн анкет бөглөсөн.

### Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Уурхайн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамарсан цар хүрээ	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэгжийн үнэлгээ /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Тайлбар	Хэрэгжүүлсэн хувь
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдсөн.	ЭМААБО хэлтэс	-	-	-	-	Байгаль орчны дотоод журам гаргаж мөрдөж ажиллаж байна.	100%
Ажилчдыг Хачигны эсрэг вакцинд хамруулах	Уурхайн ажилчид	Удаа	1		340 000	Хавар хачигны вакцин Ерөө сумын эрүүл мэндийн төвөөр хийлгэсэн	100%
Уурхайгаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн стандартын дагуу хийх	ЭМААБО хэлтэс	-	-	-	-	Байгаль орчны мэргэжилтэн Б.Батчимэг ажиллаж байна.	100%

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАНДГАЙТГОЛ ХХК-ИЙН  
MV-021595 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ БАЯНГОЛЫН ЭХ  
ХӨНДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ**

2025 он

**2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

<b>зорилгоор байгаль орчны мэргэжилтэн авч ажиллуулна.</b>							
<b>Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл болон болзошгүй галын ажилгүй ажиллагааны багаж хэрэгслээр хангана.</b>	ЭМААБО хэлтэс	-	-	-	ХАБ-ын зардалд орсон	Бүх ажилчдын өвөл, зуны хувцас болон хамгаалах малгай, нүдний шилээр хангаж ажиллаж байна.	100%
<b>Сумаас зохион байгуулж буй урлаг, спортын арга хэмжээг дэмжиж ажиллах</b>	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	-				Сум орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна	100%
<b>Нийт ажилчидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан</b>	Уурхайн ажилчид	хүн	35	223.0	7805.0	Дархан хотын нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан шинжилгээнд хамруулсан.	100 %
<b>Ерөө сумтай хог хаягдлын гэрээ байгуулах</b>	Санхүүгийн хэлтэс	-	-	-	Хог хаягдлын зардалд орсон	Ерөө сумтай хог хаягдлын гэрээ байгуулан сар бүр тээвэрлэж, хогний төлбөрийг төлж байна.	100%
<b>Байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан хийлгэх</b>					9000.0	Эко-акурэси ХХК-тай гэрээ байгуулан тайлан боловсруулсан.	100%
<b>Газрын төлбөр төлөх</b>						Газрын төлбөрийн төлсөн.	100%
<b>Нийт</b>		<b>91 512 мян.төг</b>					<b>100 хувь</b>

**Зураг 50. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны санамж болон тээвэрлэлтийн хяналт шалгалт**



Тээвэр хийх үеийн "Аюулгүй ажиллагааны зааварчилгаа", замын усалгаа хийх үеийн хяналт шалгалт хийсэн.



ХАБЭА-н самбарын шинэчлэлт хийж, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх санамж байрлуулав.

**Ажилчид өглөө бүр Эмчийн үзлэг, нарядны дараа гимнастик хийж ажилдаа гарч байна.**



### Зураг 51. Ажилчдын эмнэлгийн үзлэгт хамруулсан байдал



Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 32 ажилтан орсон.  
Үүнээс: А ээлжний - 19 ажилтан  
Б ээлжний – 13 ажилтан хамрагдсан.

- А ээлжний үзлэгт орсон хүмүүсийн материалыг эжсел программ дээр олон улсын оношын кодоор бүртгэл хийсэн. Одоогоор Б ээлжний үзлэгт орсон материалууд ирээгүй байна.
- Кемпийн гадаах хогийг кемп туслахуудаар цэвэршүүлсэн.



**Зураг 52. Ерөө сумын төвд ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулсан.**



Зураг 53. Хачигны вакцин хийлгэсэн байдал



## Бүлэг 12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

2025 оны 09-р сарын 23-ны сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд уурхайн үйл ажиллагааны танилцуулгыг хийсэн.

### Дүгнэлт

“Хандгайтгол” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Баянгол төмрийн хүдрийн ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсрууллаа.

### Хүснэгт 11. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн зардлын нэгтгэл

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулагдсан нийт зардал мян.төг
		2025
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	31060.0
2	Нөхөн сэргээлт	-
3	Тэрбум мод	5800.0
4	Нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговор	-
5	Осол эрсдэл, химийн бодисын менежментийн төлөвлөгөөний биелэлт	64526.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	6408.0
7	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	500.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	<b>22445</b>
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2978.0
10	Аймаг нийслэлийн засаг даргын шаардлагаар хийсэн арга хэмжээний зардал	<b>27170.0</b>
<b>Дүн</b>		<b>154887.0</b>

Хандгайтгол ХХК нь 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд нийт 154887.0 мян.төг зарцуулсан.

## **Хавсралт 1. Усны газар ус ашиглуулах дүгнэлт**



# УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 09 -р  
сарын 19 -ны өдөр

Дугаар Е-2507-000135

Улаанбаатар хот Утас:

265528, 265578

## 1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Хандгайтгол ХХК

Улсын бүртгэлийн дугаар:

Регистрийн дугаар: 2059681

Захирал: Эрдэмбаяр

Холбоо барих дугаар: 88880748

Факс :

И-мэйл хаяг :

## 2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: "Баянголын" төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах төсөл

Байршил: Сэлэнгэ, Ерөө, 2-р баг, Буурагчин

Харьяалагдах сав газар: Хараа голын сав газар

Хамаарах салбар: Уул уурхай

Төслийн дэлгэрэнгүй: Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ийн MV-021595 тусгай зөвшөөрөлтэй "Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн орд"-ыг ил аргаар ашиглах төсөл нь Улаанбаатар хотоос хойш 230 км, Дархан хотоос зүүн хойш 70км, Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос зүүн урагш 90 км-т оршино. 2025 онд 1573.4 мян.тнн хөрс хуулж, 736.2 мян.тнн хүдэр элс олборлож, 774.0 мян.тнн хүдэр элс боловсруулж, 422.1 мян.тнн төмөр гарган авахаар төлөвлөсөн.

## 3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Хандгайтгол

## 4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
12	2 ээлжээр	300	150	8

## 5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	106.0	хоногт 1 хүн	2025 оны уулын ажлын төлөвлөгөө маягт 12-т нийт 106 хүн, 270 хоног ажиллахаар төлөвлөсөн.
Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	100000.0	м2	2025 оны уулын ажлын төлөвлөгөө маягт 10-т нийт 10 га талбайд дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. Нөхөн сэргээлтэд ашиглах усыг шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана.
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	110000.0	м2	Төслийн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд нийт 110000 м2 зам, талбайн тоосжилтыг 90 удаа усална гэсэн.
Уурхайд шүүрэлтээр орж ирэх усны хэмжээ	61.0	м3	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт 2024 онд хийсэн "Баян голын эх хөндий" төмрийн хүдрийн ордын гидрогеологийн нөхцөлийн судалгааны үр дүнгийн тайланд уурхайд шүүрэн орж ирэх усны хэмжээг 61 м3/хон гэсэн.
Өрөмдлөг тэсэлгээний ажилд шаардагдах усны хэмжээ	776.0	100.0 тууш.метр	2025 оны уулын ажлын төлөвлөгөө маягт 9.1-т 77.6 мян.тууш.м өрөмдлөг хийхээр төлөвлөсөн.

## 6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Унд ахуй	3.0	259.2	Усны газрын 2021 оны 09-р сарын 03-ны өдрийн 140 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах унд, ахуйн 40.5 м3/хон усыг өөрийн эзэмшлийн 2.51л/сек буюу 216.86 м3/хон ундаргатай худгаас, зам талбайн тоос дарах, өрөмдлөгийн ажил, биологийн нөхөн сэргээлтэд шаардагдах 541.1м3/хон усыг 1955.8 м3/хон шүүрлийн уснаас хангахад усны ашиглах боломжит нөөц хүрэлцээтэй гэсэн.
Шүүрлийн ус	Усалгаанд	0.7061	61.00704	2024 онд Сойл инженеринг ХХК-иар ордын гидрогеологийн хайгуул судалгааг хийлгэж тайлан боловсруулсан. Тайланд уурхайд орж ирэх шүүрлийн усны хэмжээг 70-130 м түвшинд 3 цэгт хийсэн ба төслийн 1-р жилд 61 м3/хон, 2-р жилд 49.79м3/хон ус шүүрүүлнэ гэсэн.

## 7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ :

Холбоо барих :

Нэмэлт мэдээлэл:

Эм И Си Эс Зэт Би ХХК

91113625

Захирал

## 8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
Гүний худаг	3.0	Тоолууржуулсан, мод барилгатай.

## 9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
	ус нөөцлөх сав	10	30
	ус хуримтлуулах усан сан	200	75

## 10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлэх, биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй болохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
- Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Голын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх;
- Хаягдлын сангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах;
- Усны эх үүсвэр өөрчлөгдсөн тохиолдолд ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлтийг шинэчлэн гаргуулахыг анхаарах;
- Усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, шинэ технологи ашиглах, нөхөн сэлбэлтээр авах усны хэрэглээг бууруулах;

## 11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	106	хоногт 1 хүн	0.15	270.0	Хоног	4,293.00	0.00	4,293.00
Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	100000	м2	0.004	40.0	Удаа	16,000.00	16,000.00	0.00
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	110000	м2	0.002	90.0	Хоног	19,800.00	0.00	19,800.00
Уурхайд шүүрэлтээр орж ирэх усны хэмжээ	61	м3	1.0	270.0	Хоног	16,470.00	0.00	16,470.00
Өрөмдлөг тэсэлгээний ажилд шаардагдах усны хэмжээ	776	100.0 тууш.метр	10.0	1.0	Удаа	7,760.00	0.00	7,760.00

## 12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м <sup>3</sup>	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м <sup>3</sup> усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	4293.00	Газрын доорх ус	0.0	82.92	355,975.56	0.0	355,975.56
Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	0.00	Газрын доорх ус	0.0	69.10	0.00	0.0	0.00
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	19800.00	Газрын доорх ус	0.0	165.84	3,283,632.00	0.0	3,283,632.00
Уурхайд шүүрэлтээр орж ирэх усны хэмжээ	16470.00	Газрын доорх ус	0.0	580.44	9,559,846.80	0.0	9,559,846.80
Өрөмдлөг тэсэлгээний ажилд шаардагдах усны хэмжээ	7760.00	Газрын доорх ус	0.0	829.20	6,434,592.00	0.0	6,434,592.00
<b>Нийт</b>	<b>48,323.00</b>				<b>19,634,046.36</b>		<b>19,634,046.36</b>

## 13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Хурын усыг хуримтлуулах, ахуйн бохир усыг зохих стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж халдваргүйжүүлэн зам талбайн тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Шүүрлийн усыг зам, талбайн тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлт, мод усалгаанд эргүүлэн ашиглах;

## 14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Ус ашиглуулах дүгнэлтийн онцгой нөхцөлийг хангаж ажиллаагүй тохиолдолд дараа оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргахгүй болохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус ашиглах шугам хоолой бүрд тоолуур суурилуулж, баталгаажуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, шинэ технологи ашиглах, нөхөн сэлбэлтээр авах усны хэрэглээг бууруулах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны

байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;

- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;

**Боловсруулсан:**

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС

О.Оюунгэрэл

Боловсруулсан огноо:

2025.09.08



Байгууллагын нэр: **Усны газар**  
Газар хэлтэс: **Удирдлага**  
Албан тушаал: **Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч**  
Овог нэр: **Эзнэмъядар Батбаяр**  
Зурсан огноо: **2025.09.19 16:44:02**

## **Хавсралт 2. Хараа-Ерөө голын сав газрын ус ашиглах гэрээ**



Батлав:  
Хараа-Ерөө голын сав газрын  
Захиргааны дарга  
.....  
Ө. Ариунбаатар

2025 оны 09 сарын 30-ний өдөр



Батлав:  
"Хандгайт гол" ХХК- ний  
Гүйцэтгэх захирал  
.....  
ХХК ..... Н.Эрдэмбаяр

Дархан-Уул аймаг

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 30

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29-р зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн E-2507-000135 тоот ус ашиглуулах дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас олгосон 2025 оны 09 сарын 30-ний өдрийн A/62 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Хараа-Ерөө голын сав газрын захиргааны мэргэжилтэн Лхагвасүрэн овогтой Насанзул, ус ашиглагчийг төлөөлж Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Буурагчин 2-р багийн нутагт орших "Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн орд" 543.33 га талбайд ашигт малтмал ашиглалтын MV-021595 дугаартай тусгай зөвшөөрөлтэй, 1311003083 улсын бүртгэлийн дугаартай, 2059681 тоот регистрийн дугаартай төмрийн хүдрийн ордыг ил аргаар олборлон хуурай соронзон аргаар нунтаглан баяжуулах "Хандгайт гол" ХХК-ийн уул уурхай хариуцсан захирал Г.Нэмэхбаяр нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2025 оны 09 сарын 29-ний өдрөөс 2025 оны 12 сарын 30-ний өдөр хүртэл хугацаатайгаар байгуулав.

1.2. Гэрээг монгол хэлээр 2% үйлдэж талуудад нэг хувь хадгалагдах бөгөөд аль ч хувь нь хуулийн хүчинтэй баримт мөн.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй зүйлийг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2025 онд 1573,4 мянган тонн хөрс хуулж, 736,2 мянган тонн хүдэр элс олборлож, 774,0 мянган тонн хүдэр элс боловсруулж, 422,1 мянган тонн төмөр гарган авахаар төлөвлөсөн байна.

**2.1. Ус ашиглах зориулалт:** Хүн ам, үйлдвэрийн хэрэгцээ, ногоон байгууламжийн усалгаа, зам талбайн усалгаанд усны нөөцийг ашиглана.

**2.2. Нийт ашиглах усны хэмжээ:** 64,323,00 м<sup>3</sup>/жил Үүнээс: Үйлдвэрлэх боловсруулах бүтээгдэхүүнд зарцуулах хэмжээг холбогдох хууль, журам, норм стандартын дагуу тооцоход: 106 хүн \* 150 л/хон х 270хон = 4293.00 м<sup>3</sup>/жил – Ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах усны хэмжээ

776 т.м \* 10м<sup>3</sup> = 7,760 м<sup>3</sup>/жил – Уурхайн өрөмдлөгт ашиглах ус,

110,000 м<sup>2</sup> \* 2.0 л/м<sup>2</sup> \* 210 хон = 19,800.00 м<sup>3</sup>/жил - Зам усалгаанд ашиглах ус,

100,000 м<sup>3</sup>/жил \* 0.004 \* 40 удаа = 16,000.00 м<sup>3</sup>/жил – Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ

61 м<sup>3</sup>/хон \* 270 хон = 16,470.00 м<sup>3</sup>/жил- Шүүрэн орж ирэх усны хэмжээ.

**2.3. Усны чанар, найрлага:** Унд ахуйн болон үйлдвэрийн технологийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг Сав газрын захиргаанд ирүүлнэ.

**2.4. Усны эх үүсвэрийн байршил:** Унд ахуй-Усны газрын 2021.09.03-ны өдрийн "Эм И Си Эс Зэт Би" ХХК-д гаргаж хүргүүлсэн "Хандгайт гол" ХХК-ний "Баянголын эх хөндий" нэртэй MV-021595 дугаартай тусгай зөвшөөрөлтэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар олборлох төслийн унд ахуйн 40.5 м<sup>3</sup>/хон усыг өөрийн эзэмшлийн 2.51 л/сек буюу 216.86 м<sup>3</sup>/хон ундаргатай худгаас, зам талбайн тоосжилт дарах, өрөмдлөгийн ажил, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах 541.1

м<sup>3</sup>/хон усыг шүүрлийн уснаас авч ашиглахад ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэсэн байна.

**2.5 Усны барилга байгууламж:** Худгаас 10 мм хоолойгоор 30м урт дамжуулах шугамаар дамжин боловсон бие засах газар болон угаалгын хэсэг рүү 5 тн нөөцийн саванд хуримтлуулдаг. Цэвэр усны сангийн эзлэхүүн 9.750 м<sup>3</sup> байна.

**2.6. Дамжуулах байгууламж:** Уурхайн ухлагаас усан сан хүртэл усыг дамжуулах ган хоолойн урт 75 м, голч 200мм.

**2.7. Хаягдал усны хэмжээ цэвэрлэгээний арга:** Ахуйн хаягдал бохир усыг бага оврын Топ-аэро 32 маркийн цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлнэ.

**2.8. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл.** "Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн орд"-ыг ил аргаар ашиглах төсөл "Хандгайт гол" ХХК-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2021 онд "Эм И Си Эс Зэт Би" ХХК хийж гүйцэтгэсэн

**2.9. Худаг өргөлтийн станцууд, Усны тоолуур насосын хүчин чадал:**

Унд ахуйн худаг 106°59'18.25"E, 49°38'49.32"N. Ундарга-0.5 л/сек насос QG10052 Тоолуур Гран система.

**2.10.Онцгой нөхцөл:**

- Шар усны болон гэнэтийн үерийн ус уурхайн ухлага буюу ашиглалт явуулж буй талбай болон хаягдлын санд орохоос сэргийлэн зохих арга хэмжээ авах;
- Хаягдлын сангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах.
- Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны өдрийн дотор Хараа-Ерөө голын сав газарт ирүүлэх;
- Усны тухай хуулийн 30.1.3-д заасны дагуу Хаягдал усны дүгнэлт гаргуулж үйлдвэрлэлийн явцад гарсан хаягдал усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж зайлуулах, усны нөөц горим, чанарын мэдээ болон ус ашиглалтын тайланг сав газрын захиргаанд ирүүлэх;

**2.11. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:**

"Усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээг шинэчлэн батлах" тухай Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Хараа голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах" тухай Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтын итгэлцүүр, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх" тухай Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоолд заасан хувь хэмжээг ашиглан тооцвол:

*Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усны нөөц ашигласны төлбөр;*

1м<sup>3</sup> газрын доорх ус ашигласан төлбөр: 2764.0 төг/м<sup>3</sup> x 0.15 x 0.2 = 82.92 төг/м<sup>3</sup>

2'764.0 төг/м<sup>3</sup> – Засгийн газрын 2013 оны 302-р тогтоолоор Хараа голын сав газарт сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

15% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 10-д заасан ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь;

0.2 - Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын Хараа голын сав газарт бусад, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр;

**4,293.00 м<sup>3</sup>/жил x 82.92 төг/м<sup>3</sup> = 355,975.56 төг**

*Уул уурхайн үйлдвэрлэлд шавхан зайлуулах усны төлбөр:*

1м<sup>3</sup> усны нөөц ашигласны төлбөр: 2'764.0 төг/м<sup>3</sup> x 0.15 x 1.4 =580.44 төг/м<sup>3</sup>

2'764.0 төг/м<sup>3</sup> – Хараа-Ерөө голын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд экологи эдийн засгийн суурь үнэлгээ.

(15%) – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7в-д заасан хувь, хэмжээ.

1,4 – Газрын доорх ус шавхан зайлуулах нөхцөлд тооцох итгэлцүүр.

$$16,470.00 \text{ м}^3/\text{жил} \times 580.44 \text{ м}^3/\text{төг} = 9,559,846.80 \text{ төг}$$

*Зам талбайн тоосжилт дарахад гадаргын ус ашигласны төлбөр:*

$$1 \text{ м}^3 \text{ усны нөөц ашигласны төлбөр: } 2764 \text{ төг/м}^3 \times 0.20\% \times 0.3 = 165.84 \text{ төг/м}^3$$

2764 төг/м<sup>3</sup> – Хараа-Ерөө голын сав газарт гадаргын ус ашигласан нөхцөлд экологи эдийн засгийн суурь үнэлгээ

(20%) – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 9-д заасан хувь, хэмжээ

0,3 – Авто зам засварт гадаргын ус ашигласан нөхцөлд тооцох итгэлцүүр

$$19,800.00 \text{ м}^3/\text{жил} \times 165.84 \text{ төг/м}^3 = 3,283,632.00 \text{ төгрөг}$$

*Өрөмдлөгийн ажилд ашиглах газрын доорх усны төлбөр:*

$$1 \text{ м}^3 \text{ гадаргын ус ашигласан төлбөр: } 2764 \text{ төг/м}^3 \times 1.5 \times 0.20 = 829.2 \text{ төг/м}^3$$

2764 төг/м<sup>3</sup> – Хараа голын сав дахь газар доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

1,5 - Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

0,20 – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын дагуу усны нөөц ашигласны төлбөрийн 7.4г-д заасан хувь, хэмжээ

$$7,760.00 \text{ м}^3/\text{жил} \times 829.20 \text{ төг/м}^3 = 6,434,592.00 \text{ төгрөг}$$

$$\text{Нийт төлбөр: } 355,975.56 \text{ төг} + 9,559,846.80 \text{ төг} + 3,283,632.00 \text{ төгрөг} + 6,434,592.00 \text{ төгрөг} = 19,634,046.36$$

*(Арван өсөн сая зургаан зуун гучин дөрвөн мянга дөчин зургаан төгрөг)*

**Төлбөр төлөлт:** Усны нөөц ашигласны төлбөрийг Сэлэнгэ төрийн сан банкны 100130000944 тоот дансанд 2025 оны 11 сарын 30-ний дотор бүрэн хийж барагдуулсан байна.

Ус ашиглалтын мэдээ тайлан, болон усны нөөц ашигласны төлбөрийн үнийг орон нутгийн төсөвт төлсөн хагас, бүтэн жилээр төвлөрүүлж Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд гаргаж өгнө.

Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу төлбөрийг шатлан өсгөхийг анхаарч ус ашиглалтын календарьчилсан төлөвлөгөө графикийг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.

#### **Гурав. Талуудын эрх, үүрэг**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 17-р зүйл, 26, 27, 28, 29 30, 31-р зүйлд заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.

#### **Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг, дарж баталгаажсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг талууд 2025 оны 12 сарын 10-ний дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.


4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:**

**Ус ашиглуулагчийг төлөөлж:**

ХЕГСГЗ-ны мэргэжилтэн

.....Л.Насанзул

Дархан-Уул аймаг, Дархан сумын 14 баг  
Монгол банкны 3 давхарт Хараа-Ерөө  
голын сав газрын захиргаа Утас: 70373171

**Ус ашиглагчийг төлөөлж:**

"Хандгайт гол" ХХК-ийн уул уурхай  
хариуцсан захирал

.....Г.Нэмэхбаяр

**ХАЯГ:**

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 8-р  
Хороо Бага тойрог Сүхбаатарын  
талбай Сити Тауэр 13 давхар  
Утас: 88880748, 88073007

### **Хавсралт 3. Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газартай байгуулсан гэрээ**

БАТЛАВ:  
СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
УЦУОШТӨВИЙН ДАРГА

...../О.ГАНБАТ/

БАТЛАВ:  
ХАНДГАЙТ ГОЛ ХХК-НИЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

...../Ц.МӨНГӨН-ЭРДЭНЭ/

**Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ  
хийх талаар байгуулсан гэрээ**

№ 55/.....

2025-08-08

#### **Нэг. Гэрээний зорилго**

- 1.1 Үйлдвэр, албан байгууллага, аж ахуйн нэгжийн болон хувийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчинд гарч болох хими, физик, биологийн хувьсал өөрчлөлт, агаар, усан мандал, хөрсний бохирдолтын түвшинд байгаль орчны ажиглалт, судалгаа, хяналт шинжилгээ хийж, дүгнэлт өгөх.
- 1.2 Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2, 3-р заалт, 11-р зүйлийн 2-р заалтыг аж ахуйн нэгж дээр хэрэгжүүлэн биелүүлэхэд оршино.
- 1.3 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй тухайн аж ахуйн нэгжийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлыг гүйцэтгэх.

#### **Хоёр. Ерөнхий зүйл**

- 2.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх ажлыг Аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төв /регистрийн дугаар 9057196/-ийг төлөөлж БОШЛ-ын ерөнхий инженер М.Аягүл нөгөө талаас "Хандгайт гол" ХХК, /регистрийн дугаар 2059681/-ний байгаль орчны мэргэжилтэн Б.Батчимэг нар хариуцан энэхүү гэрээг хийв.

#### **Гурав. Аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн хүлээх үүрэг**

- 3.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан ба ерөнхий үнэлгээнд заасан хөтөлбөрт ажлын дагуу 2025 оны 8 сард агаар, ус, хөрсний дээжийг авч химийн шинжилгээ хийж, үр дүн болон дүгнэлтийг хугацаанд нь гаргаж өгнө.
- 3.2 Байгаль орчны хяналт шинжилгээ хийх багаж төхөөрөмж, шаардагдах урвалж бодис, материалаар ханган ажиллах.
- 3.3 Байгаль орчны хяналт шинжилгээний дүн мэдээлэл, дүгнэлтийг тухай бүр нь хариуцагч байгууллагад гаргаж өгөх.

**Дөрөв. "Хандгайт гол" ХХК-ний хүлээх үүрэг**


- 4.1 Байгаль орчны хяналт шинжилгээ хийж гүйцэтгэсэн ажлын үнэлгээг байгаль орчны яамнаас тогтоосон тарифт үнэлгээний дагуу 802000/найман зуун хоёр мянган/ төгрөгийг Сэлэнгэ аймаг УЦУОШТөвийн Төрийн сангийн 100130013015 тоот дансанд шилжүүлэн тооцоо хийж дуусгасан байх.
- 4.2 Байгаль орчны хяналт шинжилгээ хийж гүйцэтгэсэн ажлын үнэлгээг байгаль орчны яамнаас тогтоосон тарифт үнэлгээний дагуу 135000/нэг зуун гучин таван мянган/ төгрөгийг Улаанбаатар хотын БОХЗТЛ-ийн Төрийн сангийн 100900013017 тоот дансанд шилжүүлэн тооцоо хийж дуусгасан байх.
- 4.3 Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвөөс очиж дээж авах хүний томилолт, байр, хоол, 2 хүн 1 өдөр 60000 төгрөг, шатахууны зардал 52 литр төгрөгийг урьдчилан байрлуулсан байх.

**Тав. Хамтран хүлээх үүрэг**

- 5.1 Хоёр тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар нэг нэгэндээ харилцан шаардлага тавина.
- 5.2 Гэрээ нь байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан ба ерөнхий үнэлгээ хүчин төгөлдөр байх хугацаанд мөрдөгдөж байх болно.
- 5.3 Гэрээний талаар маргаантай асуудал гарвал аль болох хэлэлцэн тохирох бодлого баримтлах бөгөөд харилцан, тохирч, шийдвэрлэж чадахгүй бол төрийн дээд шатны байгууллагад хандана.
- 5.4 Байгаль орчны төлөв байдлын гэрээний дагуу хийгдсэн ажлыг 2026 оны 12-р сарын 25-нд харилцан дүгнэж тайланг дарга, захиралуудад танилцуулах

**Гэрээ хийсэн:**


Сэлэнгэ аймгийн  
УЦУОШТөвийн  
БОШЛ-ын эрхлэгч

  
/М.Аягүл/

Утас: 70363983  
96862233

"Хандгайт гол" ХХК-ний

байгаль орчны мэргэжилтэн

  
/Б.Батчимэг/

Утас: 91113625

"Хандгайт гол" ХХК-д хийгдэх Байгаль орчны шинжилгээ хийх төлөвлөгөө

Дээжний төрөл	Цэгүүд	Хэмжилтийн үзүүлэлтүүд	Хийгдэх үзүүлэлтүүд	Нэг шинжилгээний төлбөр	
агаарын дээж	ажилчдын кемп баяжуулах үйлдвэр ил уурхай	SO2, NO2, PM10, дуу чимээ	SO2, NO2	12000 12500	5 5
	хавдлын өвслөг				
	тээвэрлэлтийн зам 1		PM10 зөвхөн баяжуулах дээр тавина 24 цагаар	30000	1
	тээвэрлэлтийн зам 2				
усны дээж	цавчмаг байгууллагын цэвэрлэгдсэн бохир ус	Ерөнхий химийн шинжилгээ	Худгийн ус MNS 900-2018 Хаягдал ус MNS4943-2015	65000 97000	1 2
	Бэлтгэл уурхайн гүүрний дээд хэсэг				
	Баянгол уурхайн гүүрний доод хэсэг				
	Баянгол Ерөө галтой нийлэх хэсэг				
хөрсний ерөнхий химий	көмт	Ялзмаг, рН, давсжилт, P2O5, K2O, Ширхэгийн бүрэлдэхүүн	Ялзмаг	10000	5
	Уурхай			12500	5
	баяжуулах үйлдвэр		рН	3500	5
	хавдлын өвслөг		P2O5	8000	5
	тэсрэх бодисын агуулах		Давсжилт буюу EC	3500	5
	көмт	хар тугалга, зэс, хром, цайр, никель, кадми			
хөрсний хүнд металл	Уурхай	хар тугалга, зэс, хром, цайр, никель, кадми	MNS 5850-2019	45000	3
	баяжуулах үйлдвэр				
	хавдлын өвслөг				
	тэсрэх бодисын агуулах				
засварын төв	хар тугалга, зэс, хром, цайр, никель, кадми				
ШТС	нефтийн бүтээгдэхүүн				
		нефтийн бүтээгдэхүүн	MNS 6838-2020	50000	2
					937000

Нийт үнэ

Хавсралт баталгаажуулсан:

УЦУОШТӨВИЙН  
БОШЛ-ЫН ЭРХЛЭГ

  
/М.Аягул/

Утас: 70363983  
96862233

"Хандгайт гол" ХХК-ний  
байгаль орчны мэргэжилтэн

  
/ Б.Батчимэг /

Утас: 91113625

## **Хавсралт 4. Уурхайн үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг журмууд**

Баримт бичгийн төрөл, дугаар	Журам
Үйлчлэх хүрээ	Хандгайтгол ХХК, түүний хараат болон охин, зэргэлдээх компани, гэрээт компаниуд
Хариуцах нэгж	ЭМААБО хэлтэс
Нууцын зэрэглэл	Нууц биш
Танилцсан	Бүх хэлтэс болон гэрээтүүдэд

## АСГАРАЛТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

### Баталгаажуулалт

	Нэр албан тушаал	Гарын үсэг	Огноо
Боловсруулсан:	Ганбаатар Чинзориг Бадамгарав Баярмандах		
Хянасан:	Ганбат Нэмэхбаяр Уул уурхай хариуцсан захирал		
Баталсан:	Нэмэхбаатар Эрдэмбаяр Гүйцэтгэх захирал		

МН 021595

Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022  
 оны... сарын ...өдрийн ...тоот  
 тушаалын... хэвсрэлт

Баримт бичгийн төрөл, дугаар	Журам
Үйлчлэх хүрээ	Энгис ХХК, түүний хараат болон охин, зэргэлдээх компани, гэрээт компанууд
Хариуцах нэгж	ЭМААБО хэлтэс
Нууцны зэрэглэл	Нууц биш
Танилцсан	Бүх хэлтэс болон гэрээтүүдэд

**УУРХАЙН ХУУЛСАН ШИМТ ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ**

Баталгаажуулалт

	Нэр албан тушаал	Гарын дүсэг	Огноо
Боловсруулсан:	Батчимэг Батсайхан Байгаль орчны мэргэжилтэн		2022.06.02
Хянасан:	Нэмэхбаар Ганбат Ерөнхий инженер		2022.06.02
Баталсан:	Лхагвасүрэн Хандан Гүйцэтгэх захирал		2022.06.02



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022  
оны... сарын ...өдрийн ...тоот  
тушаалын...хавсралт

## УУРХАЙН ХУУЛСАН ШИМТ ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэсэл

- 1.1.Энгис ХХК -ийн уурхайн шимт хөрстэй ажиллах харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.2.Энэхүү журам нь "Энгис ХК-ийн уурхайн болон уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компани, туслалт гүйцэтгэгч компани, тэдгээрийн ажилтанд хамааран уйлчилнэ.

### УУРХАЙН ХУУЛСАН ШИМТ ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

- 1.3.Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг холбогдох дүрэм, журам, ажлын горим, зааврын дагуу шийдвэрлэнэ.
- 1.4 Шимт хөрсийг хуулах үйл ажиллагаанд MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томъёо, тодорхойлолт, MNS 5915:008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал, MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага, MNS 5918:2008 Эвдэрсэн газрын ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага, Шимт хөрс хуулах зөвшөөрлийн хуудас зэрэг холбогдох стандарт, хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

### Хоёр. Шимт хөрс, түүнтэй ажиллах

- 2.1. Уурхайлалт гэдэгт олборлох, хөрс хуулах, тээвэрлэх, барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэд бүтцийг байгуулах бүх үйл ажиллагааг хамруулан ойлгох бөгөөд шимт хөрсийг байгаль орчныг нөхөн сэргээх зориулалтаар дахин ашиглана.
- 2.2 Шимт хөрс гэдэг нь ургамал ургахад шаардагдах үржил шим, агрохими, механик бүрдэл бүхий нөхцлийг хангасан буюу энгийн сайжруулалт хийх боломжтой хөрсний өнгөн хэсэг бөгөөд энэ хэсгийг дахин боловсруулна.
- 2.3 Шимэрхэг хөрс гэдэг нь ургамлын ургалт, төлжилтөнд хязгаарлагдмал хүрээнд таатай нөлөө үзүүлэхүйц физик, химийн шинж чанар бүхий уулын чулуулаг болно.
- 2.4 Хөрсний урьдчилсан үнэлгээ гэдэг нь үйл ажиллагаа явуулах талбайн шимт хөрсийг хуулахаас өмнө хөрсний чанарыг магадлан нөөцийг хэсэгчилэн тогтоох ажиллагаа бөгөөд уг үнэлгээгээр шимт болон шимэрхэг хөрс хуулах зузааныг тогтооно.
- 2.5 Шимт хөрс хуулалт нь нөхөн сэргээлтэд зориулан хөрсний бүрэлдэхүүн хэсгийг хадгалах зорилгоор хөрсний үржил шимт давхаргыг урьдчилсан үнэлгээнд заасан гүн хүртэл хуулах үйл ажиллагааг бөгөөд хэрэв үнэлгээ хийгдээгүй бол хуулах зузааныг уулын ажлын төлөвлөгөөнд заасан хэмжээгээр тооцож, авна.
- 2.6.Нөхөн сэргээлтэнд ашиглах зорилгоор хуулсан шимт хөрсийг заасан овоолго буюу агуулах талбайд хадгалах, шимт чанар, нөөцийг алдагдуулахгүйгээр хамгаалах арга хэмжээ авна.



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022  
оны... сарын ...өдрийн ...тоот  
тушаалын...хавсралт

2.7. Бороо, цас, ус, мөс, салхи, температурын өөрчлөлт, татах хүч зэрэг физик, химийн хүчин зүйлийн нөлөөгөөр эсхүл хөрс болон геологийн зүйлийг газрын гадаргын нэг цэгээс өөр нэг цэг рүү хөрсийг хамах, салгах буюу зайлуулах байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас газрын гадаргуу элэгдсэнд нөхөн сэргээлт хийнэ.

2.8. Шимт хөрсний овоолгын өндрийн хязгаар, эцсийн хэлбэрийн дээд болон хажуугийн налуу, шимт хөрс хуулах зузаан зэрэг уулын ажлын тоон үзүүлэлтийг шимт хөрсний параметр гэх бөгөөд тухайн жилд батлагдсан Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу уг ажлыг гүйцэтгэнэ.

2.9. Элэгдсэн газрын үржил шимийг сэргээх, хүрээлэн байгаа орчны нөхцөлийг сайжруулахад чиглүүдэж, нөхөн сэргээх зарга хэмжээг авна.

#### **Гурав. Шимт хөрс хуулах, төлөвлөх, бэлтгэл ажил**

3.1. Тухайн жилд уурхайн ажилтанд өртөж хуулагдах талбай, шимт хөрсний хэмжээ болон овоолго үүсгэн байрлуулах талбайн байршил, хэмжээг "Энгис" ХХК-ийн уулын ажлын төлөвлөгөөнд тусгана.

3.2. Уг төлөвлөгөөнд тухайн жилд олборлох шимэрхэг хөрсний хэмжээ болон байршуулах овоолгыг мөн адил төлөвлөнө.

3.3 Шимт хөрс хуулахаас өмнө талбайд цэвэр усны эх үүсвэр хөндөгдөх, ховордсон өвс, ургамал өртөх эсэхийг тогтоон шаардлагатай бол нөхөн сэргээлтийн талбайд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.4 Уурхайн ажилтанд өртөх талбайд Энгис ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээг хийж, шимт хөрс хуулах зузааны хэмжээг тогтооно. Говийн бүсэд шимт хөрснийг 0-40 см хүртэл гүн хуулахаар тогтооно. Шимт хөрст талбайд хөрсний тодорхой гүнүүдээс дээж авч шинжлүүдэн хөрсний үржил шим, механик бүрдлийг тодорхойлон шаардлагатай бол чанарын хэсэгчилсэн зураг гарган боловсруулж батлуулна.

#### **Дөрөв. Шимт хөрс хуулах, зөвшөөрөл олгох**

4.1 Энгис ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээ, уулын ажлын төлөвлөгөө, болон бусад төлөвлөлтийг үндэслэн шинээр газар хандах хөрс хуулах тохиолдол бүрт шимт хөрс хуулах зөвшөөрөл олгоно.

4.2 Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөндөгдөх талбайн хил хязгаар, өндрийн түвшинг уурхайн маркшейдэр инженер гадаслаж тэмдэглэнэ.

4.3. Хөрс хуулах явцад шимт хөрсний гүнд чанар муутай хөрсний материал орохоос ямагт сэргийлэх хэрэгтэй.

4.4. Хөрс хуулалтад өөрчлөлт гарах болсон тохиолдолд "Энгис" ХХК-ийн Байгаль орчны болон ашиглалтын инженерт ерөнхий мэдэгдэн мэргэжилтэн тухайн тушаалтнуудын шийдвэрээр хуулах гунийг өөрчилж болно.



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022  
оны... сарын ...өдрийн ...тоот  
тушвалын...хаасралт

4.5 Шимт хөрсийг хуулаат байрзүйн хувьд өндрөөс нам руу чaглэн явагдана.

4.6.Шимт хөрс хуулсан хэсэгт маркшейдерийн хэмжилт хийлгэж, хөндөгдсөн талбайн болон эзэлхүүний хэмжээг долоо хоногийн тайланд, хадгалах талбайд буусан шимт хөрсний хэмжээг сарын тайланд тус тус тусгана.

4.7.Хэрэв маркшейдерийн хэмжилтээр шимт хөрс хуулах гүнд хүрээгүй эсвэл хуулсан хөрсний эзэлхүүн дутуу байгаа тохиолдолд шимт хөрсийг дахин хуулуулж заасан хэмжээнд хүргэнэ.

4.8.Салхины хурд ихтэй, хэт их хуурайшилт ихтэй үед шимт хөрсийг аль болох хуулахгүй, тэвэрлэхгүй байхыг эрмэлзэх бөгөөд зайлшгүй хуулах, зөөх тохиолдолд шимт хөрсийг салхинд зөөгдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.9.Шимт хөрсийг өдрийн цагаар хуулна. Зайлшгүй шөнийн цагаар хуулах шаардлагатай нөхцлийг уурхайн төлөвлөлтийн инженер багласан тохиолдолд шимт хөрс хуулах ажил бүрт байгаль орчны мэргэжилтэн шене шимт хөрс хуулах зөвшөөрлийг олгоно.

4.10.Түр хугацаагаар байгуулах зам, усны хоолой зэрэгт шимт хөрсийг заавал овоолгод байршуулахгүйгээр салхины хаалт маягаар овоолж эргүүлэн ашиглаж болно.

4.11 Уурхайн ажилт болон тээлт хийхдээ шимт хөрсийг хугацаанаас нь эрт хуулахгүй байх. Хуулсан даруйд нөхөн сэргээлтэнд ашиглахыг чухалчилна.

#### **Тав. Шимт хөрснийг хадгалах**

5.1. Шимт хөрснийг зөвхөн нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглана.

5.2 Шимт хөрсний овоолгын зөвшөөрөгдөх хамгийн дээд өндөр нь 5 метр байгаа.

5.3.Овоолгыг хэлбэршүүлэхдээ хотгор гадаргуугийн талбайг багасгахын тулд шимт хөрсний овоолгын хажуугийн налууг 15 градус, дээд гадаргын налууг 5 градусаас ихгүйгээр тэгшилнэ.

5.4.Гурван жилээс дээш хугацаанд хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу хажууг хэлбэржуулж олон наст өвслөг ургамал тарина.


5.5.Шимт хөрсний хадгалалт, тордлогын бүртгэлийн тайланг жилд 2-оос доошгүй удаа хийнэ.

5.6.Шимт хөрсийг хуулсан даруйд төлөвлөгдсөн талбайруу зөөж хадгална.

5.7 Шимт хөрснийг овоолсон цагаас эхлүүдээд нөхөн сэргээлтэнд ашиглах хүртэл жил бүр чанарын болоод бохирдлын шинжилгээнд хамруулж, шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлэх ба газрын зураг дээр байршлийг нь тэмдэглэж мэдээллийн санд хадгална.

#### **Зургаа. Үүрэг хариуцлага**

6.1.Албан тушаалтан дор дурьдсан үүрэг, хариуцлага хүлээнэ.



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022  
оны... сарын ...өдрийн ...тоот  
тушаалын...хавсралт

6.1.1.ХАБЭАБО-ны хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн шимт хөрсийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих.

6.1.2"Энгис" ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн энэ журмын хэрэгжилтийг дүгнэх, шимт хөрс хамгаалах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, шимт хөрс хамгаалахад шаардлагатай тоног төхөөрөмж, тарих үрийн судалгааг хийж, захиалж бэлэн байлгах,

6.1.3. Энгис" ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн нь уг журмын хэрэгжилтэнд хяналт хийж зөрчлийг мэдээлэх, ариалах, шимт хөрсний хуулалт, овоолгын байдал, нөөц болон чанарын хяналт явуулах, шимт хөрстэй холбоотой мэдээллийн санг үүсгэж хариуцах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.4.Төлөвлөлтийн инженер нь тухайн жилийн уулын ажлын төлөвлөлтөнд шимт хөрсний хэмжээ, шимт хөрсний овоолго үүсгэх талбай, хуулалт хийгдэх хуваарийг гаргах, шимт хөрсний байршлын зураг боловсруулах, техникийн паспорт үйлддэг байх;

6.1.5.Уулын мастер нь шимт хөрс хуулах, овоолго үүсгэх, хэлбэржүүлэлт хийх ажилд хяналт тавих;

6.1.6. Уулын гэрээт ажил гүйцэтгэгчийн байгаль орчин харуцсан ажлтан нь шимт хөрсний хуулалт, овоолгын байдал, нөөц болон чанарт байнгын хяналт явуулах, шимт хөрс хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулан, зохион байгуулах;

6.1.7.Шимт хөрсний чанарыг доройтуулах үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлтээс өөр зориулалтаар ашиглах, шимт хөрс хуулах зөвшөөрөлгүйгээр хуулалт хийхэд хяналт тавих;

6.2.Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, "Энгис" ХХК-ий Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

#### **Долоо. Бусад**

7.1.Шимт хөрсний хадгалалт, хамгаалалтад бүртгэл, хяналт хийх зорилгоор дор дурдсан мэдээллийг тогтмол шинэчлэн мэдээллийн санд хадгална.

7.1.1.Шимт хөрсний овоолгын төлөвлөлт: (уулын ажлын төлөвлөгөөнд туссанаар)

7.1.2. Шимт хөрс хуулах, овоолго хийх хуваарь.

7.1.3.Шимт хөрс хуулсан талбайн хэмжээ, овоолгын байршлын зураг (ArcGIS).

7.1.4. Шимт хөрс хуулах зөвшөөрлийн хуудас.

7.1.5.Хамгаалалтын арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан.

7.1.6.Газарзүй мэдээллийн системд байрзүйн болон чанарын хэмжилтийн мэдээллийг 6 сарын давтамжтайгаар оруулж орон зай, цаг хугацааны мэдээг үүсгэнэ.

7.1.7 Шимт хөрс хадгалах байгаль орчны төлөвлөгөө зэрэг болно.



Энлис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022  
 оны... сарын ... өдрийн ... тоот  
 тушаалын... хавсралт

**Найм. Хавсралтууд**

Хавсралт-1. Шимт хөрс хуулах зөвшөөрөл.

❖ **Хүсэлт гаргагч бөглөнө:**

Хүсэлт гаргасан огноо:	Хүсэлт гаргасан хэлтэс/ Гэрээт компани:		
Хүсэлт гаргасан ажилтны овог нэр:			
тас:	Албан тушаал:		
Шимт хөрс хуулах байрлал:	Уурхай <input type="checkbox"/>	Хотхон <input type="checkbox"/>	Бусад <input type="checkbox"/>
Шимт хөрс хуулах байрлал /бичгээр/:			
Байрлалын талаарх нэмэлт тайлбар:			
Зори улалт:			
Шимт хөрс хуулах талбай:	а	г	2 м
Хуулагдах шимт хөрсний хэмжээ (м <sup>3</sup> ):	Байршуулах овоолгын дугаар:		
Байршуулах овоолгын талаарх нэмэлт тайлбар:			
Шимт хөрс хуулж эхлэх огноо:	Дуусах огноо:		
Хариуцах ажилтны овог нэр:			
Албан тушаал:	Холбоо барих утас:		

❖ **Байгаль орчны хэсэг бөглөнө:**

Газрын хэлбэр:	Тал газар <input type="checkbox"/>	Хонхор газар <input type="checkbox"/>	Гүвээ <input type="checkbox"/>	Бусад <input type="checkbox"/>
Унд, ахуйн болон бусад усны эх үүсвэрт ойр байгаа эсэх?			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Ховордсон амьтан ургамал өртөх эсэх?			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Бохирдол хязгаарлах арга хэмжээ авагдах шаардлагатай эсэх?			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тоосны эх үүсвэрийг багасгах шаардлагатай эсэх?			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Шимт хөрс хуулах гүн (см):	Шаардлагатай тохиолдолд хуулах гүн (см):			
Ажлын явцад байгаль орчны нөлөөллийг хянах талаар тэмдэглэл:				

**ENGIS** Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 сарын 05 өдрийн /14/ тоот тушаалын хавсралт

Баримт бичгийн төрөл, дугаар	Горим
Үйлчлэх хүрээ	Энгис ХХК, түүний хараат болон охин, тэргэлдэх компани, гэрээт компаниуд
Хариуцах нэгж	ЭМААБО хэлтэс
Нууцны зэрэглэл	Нууц биш
Танилцсан	Бүх хэлтэс болон гэрээтүүдэд

**ЭРҮҮЛ МЭНД АЮУЛГҮЙ  
 АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ УДИРТГАЛ  
 ЗААВАРЧИЛГАА**

Баталгаажуулалт

	Нэр албан тушаал	Гарын үсэг	Огноо
Боловсруулсан:	Анхбаяр Мөнхсайхан Аюулгүй Ажиллагааны мэргэжилтэн		2022.05.05
Хяндсан:	Мөнхбилэг Энх-Амгалан Ерөнхий инженер		
Баталсан:	Лхагвасүрэн Хандва Гүйцэтгэх захирал		

1

**ENGIS** Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 сарын 05 өдрийн 1/1 тоот тушаалын хавсралт

Баримт бичгийн төрөл, дугаар	Нэр томъёо
Үйлчлэх хүрээ	Энгис ХХК, түүний хараат болон охин, хэргэлдэх компани, гэрээт компаниуд
Харуцах нэгж	ЭМААБО хэлтэс
Нууцны зэрэглэл	Нууц бич
Танилцсан	Бүх хэлтэс болон гэрээтүүдэд

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Баталгаажуулалт


	Нэр албан тушаал	Тарын үсэг	Огноо
Боловсруулсан:	Анхбаяр Мөнхсайхан Аюулгүй Ажиллагааны мэргэжилтэн		2022.05.05
Хянасан:	Мөнхбилэг Энх-Амгалан Ерөнхий инженер		
Баталсан:	Лхагвасүрэн Хяндаа Гүйцэтгэх захирал		

 Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 сарын 05-өдрийн 14/2000т тушаалын.....хавсралт

Баримт бичгийн төрөл, дугаар	Журам
Үйлчлэх хүрээ	Энгис ХХК, түүний хараат болон охин, зэргэдээх компани, гэрээт компаниуд
Хариуцах нэгж	ЭМААБО хэлтэс
Нууцны зэрэглэл	Нууц бий
Танилцсан	Бүх хэлтэс болон гэрээтүүдэд

**УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН  
 ЖУРАМ**

Баталгаажуулалт

	Нэр албан тушаал	Гарын үсэг	Огноо
Боловсруулсан:	Анхбаяр Мөнхсайхан Аюулгүй Ажиллагааны мэргэжилтэн		2022.05.05
Хянасан:	Мөнхбилэг Эгэх-Амгалан Ерөнхий инженер		
Баталсан:	Лхагвасүрэн Хандва Гүйцэтгэх захирал		



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 сарын  
 05 өдрийн 4/11 тоот тушаалын хавсралт

Баримт бичгийн төрөл, дугаар	Журам
Үйлчлэх хүрээ	Энгис ХХК, түүний хараат болон охин, тэргэлдээх компани, гэрээт компаниуд
Хариуцах нэгж	ЭМААБО хэлтэс
Нууцлаг зэрэглэл	Нууц бичиг
Тавигдсан	Бүх хэлтэс болон гэрээтүүдэд

## ӨНДӨРТ АЖИЛЛАХ ЖУРАМ

### Баталгаажуулалт

	Нэр албан тушаал	Гарын үсэг	Огноо
Боловсруулсан:	Атхбаар Монхсайхан Аюулгүй Ажиллагааны мэргэжилтэн		2022.05.05
Хянасан:	Монхбилэг Энх-Амгалан Ерөнхий инженер		
Баталсан:	Лхагвасүрэн Хандиа Гүйцэтгэх захирал		

## Хавсралт 5. Байгаль орчны аудитын гэрээ

БАТЛАВ.

“ЭКО-АКЮРЭСИ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ОТГОНЦЭЦЭГ

БАТЛАВ.

“ХАНДГАЙТ ГОЛ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭМБАЯР

СЭЛЭНГЭ АЙМАГ

## БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

№ КНГ-2025-08-27

2025 оны 08-р сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, 46-25 тоот хаягт байрлах /Регистрийн дугаар: 5751365/ Байгаль орчны аудитын (БОА) “Эко-Акюрэси” ХХК (цаашид “Үйлчилгээ үзүүлэгч” гэх), түүнийг төлөөлж менежер Д.Хүрлээ, нөгөө талаас Сэлэнгэ аймаг, Ерөө сум, 1-р баг, Тавин, Хандгайтад байрлалтай 1 “Хандгайт гол” ХХК-/Регистрийн дугаар: 2059681/ түүнийг төлөөлж Н.Эрдэмбаяр (цаашид “Захиалагч тал” гэх), нар Монгол Улсын Иргэний хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт “Баянголын ордын Баруун хүдрийн биетийн баруун VI орд” нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд Байгаль орчны аудит (БОА) гүйцэтгэх, БОА-ын тайлан боловсруулах, захиалагчид хүлээлгэн өгөх, гэрээний төлбөр төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. **Гэрээний хугацаа:** БОА-ын баг газар дээрх үзлэг зохион байгуулснаас хойш ажлын 30 хоногт БОА-ын тайланг Үйлчилгээ үзүүлэгч талд танилцуулахаар өгсөн байна.
- 1.3. **Гэрээний үнэ:** 9,000,000 (Есөн сая) төгрөг. НӨАТ багтсан үнэ болно.
- 1.4. Энэ удаагийн БОА-ын хамрах хүрээнд дараах үндсэн чиглэлүүд багтана. Үүнд:
  - ✓ Байгаль орчны удирдлагын тогтолцоо
  - ✓ Агаарын чанар
  - ✓ Ус ашиглалт
  - ✓ Газар ашиглалт, хөрсний чанар
  - ✓ Хог хаягдлын менежмент

- 1.5 **Гэрээний үр дүнг хүлээлцэх:** Үйлчилгээ үзүүлэгч Байгаль орчны аудит хийх, Байгаль орчны аудитын тайланг хэвлэмэл 2%, мөн файл хэлбэрээр захиалагчид хүлээлгэн өгнө.

### **ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1. Захиалагч гэрээт ажлыг хамтран зохион байгуулах, төслийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй үнэн зөв мэдээлэл өгөх ба аудитын ажлыг гүйцэтгэх, аюулгүй ажиллах шаардлагатай орчин, нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.2. Захиалагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн ажлын явцтай танилцах, шаардлагатай тохиолдолд аудитын дүгнэлтийг сайжруулахыг шаардах эрхтэй.
- 2.3. Захиалагч нь БОА-ын баг газар дээрх үзлэгээ гүйцэтгэхэд шаардлагатай нэг бүрийн хувийн хамгаалах хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, бусад хэрэгслэлээр хангах зааварчилгаа өгч болно.
- 2.4. Ахлах аудиторoor дамжуулан БОА-ын багт санал, хүсэлт, шаардлагаа хүргүүлнэ.
- 2.5. Захиалагч талаас БОА-ын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, аудитын тайлан, үр дүнг хүлээн авах эрх бүхий албан тушаалтанг томилсон байна.
- 2.6. Гэрээний 2.5-д заасан албан тушаалтан БОА-ын багийг шаардлагатай мэдээллээр шуурхай хангах, газар дээрх үзлэгийг богино хугацаанд оновчтой хэрэгжүүлэх, гэрэл зураг авах, тэмдэглэл үйлдэх, ярилцлага хийх нөхцөлөөр хангаж ажиллана.
- 2.7. БОА-ын газар дээрх үзлэгийн үед аливаа хязгаарлалт, тусгай нөхцөл байдал бий болсон үед Ахлах аудитор т яаралтай мэдээлнэ.
- 2.8. Аудитын ажлын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд саадгүй шилжүүлнэ.

### **ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Хөндлөнгийн, бие даасан, хараат бус, нотолгоонд түшиглэсэн БОА-ыг гүйцэтгэж, БОА-ын тайлан боловсруулж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, үр дагавар, хамрах хүрээ, учирч болзошгүй аливаа осол, эрсдэл, хохирлыг тодорхойлох, илэрсэн зөрчил, үл нийцлийг арилгах, зардал хэмнэх үр ашигтай менежмент, хэрхэн урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж өгнө.
- 3.2. БОА-ыг хариуцлагатай гүйцэтгэж, төслийн эзэмшил талбайд нэвтэрч, ойр орчинд нь ажиглалт хийх, барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй танилцах, баримт бичгийн аудит хийх, гэрэл зураг авах, хариуцсан удирдлага, мэргэжилтэнтэй ярилцлага хийх болон илэрсэн асуудлуудыг нэгтгэх явцад аудит хийлгэгч буюу Захиалагч байгууллагын соёл, дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг хүндэтгэн эн тэргүүнд дагаж мөрдөж ажиллана.
- 3.3. Үйлчилгээ үзүүлэгч БОА-ын зорилго, хөтөлбөр, удирдамжийн дагуу мэргэжлийн байх, нягт нямбай байх, үл ялгаварлах, ашиг сонирхлын зөрчилгүй байх, гуравдагч талуудтай мэдээллийг хэлэлцэхгүй байх, буруу

болон төөрөгдөл үүсгэхгүй байх, нотолгоонд тулгуурлах зарчмуудыг эрхэмлэн ажиллана.

- 3.4. БОА хийхэд шаардлагатай мэдээлэл гаргуулах, газар дээрх үзлэгийн үед хувийн хамгаалах хэрэгсэл, зааварчилгаа шаардлагатай бол уг хүсэлтээ илэрхийлэх.
- 3.5. Захиалагчаас БОА-ын үед олж авсан мэдээлэл, дотоод журам, бичиг баримтыг актаар хүлээн авч, ажил үүргээ дуусмагц акт үйлдэн буцаан хүлээлгэн өгнө.
- 3.6. БОА хийх явцад захиалагч талаас ирүүлсэн бүх баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 3.7. Захиалагч хүсвэл БОА-ын тайланд шаардлагатай сайжруулалт хийнэ.
- 3.8. Гэрээний үүргээ биечлэн гүйцэтгэх бөгөөд гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 3.9. Захиалагчийн нэр барих, түүнд мэдэгдэхгүй, зөвшөөрөлгүй орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн иргэн, аж ахуйн нэгжид аливаа мэдээлэл өгөхгүй байх.
- 3.10. Мэргэжлийн бус, эсвэл мэргэжлийнх мөртлөө туршлагагүй хүн ажиллуулахгүй.

#### **ДӨРӨВ. АУДИТЫН ҮЕ ШАТ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

- 4.1. БОА-ыг гэрээний 1.5-д заасан хугацаанд дараах үе шатуудад хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 4.1.1. БОА-ын бэлтгэл үе шат:
  - 4.1.2. БОА-ын газар дээрх үзлэгийн үе шат:
  - 4.1.3. БОА-ын тайлан боловсруулах үе шат:
  - 4.1.4. БОА-ын тайлангийн төслийг танилцуулах үе шат:
  - 4.1.5. БОА-ын тайланг хүлээлгэж өгөх үе шат:

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, БАТАЛГАА**

- 5.1. БОА-ын үед илэрсэн зөрчил, болзошгүй эрсдэл, үр дагавар, урьдчилан сэргийлэх арга замыг Үйлчилгээ үзүүлэгч БОА-ын тайланд тусгаагүй нь экологийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 5.2. Захиалагч гэрээний 2.1-д заасан мэдээлэлээр хангаагүй нь 5.1 дэх нөхцөл байдлыг үүсгэсэн бол Үйлчилгээ үзүүлэгч хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 5.3. Үйлчилгээ үзүүлэгч нь мэргэжлийн компанийн хувьд Захиалагчийн ажлыг гүйцэтгэх баг, аргачлалыг өөрөө сонгож, хэрэгжилтэд баталгаа гаргана.
- 5.4. Талууд бичиг баримт солилцохдоо акт үйлдэн хүлээлцэх бөгөөд БОА-ын тайланг хүлээлцэхдээ бүрэн гүйцэд буцаан өгч, хуулбар хувь үлдээгүй тухай баталгаа өгнө.
- 5.5. Үйлчилгээ үзүүлэгч талын ажлын гүйцэтгэл нь холбогдох стандарт заавар журам техникийн тодорхойлолтод нийцсэн байна.

## ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 6.1. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлын нийт хөлс:
  - ✓ Нийт ажлын хөлс 9,000,000 (есөн сая) төгрөг. НӨАТ багтсан. Гэрээ хэрэгжих явцад энэ үнийн дүн өөрчлөгдөхгүй.
- 6.2. Захиалагч тал нь гэрээний 6.1-т заасан төлбөрийн 50%-ийг гэрээ хүчин төгөлдөр болсноор ажлын 3 хоногт, үлдэгдэл төлбөрийг БОА-ын тайланг хүлээлцэж, актаар хүлээлгэн өгсөн өдрөөс ажлын 3 хоногт багтаан Үйлчилгээ үзүүлэгчийн Худалдаа хөгжлийн банкны **800000445** тоот дансанд шилжүүлнэ.
- 6.3. Гэрээнд зааснаас өөр нэмэлт ажил гүйцэтгэх тохиолдолд холбогдох зардлыг харилцан тохиролцож, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна. Талууд энэ гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэнэ

## ДОЛОО. ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

- 7.1. БОА-ын баг газар дээрх үзлэгийн үед Захиалагчийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг чанд баримтлаж ажиллана.

## НАЙМ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

- 8.1. Үйлчилгээ үзүүлэгч гэрээ байгуулснаас хойш энэ гэрээ болон төслийн талаарх мэдээллийг хугацаагүй хадгалах үүрэг хүлээнэ.
- 8.2. БОА-ын тайланг бичиг баримт солилцох акт үйлдэн хүлээлцсэн материалуудын хамт захиалагчид хүлээлгэн өгч, хуулбар хувь үлдээгүй тухай баталгаа өгнө.

## ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 9.1. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн саатуулсан, тасалдуулсан, хойшлуулсан, хүчтэй цасан болон шороон шуурга, газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гэнэтийн үзэгдэл, түймэр, нийтийг хамарсан халдварт өвчний улмаас хөл хорьсон, үймээн, эсэргүүцлийн жагсаал, төрийн байгууллага, орон нутгийн захиргааны шийдвэр, хоригийг Давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 9.2. Дараах тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзэхгүй. Үүнд:
  - 9.2.1. Зардлын өсөлт, эдийн засгийн сөрөг нөлөө
  - 9.2.2. Гэрээний үүрэг гүйцэтгэх явцад Үйлчилгээ үзүүлэгчийн техник, тоног төхөөрөмж, машин эвдрэх, алдагдах, түлш тасалдах зэрэг болно.
- 9.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх ба уг нөхцөл байдал арилах хүртэл гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаа түр хойшлоно.

## АРАВ. БУСАД

- 10.1. Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

10.2. Талууд аливаа асуудал, үл ойлголцлыг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

10.3. Гэрээний хавсралтаар БОА-ын урьдчилсан асуулга байна.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эко-Акюрэси ХХК-ийн



Менежер Д.Хүрлээ

Утас: 9900 2992

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ийн

Санхүү эрхэлсэн захирал  
Д.Эрдэнэгэрэл

Утас: 9911 6750

## Хавсралт 6. Нийгмийн хариуцлагын гэрээ дүгнэлт

## Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Сэлэнгэ аймаг, Ерөө сум засаг даргын тамгын газар болон Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт үйл ажиллагаа явуулагч MV-021595 дугаартай Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хандгайт гол” ХХК нарын 2024 оны 05 сарын 02-ны өдөр байгуулсан “Нийгмийн хариуцлагын гэрээ”-г (цаашид Гэрээ гэх) дараах байдлаар дүгнэв.
- 1.2. Энэхүү гэрээний зорилго нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## Хоёр. Гэрээ дүгнэлт

- 2.1. Гэрээний Гурав.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг-ийн 3.1.1-т заасан Үйл ажиллагаагаа хүрээнд хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх гэж заасан бөгөөд 2024 оны 04 сараас “Хандгайт гол” ХХК нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад орон нутгийн иргэдээс болон хуулийн этгээдээс хууль бусаар саад учруулсан тохиолдол гараагүй болно. Заалтын хэрэгжилт **100%**.
- 2.2. Гэрээний 3.1.2-т заасан “Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах”

Хэрэгжилт: “Хандгайт гол” ХХК нь өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай ажилчдын орон тоог Сэлэнгэ аймаг, Ерөө сумаас бүрдүүлэхээр жилдээ хамгийн багадаа 1 удаа Ерөө сум болон Бугант тосгон “Нээлттэй ажлын байр”-ны өдөрлөг зохион байгуулсан бөгөөд 2024 оны байдлаар 90 гаруй анкет бүрдүүлсэн. Гэрээний заалтын хэрэгжилт **100%**.



- 2.3. Гэрээний заалт 3.1.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,





- Нийгмийн хариуцлагын хүрээнд Сурийн аварга шалгаруулах тэмцээны талбай руу явах голын гарам засварын ажилд шаардлагатай материал буулгасан.



- Нийгмийн хариуцлагын хүрээнд Улаан давааны баруун талд малчдын хүсэлтээр гарам зассан.





- 2024 оны 06 сарын 09-ны өдөр орон нутагийн хөгжилд нийгмийн хариуцлагын хүрээнд газар шорооны ажилд туслан, морины зам гарган өгөв.



- 2024 оны 07 сарын 04-с 07 сарын 09ны хооронд автогрейдерээр 20км замын тохижилт хийсэн.



- 2024 оны 07 сарын 04-с 07 сарын 09ны хооронд ковшоор хурдны морь уралдах зам талбайг янзалж бэлдсэн.


2.5. Гэрээний заалт 3.1.5.-т Ерөө сумын түүхт 100 жилийн ойд зориулж 60.000.000 төгрөг хандивлах,

Хэрэгжилт: “Хандгайт гол” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын түүхт 100 жилийн ойн баярт зориулан 2023 онд 11,375,000.0 төг, 2024 онд 33,000,000.0 төг тус тус хандивласан байна. Хавсралт №01-т тусгав. Хэрэгжилтийн хувь **73%**.



2.6. Гэрээний заалт 3.1.6. Техник технологийн дээд сургуульд 3-4 оюутныг төлбөрийн 100%-ын тэтгэлэгтэйгээр суралцуулах,

Хэрэгжилт: Энэхүү заалтын хэрэгжилтийн хувь **50%**. Одоогийн байдлаар Б.Ирмүүн нь Техник технологийн коллежид, Нарантуул нь ХХҮҮТ-1 тус тус суралцаж байгаа болно.



2.7. 3.1.7. Нийт ажилчдын 60-с дээш хувийг орон нутгийн иргэдээс сонгон шалгаруулж авах,

Хэрэгжилт: Одоогийн байдлаар “Хандгайт гол” ХХК-д нийт үндсэн ажилтан 53 байгаагаас орон нутгийн иргэдээс 22 буюу 42%-ийн гүйцэтгэлтэй байна. **70%** хэрэгжилттэй.

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-н АЖИЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ							
ЗАХИРГАА							
№	Овог	Нэр	Албан тушаал	РД	Утасны дугаар	Харьяа	Ажилд орсон
1	Баттулга	Мөнгөншагай	Ковш оператор	МП04221113	94818467	Хүдэр	2025.06.10
2	Нямсүрэн	Жүгдэржав	Маркшейдер	МЕ97042613	88742441	Ерөө	2025.04.23
3	Дамдин	Энхцацрал	Уурхайн админ	МТ00250400	85111354	Ерөө	2025.04.23
4	Цэрэнсомон	Батгөр	Дээж бэлтгэгч	МБ73021011	99877804	Бугант	2025.04.23
5	Ням-Осор	Энхтуяа	Тогооч	МТ79022608	99965350	Бугант	2025.04.23
6	Дамдинжав	Эрдэнэчимэг	Туслах тогооч	ДНО80061366	99845465	Бугант	2025.04.23
7	Цэрэн	Уранбилэг	Туслах тогооч	МЕ69070405	94787929	Ерөө	2025.06.09
8	Ганбаатар	Энэбиш	Бэлтгэгч	МЕ82121005	99609376	Ерөө	2025.04.23
9	Алтанцэцэг	Баярмаа	Бэлтгэгч	МЕ02251805	80606158	Ерөө	2025.04.23
10	Сашка	Шынай	Бэлтгэгч	МТ90012503	99634632	Бугант	2025.04.23
11	Карпова	Антонина	Бэлтгэгч	RU76050982U49	85595820	Бугант	2025.04.23
12	Бугандай	Янжмаа	Бэлтгэгч	МЕ79060607	99537054	Хүдэр	2025.06.09
13	Жамбаа	Батзаяа	Угаагч	МТ89041404	89372229	Бугант	2025.04.23
14	Наранхүү	Оюунцэцэг	Угаагч	МТ91122103	99666902	Дархан	2025.04.23
15	Пүрэв	Наранхүү	Угаагч /хувцас/	МТ76062902	95272576	Бугант	2025.04.23
16	Наранхүү	Ариунзул	Угаагч /хувцас/	УХ95111621	99332852	Бугант	2025.04.23
17	Пүрэвэ	Уранхайч	Үйлчлэгч	МЭ76102567	99390594	Зүүнхараа	2025.04.23
18	Өлзийбат	Лхагвасүрэн	Үйлчлэгч	М374050104	95155286	Зүүнхараа	2025.06.09
19	Жамсран	Отгонбаяр	Кемп туслах	М390061571	99815105	Зүүнхараа	2025.04.23
20	Эрдэнэтуяа	Төгсбаяр	Кемп туслах	БО84071939	80106441	Дархан	2025.04.23
21	Лувсандавга	Гомбосүрэн	Кемп туслах	МЮ70011670	94616219	Ерөө	2025.04.23
22	Буяндэлгэр	Ганбилэг	Кемп туслах	МТ91080511	95504632	Бугант	2025.04.23

2.8. Гэрээний заалт 3.1.8.-т Сумын малчин болон мал бүхий иргэдээс мах махан бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо тариалдаг ААНэгж, иргэдээс төмс хүнсний ногоог тогтмол авах

Хэрэгжилт: Хавсралтад заасны дагуу Орон нутгийн иргэдээс худалдан авсан хүнс, хүнсний ногооны нийт өртөг 50,953,460.0 төг бол мах махан бүтээгдэхүүн нийт өртөг нь 54,946,142.0 төг тус тус байна. **100%** хэрэгжилттэй.

2.9. Заалт 3.1.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан жил бүр сум орон нутагт тайлагнан дүгнүүлж ажиллах,

Хэрэгжилт: Тайлант оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө биелэлтийг 2024 оны 10 сард орон нутгийн иргэдэд танилцуулах, уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулах, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарилагийн дагуу Тэрбум мод өдөрлөгийг “Модоо ургуулцгаая” уриан дор давхар зохион байгуулсан. **100%** хэрэгжилттэй.

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

**НЭХЭМЖЛЭХ № 5**

Нэхэмжлэгч: \_\_\_\_\_ Төлөгч: \_\_\_\_\_  
 Байгууллагын нэр: Грийн пайп ХХК Байгууллагын нэр: \_\_\_\_\_  
 Хаяг: Сэлтгэ аймгаг Ерөө сум Хаяг: \_\_\_\_\_  
 Утас: Факс: 26000589  
 Э.шуудан \_\_\_\_\_ Гэрээний № \_\_\_\_\_  
 Банкны нэр: Төрөлөг Банк  
 Банкны дансны дугаар: 152101150023 Нэхэмжилсэн огноо \_\_\_\_\_  
 Регистрийн №: 3752941 Төлбөр хийх хугацаа \_\_\_\_\_

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Алт	50	3000	150000
2	Монго	50	6000	300000
3	Чимас	50	6000	300000
4	Кайлаас	50	2500	125000
5	Нарс - 2 наст	100	1500	150000
6	Нарс - 3 наст	50	2500	125000
		350	Дүн	1150000
			НВАТ	
			Нийт дүн	1150000

Өгөгдлийн дүн: Нэг сая ихэвчлэн тавих  
 Дарга: Н.Бүлэгдэлгэр  
 (Тамга) Хуульч: \_\_\_\_\_  
 Хүлээн авсан: \_\_\_\_\_  
 Нэгтгэн бодогч: \_\_\_\_\_

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

**ЗАРЛАГЫН БАРИМТ №**

Регистрийн №: Грийн пайп ХХК (байгууллагын нэр)  
 Регистрийн №: Кайлаас Өол ХХК (худалдан авагчийн нэр)  
 2024 оны 10 сарын 09 өдөр  
Сэлтгэ аймгаг Ерөө сум (тээвэрлэгчийн хаяг, агбан тушаал, нэр)

№	Материалын үнэг зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэмжээ	Хуудал		
				Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Алт		50	3000	150000	
2	Нарс - 3 наст		50	2500	125000	
3	Монго		50	6000	300000	
4	Чимас		50	6000	300000	
5	Кайлаас		50	2500	125000	
6	Нарс - 2 наст		100	1500	150000	
			350	Дүн	1150000	
				НВАТ		
				Нийт дүн	1150000	

Дарга: Н.Бүлэгдэлгэр  
 Хуульч: \_\_\_\_\_  
 Хүлээн авсан: \_\_\_\_\_  
 Нэгтгэн бодогч: \_\_\_\_\_



Мод тарьж дуусаад дурсамжийн зураг даруулсан.



Мод тарьж буй байдал.

Уурхайн кемпийн талбайд 5 төрлийн 350 мод тарьсан байдал



2.10. 2023 оны Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасны дагуу Баянгол орчмын айлуудын хүсэлтийн дагуу 2 гүний худаг гаргасан. Гүний худгийг иж бүрэн болгон 2025.08.04 нд орон нутгийн удирдлагын хамт олонд хүлээлгэн өгсөн.

Гэрээний заалтын хэрэгжилт **100%**.

*“ХАНДГАЙТ ГОЛ” ХХК  
ГАЗАР*

*ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН*



“ХАНДГАЙТ ГОЛ” ХХК  
ГАЗАР

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

- 2.11. Гэрээний заалт 3.1.10. Тус сумын Баянголын гүүрнээс Бугант тосгон хүртэлх сайжруулсан шороон замын тодорхой хэсгийн эвдрэлийг жилд нэг удаа компанийн техник, хүн хүчийг гаргаж засвар үйлчилгээ хийж өгөх,  
Хэрэгжилт: Зам засварын ажилд Автогрейдер ажиллуулах хүсэлт ирүүлсэн боловч тус техник тухайн үед эвдрэлтэй байсны улмаас хугацаанд гүйцэтгэх боломжгүй байсан.

**Нийт зардалын мэдээлэл**

№	Зориулалт	Үнийн дүн
1	Сумын төвд 600 урттай замын түрж тэгшилсэн 2024 оны 05 сарын 09нд Сэлэнгэ аймгийн 5 сумын залуу бөхчүүдийн сорил барилдааныг “Хандгайт гол” компаниас ивээн тэтгэж шагнал гардуулах үйл ажиллагаанд оролцов. 2024 оны 05 сарын 12нд Нийгмийн хариуцлагын хүрээнд Ерөө суманд нийт 4.8км 5 гудамжны зам дэвсэлтийн ажил хийсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд Сурийн аварга шалгаруулах тэмцээны талбай руу явах голын гарам засварын ажилд шаардлагатай материал буулгасан. Нийгмийн хариуцлагын хүрээнд Улаан давааны баруун талд малчдын хүсэлтээр гарам зассан. 2024 оны 06 сарын 09-ны өдөр орон нутагийн хөгжилд нийгмийн хариуцлагын хүрээнд газар шорооны ажилд туслан, морины зам гарган өгөв. 2024 оны 07 сарын 04-с 07 сарын 09ны хооронд автогрейдерээр 20км замын тохижилт хийсэн. 2024 оны 07 сарын 04-с 07 сарын 09ны хооронд ковшоор хурдны морь уралдах зам талбайг янзалж бэлдсэн. Сумын орох хаалганд хайрга дэвсэлтийн ажлыг хийж өгсөн	12 103 000
3	Сумын 100 жилийн ойн хандив	44 375 000
4	Ерөө сумын малчдад унд ахуйн зориулалттай гүний 2 ширхэг худаг гаргаж хүлээлгэж өгсөн. Худгийн байр болон мотор орсон болно.	31 499 000
5	2 оюутныг төлбөрийн 100%-ын тэтгэлэгтэйгээр суралцуулсан	5 000 000
6	Орон нутгийн иргэдээс мах махан бүтээгдэхүүн авсан	54 946 142
	Нийт	147 923 142

## Хавсралт 6. Гамшиг эрсдэлийн үнэлгээний гэрээ



## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 10 сарын 10-ний өдөр

№КНГ-2025-10-10

Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас улсын бүртгэлийн 1311003083, регистрийн 2059681 тоот дугаартай “Хандгайт гол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал албан тушаалтай Н.Эрдэмбаяр /цаашид “Захиалагч” гэх/, нөгөө талаас улсын бүртгэлийн 9011814999, регистрийн 6527175 тоот дугаартай “Кило Майн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал албан тушаалтай Ж.Ууганбаяр /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар /хамтад нь “Талууд” гэх/ Монгол Улсын Иргэний хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үндэслэн доорх нөхцөлийг харилцан тохиролцож уг гэрээг байгуулав.

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь гэрээнд заасан нөхцөл шаардлагын дагуу гэрээний 2.1-т заасан ажлыг хугацаанд нь гүйцэтгэх, Захиалагч нь гэрээт ажлын үр дүнг хүлээн авах, гэрээний төлбөр төлөх, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох болон холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД

- 2.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах “Хандгайт гол” төмрийн хүдрийн ил уурхайн үйл ажиллагаа, барилга байгууламжуудад Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийнэ.
- 2.2. Дараах асуудлуудад тулгуурлан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгдэнэ. Үүнд:
  - 1) Байгаль, цаг уурын гаралтай
  - 2) Техник, технологийн холбогдолтой
  - 3) Биологийн гаралтай
  - 4) Хүний үйл ажиллагааны холбогдолтой
- 2.3. Гэрээт ажил нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, Монгол Улсын Шадар сайдын 68-р тушаалаар баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар”, ОБЕГ-ын даргын 2021 оны А/255 тоот тушаалаар баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг дүгнэх шалгуур үзүүдэлт” холбогдох бусад хууль тогтоомж, заавруудтай нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 2.4. Захиалагч тал гэрээний 3.2-т заасан урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн өдрөөс ажил хийж гүйцэтгэж эхлэх ба 45 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ.

- 2.5. Хэрэв орон нутаг дахь объектуудад биет судалгаагаар явах үед давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тохиолдолд хөл хорио тогтоосон өдрөөр гэрээний хугацаа сунгагдана.
- 2.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг цаасан хэлбэрээр тус бүр 3 хувь үйлдэнэ. Эдгээрээс захиалагчид 1, гүйцэтгэгчид 1, ОБЕГ-т 1 хувь тайланг хүлээлгэн өгнө.
- 2.7. Захиалагчаас Гүйцэтгэгчид энэ Гэрээнд заагдаагүй нэмэлт ажлын захиалга өгвөл Гэрээнд нэмэлт оруулах эсвэл дахин гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.

### **ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ**

- 3.1. Гэрээт ажлын нийт үнэ 15,000,000₮ (арван таван сая) төгрөг байна. Үнийн дүнд НӨАТ багтсан болно.
- 3.2. Захиалагч Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн урьдчилгаа төлбөр болох 30 хувийг дор дурдсан дансанд шилжүүлнэ. Үлдэгдэл төлбөрийг ажлын явцад 40 хувь, эрсдэлийн үнэлгээний тайланг цаасан хэлбэрээр хүлээн авсаны дараа 30 хувийг шилжүүлнэ.
- Хүлээн авагч: “Кило майн” ХХК  
Харилцагч банк: Голомт банк  
Харилцах данс: 1175129259  
IBAN: MN5000 1500
- 3.3. Хэрэв ажлын гүйцэтгэл болон гүйцэтгэлийн актын талаар Талууд санал нэгдээгүй нөхцөлд маргаангүй хэсгийг Захиалагч саадгүй төлөх бөгөөд тухайн маргаантай хэсэг шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд тухайн маргаантай төлбөрийг төлөхгүй байх эрхийг Захиалагч эдэлнэ.

### **ДӨРӨВ. НУУЦ ХАДГАЛАХ**

- 4.1. Талууд энэхүү гэрээгээр дор дурдсан бизнесийн болон бусад нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг /цаасан, цахим, амаар хэлсэн, мэдээлэл хадгалагч төхөөрөмжид байгаа мэдээлэл г.м аль ч хэлбэрээр байгаа мэдээлэл, баримт бичиг хамаарна/-ийг хадгалах үүргийг аль ч хугацаанд хүлээнэ. Үүнд:
- 4.1.1. Захиалагч талаас Гэрээт ажлын хүрээнд Гүйцэтгэгчид шилжүүлсэн бүх төрлийн баримт бичиг, мэдээлэл;
- 4.1.2. Гүйцэтгэгчийн Захиалагчид хүлээлгэн өгсөн гэрээт ажлын баримт бичиг, мэдээлэл;
- 4.1.3. Талууд Гэрээт ажлын хэрэгжилтийн явцад олж мэдсэн нөгөө талын бүхий л мэдээлэл, баримт бичиг;
- 4.2. Дараах мэдээлэл, баримт бичиг нууцад хамаарахгүй. Үүнд:
- 4.2.1. Талууд өөрийн хүсэлтээр нийтэд ил болгосон мэдээлэл, баримт бичиг;
- 4.2.2. Нөгөө талын бичгээр олгосон бусдад задруулахыг зөвшөөрсөн мэдээлэл, баримт бичиг;
- 4.3. Талууд нууцад хамаарах мэдээлэл, баримт бичгийг нөгөө талын албан ёсны зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах, ашиглуулах, хувийн ашиг сонирхол болон аливаа гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглах, гуравдагч этгээдэд нууцлалыг мэдэгдэх, энэхүү хамтран ажиллах зорилгоос гадуур нөгөө талын ашиг сонирхлын эсрэг ашиглахыг хориглоно.
- 4.4. Талууд гэрээний 4.3-р заалтыг зөрчсөн тохиолдолд нөгөө талдаа учирсан бүхий л хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

### **ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

5.1. Гүйцэтгэгч нь дараах эрхтэй. Үүнд:

5.1.1. Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг Захиалагчаас шаардах;

5.1.2. Захиалагч талаас гэрээт ажлын төлбөрийг нэхэмжлэх;

5.1.3. Захиалагчийг гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;  
объектод нэвтрэх, танилцах;

5.1.5. Захиалагч шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг гарган өгөөгүй эсвэл буруу мэдээлэл өгснөөс үүсэх үр дагаврын хариуцлагыг гүйцэтгэгч хүлээхгүй байх;

5.2. Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

5.2.1. Гэрээт ажлыг гэрээний 2.3.-т заасан шаардлагад нийцүүлэн гэрээний 2.4-т заасан хугацаанд хийж гүйцэтгэх;

5.2.2. Гэрээт ажлын тайланг цаасан болон цахим хэлбэрээр Захиалагчид хүлээлгэн өгөх;

5.2.3. Гэрээт ажлыг зохих анхаарал, хяналт, ур чадвар, идэвх зүтгэл гаргаж, мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэх;

5.2.4. Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбогдон гарах ажиллах хүн хүч, техник хэрэгслийн зардлыг бүрэн хариуцаж ажиллах;

5.2.5. Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай чадварлаг мэргэжилтнээр хангаж ажиллах;

5.2.6. Гэрээт ажлыг дутуу, буруу, алдаатай гүйцэтгэсэн, энэ гэрээгээр тохиролцсон шаардлагад нийцээгүй бол гэрээт ажлыг өөрийн зардлаар, Захиалагчийн тохиролцсон хугацаанд бүрэн гүйцэтгэх;

5.2.7. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бусдад шилжүүлэхгүй байх;

5.2.8. Гэрээт ажлын хөлсийг аливаа шалтгаанаар нэмэгдүүлэхгүйгээр ажлыг зохих ёсоор шаардлагад нийцүүлэн хийх;

5.2.9. Гэрээний хугацаа дууссаны дараа Захиалагчаас хүлээн авсан баримт бичгийг Захиалагчид хүлээлгэн өгөх;

## **ЗУРГАА. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

6.1. Захиалагч нь дараах эрхтэй. Үүнд:

6.1.1. Гэрээт ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэхийг захиалагчаас шаардах;

6.1.2. Гэрээт ажлыг биет байдлын болон чанарын доголдолгүй өөрийн өмчлөлд шилжүүлэхийг шаардах;

6.1.3. Гүйцэтгэгчийн ажлын явц, үр дүнтэй хэдийд ч танилцах, мэдээлэл авах;

6.1.4. Гэрээт ажлыг дутуу, буруу гүйцэтгэсэн, ажлын үр дүн доголдолтой, Захиалагчтай тохиролцсон шаардлагад нийцээгүй тохиолдолд гэрээт ажлыг үнэ төлбөргүй дахин гүйцэтгэхийг шаардах, өөр этгээдээр дахин гүйцэтгүүлсэн тохиолдолд гарсан зардал, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардах;

6.1.5. Гүйцэтгэгч нь захиалагчаас тогтоосон шаардлагын дагуу ажлыг гүйцэтгээгүй бол төлбөрийг уг шаардлагыг хангах хүртэл хугацаагаар төлөхгүй байх;

6.2. Захиалагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

6.2.1. Энэ гэрээнд заасан шаардлага хангасан гэрээт ажлын гүйцэтгэлийг хүлээн авах;

6.2.2. Гэрээт ажлын төлбөрийг гүйцэтгэгчид хугацаанд нь бүрэн шилжүүлэх;

6.2.3. Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Гүйцэтгэгч талаас шаардсан мэдээлэл, баримт бичгийг 7 хоногийн хугацаанд гаргаж өгөх;

6.2.4. Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой гэрээний хүрээнд хийгдэх ажлуудыг уялдуулах, зохицуулах үүрэг бүхий ажилтныг томилж;

6.2.5. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой Гүйцэтгэгч талын ажилтныг гэрээний хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангах /баримт бичиг хуулбарлах, холбогдох ажилтантай хэлэлцүүлэг хийх, мэдээлэл авах г.м/

### **ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА**

7.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа учирсан хохирол, зардлыг бүрэн хариуцаж төлнө.

7.2. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаандаа хийж дуусгаагүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд алдангийг захиалагчид төлнө.

7.3. Захиалагч нь гэрээт ажлын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн алдангийг Гүйцэтгэгчид төлнө.

### **НАЙМ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ**

8.1. Энэхүү гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

8.1.1. Талууд гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн;

8.2.1. Талууд харилцан тохиролцож гэрээг цуцалсан;

8.2.2. Хуульд заасан бусад үндэслэлээр.

8.2. Талууд дараах тохиолдолд нэг талын санаачилгаар гэрээг цуцална. Үүнд:

8.2.1. Гүйцэтгэгч гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бөгөөд Захиалагч талаас тогтоосон нэмэлт хугацаанд Гэрээт ажлыг дуусгаж хүлээлгэж өгөөгүй;

8.2.2. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гэрээнд заасан шаардлагад нийцүүлж хийгээгүй бөгөөд Захиалагч талаас чанарын шаардлагыг сайжруулах мэдэгдэлд заасан хугацаанд гэрээт ажлыг чанартай гүйцэтгээгүй;

8.2.3. Захиалагч гэрээний урьдчилгаа төлбөрийг төлөөгүй ажлын 5 хоног хэтэрсэн;

8.3. Талууд нэг талын санаачилгаар гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа 14 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

### **ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

9.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс (иргэний хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөл, хорио цээрийн дэглэм тогтоох, байгаль цаг уурын аюулт үзэгдэл, гамшиг, осол зэрэг)-ээс шалтгаалсан онцгой нөхцөл байдлын улмаас аль нэг Тал нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын 3 хоногт багтаан бичгээр мэдэгдэх бөгөөд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх хугацаа эдгээр хүчин зүйл үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

9.2. Давагдашгүй хүчин зүйл бүрдсэн тухай мөн үүнээс учирсан хохирлын талаар талууд хоёр талын акт бүрдүүлж баталгаажуулна.

### **АРАВ. БУСАД**

10.1. Энэхүү гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

10.2. Энэхүү гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд эвийн журмаар харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Маргааныг харилцан тохиролцож эвээр шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Энэхүү гэрээний нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болох ба уг гэрээтэй адил хүчинтэй байна.

10.4. Талуудын Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, өмчлөгчид өөрчлөгдсөн болон компани өөрчлөн байгуулагдсанаас үл хамаарч гэрээг хүчин төгөлдөр байлгах асуудлыг талууд бүрэн хариуцна.

10.5. Энэхүү гэрээг адил хүчинтэй Монгол хэлээр 2 хувь үйлдэх бөгөөд талууд нэг нэг хувийг хадгална.

10.6. Талуудын эрх бүхий төлөөлөгчид нь энэ гэрээний нөхцөлтэй бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөн болно.

### ТАЛУУДЫН ХАЯГ:

Хаяг: Сэлэнгэ аймаг, Ерөө сум, 1-р баг,  
Хандгайт  
Утас: 88880748,

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар  
дүүрэг, 8-р хороо, Интер оффис, 301 тоот  
Утас: 88887816, 99038232,

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
"ХАНДГАЙТ ГОЛ" ХХК-ИЙН САНХҮҮ  
ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ



 Д.Эрдэнэгэрэл

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
"КИЛО МАЙН" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



 Ж.УУГАНБАЯР

## Хавсралт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дээжний хариу



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЫ ОРЧИН ХЭМЖИЛ ЭҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-д, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот  
Утас: 11-341818 И-мэйл: [bolndi@bolndi.com](mailto:bolndi@bolndi.com)

**СОРИЛТЫН ДҮН**



Дугаар он/№ : 2025/581-582  
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Хандгайт гол" ХХК  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : М.Аягуль БОШЛ-ийн эрхлэгч  
Сорьцын тоо, төрөл : 2 хөрсний сорьц  
Сорьц авсан огноо : 2025.09.10  
Сорьцын тодорхойлолт : Сэлэнгэ аймаг Ерөө сум  
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022  
Шинжилсэн огноо : 2025.09.16  
Хуудасны тоо : 1/1  
Үр дүн

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронци (Sr)
		мг/кг						
1	Кемп	1.5	21	<0.005	<0.5	300	20	561
2	Уурхай	<0.05	38	<0.005	<0.5	350	30	352
<b>MNS 5850:2019/ ЗДХ/</b>		<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>800</b>

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Хянаж баталгаажуулсан:



Ахлах шинжээч Б.Даваасүрэн  
БОШЛ-ний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

Хуульчлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 /A93-98

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

“Хандгайт гол”ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл:

6, Агаарын дээж

Хүлээн авсан огноо:

2025 - 09- 03

Сорилтын арга, аргачлал:

MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021, MNS4048-88

Дээжийн тодорхойлсон үзүүлэлт: хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, PM10, PM2.5

Шинжилгээ хийж дууссан огноо:

2025 – 09 - 04

#### АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд мг/м3					Том ширхэглэгт тоосонцор (PM10)		
		Азотын давхар исэл (NO2)	Хүхэрлэг хий (SO2)	Тоос (нийт)			Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
				Дундаж	Хамгийн бага	Хамгийн их			
1	Кемп	0.038	0.007	0.095	0.058	0.617			
2	Ил уурхай	0.052	0.008	0.068	0.049	0.562			
3	Тээврийн зам 2	0.046	0.009	0.186	0.090	0.936			
4	Хаягдлын овоолго	0.027	0.010	0.093	0.069	0.717			
5	Тээврийн зам 1	0.073	0.002	0.087	0.081	0.104			
6	Баяжуулах	-	-	-	-	-	0.069	0.055	0.369
MNS4585:2025 стандарт дахь хүлцэх агууламж		<b>0.200</b>	<b>0.450</b>	<b>0.500</b>			<b>0.100</b>		

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах “Хандгайт гол” ХХК-ний орчмоос авсан агаарт азотын давхар исэл, хүхэрлэг хий MNS 4585:2025 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер.....*С.Цэнджав*.....С.Цэнджав  
Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч.....*М.Аягүл*.....М.Аягүл  
Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга.....*О.Ганбат*.....О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № У121

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

“Хандгайт гол”ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

1, Ундны ус

Хүлээн авсан огноо

2025 - 09- 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

гол ион, биогений элемент

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 – 09 - 04

Үр дүн:

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Худгийн ус	MNS 900:2018
MNS ISO 10523:2001	РН –орчин	7.61	<b>6.5-8.5</b>
CA3 У 21:2012	Өнгө		20 градус
MNS 1097:2023	Кальци, мг/л	<b>161.8</b>	100.0
MNS 1097:2023	Магни, мг/л	<b>40.1</b>	<b>30.0</b>
MNS 1097:2023	Аммоны азот, мгN/л	Илрээгүй	<b>1.5</b>
MNS 4430:2005	Төмөр /нийт/, мг/л	Илрээгүй	<b>0.3</b>
MNS 9297:2005	Хлор, мг/л	23.0	<b>350.0</b>
MNS 6271:2011	Сульфат, мг/л	337.4	<b>500.0</b>
MNS 6779:2019	Нитрит, мгN/л	0.026	<b>1.0</b>
MNS 6834:2020	Нитрат, мгN/л	7.50	<b>50.0</b>
MNS 6831:2020	Гидрокарбонат	306.6	
MNS ISO 6059:2005	Хатуулаг, мг-экв/л	<b>11.37</b>	<b>7.0</b>
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар, мгО/л	2.7	
MNS 6272:2011	Фтор, мг/л	0.28	<b>0.7-1.5</b>
MNS 1097:2023	Эрдэжилт, мг/л	902.2	
CA3 У 20:2012	Na+K, мг/л	33.3	
MNS ISO 6878:2001	Фосфор, мг/л	0.049	<b>3.5</b>
MNS ISO 7888:1999	ЕС, µs/cm	<b>1197.0</b>	1000.0
	Булингар, FNU	Илрээгүй	5.0
MNS 6835:2020	Цахиур, мг/л	8.41	
MNS ISO 11083:2001	Хром+6, мг/л	Илрээгүй	

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах “Хандгайт гол” ХХК-ний худгийн усанд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 900:2018 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс кальци 1.62 дахин, магни 1.34 дахин, хатуулаг 1.62 дахин их байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер.....*С.Цэнджав*.....С.Цэнджав

Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч.....*М.Аягүл*.....М.Аягүл

Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга.....*О.Ганбат*.....О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № У123-124

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

"Хандгайт гол" ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

2, Хаягдал ус

Хүлээн авсан огноо

2025 - 09 - 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

биогений элемент

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 - 09 - 08

Үр дүн:

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Орох мг/л	Гарах мг/л	MNS 4943:2015
MNS ISO 10523:2001	РН –орчин	7.61	7.52	<b>6.0-9.0</b>
MNS 6836:2020	Жинлэгдэх бодис, мг/л	650.0	<b>368.0</b>	<b>30.0</b>
MNS ISO 5815:2015	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, мгО/л	301.0	<b>44.5</b>	<b>20.0</b>
MNS ISO 6060:2001	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, мгО/л	848.0	<b>763.2</b>	<b>50.0</b>
MNS 1097:2023	Аммоны азот, мгN/л	8.12	<b>15.17</b>	<b>15.0</b>
MNS 6779:2019	Нитрит, мгN/л	0.367	<b>0.373</b>	
MNS 6834:2020	Нитрат, мгN/л	0.71	<b>1.20</b>	
MNS ISO 11083:2001	Хром6+, мг/л	0.564	0.428	<b>0.01</b>
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар, мгО/л	87.6	<b>56.1</b>	<b>20.0</b>
MNS ISO 6878:2001	Фосфор, мг/л	0.024	0.066	<b>1.5</b>
CA3 У 21:2012	Өнгө	18.84	1.17	
Цэвэршилтийн хувь		85.22		

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ний хаягдал усны химийн шинжилгээ хийж үзэхэд ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын MNS 4943:2015 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс жинлэгдэх бодис 12.27 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 2.22 дахин, химийн хэрэгцээт хүчилтөрөгч 15.26 дахин, нийт азот 1.12 дахин, перманганатын исэлдэх чанар 2.8 дахин тус тус их бөгөөд цэвэршилт 85.22 хувь байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер.....С.Цэнджав

Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч.....М.Аягүл

Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга.....О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № У119-120

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

"Хандгайт гол" ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

2, Баянгол гадаргын ус

Хүлээн авсан огноо

2025 - 09 - 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

гол ион, биогений элемент

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 - 09 - 08

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Дээд цэг	Доод цэг	MNS 4586:2024 I зэрэг
MNS ISO 10523:2001	РН –орчин	8.05	8.04	6.5-8.5
CA3 У 21:2012	Өнгө	-	-	
MNS 1097:2023	Кальци, мг/л	<b>68.2</b>	<b>65.3</b>	<25
MNS 1097:2023	Магни, мг/л	<b>26.4</b>	<b>24.2</b>	<10
MNS 1097:2023	Аммоны азот, мгN/л	<b>0.59</b>	<b>0.67</b>	0.2
MNS 4430:2005	Төмөр /нийт/, мг/л	0.12	0.18	<0.3
MNS 9297:2005	Хлор, мг/л	1.8	1.8	200
MNS 6271:2011	Сульфат, мг/л	<b>116.6</b>	<b>114.4</b>	<60
MNS 6779:2019	Нитрит, мгN/л	<b>0.051</b>	<b>0.058</b>	0.01
MNS 6834:2020	Нитрат, мгN/л	<b>3.27</b>	<b>2.21</b>	1.0
MNS 6831:2020	Гидрокарбонат	234.9	234.9	
MNS ISO 6059:2005	Хатуулаг, мг-экв/л	5.57	5.25	<7
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар, мгO/л	1.8	1.9	
MNS 6272:2011	Фтор, мг/л	0.39	0.55	0.5-1.5
MNS 1097:2023	Эрдэсжилт, мг/л	469.1	467.6	<1000
CA3 У 20:2012	Na+K, мг/л	19.8	26.3	
MNS ISO 6878:2001	Фосфор, мг/л	Илрээгүй	Илрээгүй	0.05
MNS ISO 7888:1999	ЕС, µs/cm	581.0	589.0	
	Булингар, FNU	1.97	1.88	<5.0
MNS 6835:2020	Цахиур, мг/л	4.76	5.00	
MNS ISO 11083:2001	Хром+6, мг/л	Илрээгүй	Илрээгүй	<0.01

**Дүгнэлт:** Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ний ойр урсах Баянгол голын уснаас сорьц авч шинжилгээ хийж үзэхэд гадаргын усны MNS4586:2024 стандарт дахь зөвшөөрөгдөх хэмжээнээс кальци 2.61-2.73 дахин, магни 2.42-2.64 дахин, сульфат 1.91-1.94 дахин, нитритийн азот 5.1-5.8 дахин, нитратын азот 2.21-3.27 дахин тус тус давсан байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер.....*С.Цэнджав*.....С.Цэнджав

Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч.....*М.Аягүл*.....М.Аягүл

Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга.....*О.Ганбат*.....О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / Х74-78

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

“Хандгайт гол”ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

5, Хөрс

Хүлээн авсан огноо

2025 - 09- 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

агрохимийн үзүүлэлт

Шинжилгээний аргын стандарт

MNS 3310:1991

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 – 09 - 10

### ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд, мг/кг							
		РН	Сульфат	Цийг %	Нитрат	Аммоний азот	ялзмаг	ЕС,μS/cm	Фосфор
1	Ил уурхай	9.83	73.0	1.17	6.2	34.3	2.4	18.33	28.4
2	Баяжуулах	7.35	57.2	1.08	5.5	27.2	0.9	76.4	24.3
3	Шимт хөрсний овоолго	6.24	61.5	1.01	8.0	32.8	0.2	22.5	19.7
4	Хаягдлын овоолго	9.16	41.8	1.11	10.4	44.6	1.5	12.7	28.8
5	Кемп	9.66	61.9	1.10	6.7	21.6	1.4	25.8	32.6
MNS 3297:2019 стандарт дахь ЗДХ		6-9	160.0	-	130.0	-	-	-	-

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах “Хандгайт гол” ХХК-ний орчмоос авсан хөрсний дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 3297:2019 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер.....*С.Цэнджав*.....С.Цэнджав

Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч.....*М.Аягүл*.....М.Аягүл

Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга.....*О.Ганбат*.....О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № Х79

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:

"Хандгайт гол" ХХК

Дээжийн тодорхойлолт:

Ерөө сум

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл

2, Хөрс

Хүлээн авсан огноо

2025 - 09- 03

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

нефтийн бүтээгдэхүүн

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 – 09 - 10

Үр дүн:


№	Дээж авсан цэгийн нэр	РН	Нефтийн бүтээгдэхүүн мг/кг
1	ШТС	8.85	8.6
MNS 5850:2008 стандарт дахь хүлцэх агууламж /ХА/		-	20.0

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ний ШТС болон засварын газраас авсан хөрсний дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 5850:2008 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байлаа.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер.....*С.Цэнджав*.....С.Цэнджав  
Шинжилгээг боловсруулсан: БОШЛ-ийн эрхлэгч.....*М.Аягүл*.....М.Аягүл  
Шинжилгээг хянасан: УЦУОШТөвийн дарга.....*О.Ганбат*.....О.Ганбат

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 1/185 дугаар тушаалын арван дөрөвдүгээр хавсралт



ГУБ-41 маягт

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ АКТ

2025 оны 08 сарын 15-ны өдөр

№

Нэгж талбарын дугаар:

430 100 409 1

Газар эзэмшигч, ашиглагчийн нэр:

Монгол Улсын Ерөнхийлөгч

Регистрийн дугаар:

2059681

Засаг дарга -ын 2022 оны 13 сарын 15 -ны өдрийн 1/39 дугаар шийдвэрээр шийдвэр гаргагч он сар өдөр шийдвэрийн дугаар  
Төв аймаг/нийслэл-ийн Зрэл сум/дүүрэг-ийн 2 баг/хороо-ны нутаг аймаг, нийслэлийн нэр сум, дүүргийн нэр баг, хорооны дугаар  
 дэвсгэрт 2446078 м.кв талбайтай, 4V-021595-1, Монгол улс талбайн хэмжээ газар ашиглалтын зориулалт

зориулалтаар хугацаатай эзэмшиж/ашиглаж байгаа газрын гэрээний үүргийн биелэлтийг дараах хугацаа

байдлаар дүгнэв.

1. Газрын төлбөр төлсөн эсэх:

Тийм  Үгүй

Төлбөрийн утга	Талбайн хэмжээ /м.кв/	Төлөх	Төлсөн
4025 - 1.2	2446078	11968716	5984358

2. Нийтийн эзэмшлийн зам талбайн орц гарцыг чөлөөтэй байлгасан эсэх:

Тийм  Үгүй

3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн эсэх:

Тийм  Үгүй

4. Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан эсэх:

Тийм  Үгүй

Зөрийн Төрийн ХХК / Хянан үнэлгээтэй /

4.1. Илүү ашиглаж буй талбайн зөрчлийг арилгах: Биелүүлсэн эсэх:

Тийм  Үгүй

4.2. Бут, сөөг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх: Биелүүлсэн эсэх:

Тийм  Үгүй

5. Захирамжаар олгосон хэмжээ, зориулалтын дагуу газрыг ашиглаж/эзэмшиж байгаа эсэх:

Тийм  Үгүй

Зөрийн Төрийн ХХК / Илүү ашиглаж буй талбайг арилгах /

6. Бусдын газар эзэмших, ашиглахтай холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх:

Тийм

Үгүй

7. Өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэж, ногоон байгууламжийн арчилгаа хийсэн эсэх:

Тийм

Үгүй

8. Эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж байгуулсан эсэх:

Тийм

Үгүй

9. Бүх төрлийн хамгаалалт, хязгаарлалтын бүсэд орсон эсэх:

Тийм

Үгүй

10. Захирамжаар олгосон талбайн хэмжээгээр эзэмшиж буй эсэх:

Тийм

Үгүй

11. Бусад /тэмдэглэл/

Гэрээний үүргийг биелүүлсэн эсэх талаар гаргасан дүгнэлт:

*Гэрээний үүргийг биелүүлсэн эсэх талаар гаргасан дүгнэлт*

Хянасан:

Нэгжийн дарга

Гэрээ дүгнэсэн:

Мэргэжилтэн/

Сумын газрын даамал:

Хүлээн зөвшөөрсөн:

_____	нэр	_____	гарын үсэг
	<i>Д. Васильев</i>	<i>Д. Норов</i>	гарын үсэг
_____	нэр	_____	гарын үсэг

\*Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний үүргийн биелэлтийг дүгнэхэд дээрх хянах хэсэг нь хамраахагүй болно.

Татвар төлбөр

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК- Most Money Татвар төлөлт** Огноо: 2025-01-31 16:05

Гүйлгээний дугаар № : 183581850

Хүлээн авагч:	Сэлэнгэ	Хүлээн авсан данс:	499273559
Төлөгч РД:	46900830235	Гүйлгээний суваг:	Банк Интерфайс
Биллийн дугаар:	1240203071759		

**Татварын мэдээлэл**

Эзэмшигч: Хандгайтгол Татварын төрөл: Газрын төлбөр-Дэд алба Тайлант хугацаа: 2024

Утас: Хөрөнгийн дугаар: 7 Төлөх дүн: 2992179


Төлбөр хийсэн данс : 470042272 **Нийт төлсөн дүн : 2992179**

Гүйлгээний утга : 1240203071759 46900830235 Хандгайтгол 470042272

**ТАТВАР ТӨЛБӨРИЙН ШИМТГЭЛ Б/БУС ТЕЛЛЕР - 500 MNT**

Татвараа хугацаанд нь төлсөн танд баярлалаа. Татвартай холбоотой асуудал байвал дараах маягаар хандана уу! 1800-1288, INFO@MTA.MN.

Хянасан : ..... Теллер : ..... Харилцагч :



УБЕХ маягт №:  
Статистикийн төв газар зөвшөөрснөөр  
УБЕХ-ны даргын 1986 оны 6-р сарын  
3/205 тоот тушаалаар батлав

Төлбөрийн даалгавар № 194

2025 он 01 сар 31 өдөр

		Дансны дугаар	Дүн
Төлөгч	<i>Хандгайт гол ХХК</i>	Дебет	<b>2,992,179.00</b>
Банк	<i>Худалдаа хөгжлийн банк</i>	470042272	
Хүлээн авагч	<i>Монголын татварын алба</i>	Кредит	
Банк	<i>Нэхэмжлэхийн дугаар</i>	1240203071759	
(Хоёр сая есөн зуун ерөн хоёр мянга нэг зуун далан есөн төгрөг 00 мөнгө)			... хоногийн хувийн торгууль ... төг ... мөн


(мөнгөн дүн үсгээр)

Төлбөрийн зориулалт: (Барааны болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн нэр)

1240203071759 Газрын төлбөр-Дэд алба Хандгайт гол 2059681

Гүйлгээний утга

Дагалдах баримтын дугаар №




Дарга

тамга

Нягтлан бодогч

Банкинд гүйлгээ хийсэн  
... он ... сар ... өдөр  
(тамдэг гарын үсэг)



Төлбөрийн даалгавар № **386**

2025 он 05 сар 30 өдөр

		Дансны дугаар	Дүн
Төлөгч	Хандгайт гол ХХК	Дебет	2,992,179.00
Банк	Худалдаа хөгжлийн банк	470042272	
Хүлээн авагч	Татвар сэлэнгэ	Кредит	
Банк	Нэхэмжлэхийн дугаар	1240203072674	
(Хоёр сая есөн зуун ерэн хоёр мянга нэг зуун далан есөн төгрөг 00 мөнгө)			... хоногийн хувийн торгууль ... төг ... мөн

(мөнгөн дүн үсгээр)

Төлбөрийн зориулалт: (Барааны болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн нэр)

Газрын төлбөр-Дэд алба 2024 - Зулрал Хандгайт гол 2059681

Гүйлгээний утга

Дагалдах баримтын дугаар №

тамга

Дарга

Нягтлан бодогч

*[Handwritten signature]*  
 АХБ-ны  
 Дочир мөнгөт салбар  
 Харилцагчийн  
 ШИНЖЛЭГЧИНИЙ ВЕНЖИЛГЭЭ  
 №: 09  
 УТГ

Банкинд гүйлгээ хийсэн  
 2025.05.30 өдөр  
 (тэмдэг, гарын үсэг)

Гүйлгээний баримт

Page 1 of 1

Татвар төлбөр

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК- Most Money Татвар төлөлт		Огноо: 2025-05-31 10:16	
Гүйлгээний дугаар		№ : 198632238	
Хүлээн авагч:	Сэлэнгэ	Хүлээн авсан данс:	499273559
Төлөгч РД:	46900830235	Гүйлгээний суваг:	Банк Интерфэйс
Биллийн дугаар:	1240203072674		
<b>Татварын мэдээлэл</b>			
Эзэншигч:	Хандгайтгол	Татварын төрөл:	Газрын төлбөр-Дэд алба
Утас:		Хөрөнгийн дугаар:	7
		Тайлант хугацаа:	2024
		Төлөх дүн:	2992179
Төлбөр хийсэн данс : 470042272		Нийт төлсөн дүн : 2992179	
Гүйлгээний утга : 1240203072674 46900830235 Хандгайтгол 470042272			
<b>ТАТВАР ТӨЛБӨРИЙН ШИМТГЭЛ Б/БУС ТЕЛЛЕР - 500 MNT</b>			
Татвараа хугацаанд нь төлсөн танд баярлалаа. Татвартай холбоотой асуудал байвал дараах хаягаар хандана уу! 1800-1288, INFO@MTA.MN.			
Хянасан :	Теллер :	Харилцагч :	

Татвар төлбөр

Татвар төлбөр Огноо: 2025-06-06 19:41

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК- Most Money Татвар төлөлт**

Гүйлгээний дугаар № : 199485143

Хүлээн авагч:	Сэлэнгэ	Хүлээн авсан данс:	499273559
Төлөгч РД:	46900830235	Гүйлгээний суваг:	Банк Интерфэйс
Биллийн дугаар:	1240203073417		

**Татварын мэдээлэл**

Эзэмшигч: Хандгайтгол Татварын төрөл: Газрын төлбөр-Дэд алба Тайланг хугацаа: 2024

Утас: Хөрөнгийн дугаар: 7 Төлөх дүн: 2992179

**Төлбөр хийсэн данс : 470042272** **Нийт төлсөн дүн : 2992179**

Гүйлгээний утга : 1240203073417 46900830235 Хандгайтгол 470042272 **ТАТВАР ТӨЛБӨРИЙН ШИМТГЭЛ Б/БУС ТЭЛЛЕР - 500 MNT**

Татвараа хугацаанд нь төлсөн танд баярлалаа. Татвартай холбоотой асуудал байвал дараах хаягаар хандана уу! 1800-1288, INFO@MTA.MN.

Хянасан : ..... Теллер : ..... Харилцагч :

ХХБанк

Дорнод Уулс Банк ХХК

Харилцагчийн үйлчилгээний дивизон

№ 12

элийн задаргаа: -



1240203073417

УБЕХ маяг №:  
Статистикийн төв газар зөвшөөрснөөр  
УБЕХ-ны даргын 1986 оны 6-р сарын  
3/205 тоот тушаалаар батлав.

Төлбөрийн даалгавар № 501

2025 он 06 сар 06 өдөр

		Дансны дугаар	Дүн
Төлөгч	<i>Хандгайт гол ХХК</i>	Дебет	<b>2,992,179.00</b>
Банк	<i>Худалдаа хөгжлийн банк</i>	<i>470042272</i>	
Хүлээн авагч	<i>Сэлэнгэ татвар</i>	Кредит	
Банк	<i>Нэхэмжлэхийн дугаар</i>	<i>1240203073417</i>	
(Хоёр сая есөн зуун ерөн хоёр мянга нэг зуун далан есөн төгрөг 00 мөнгө)			... хоногийн хувийн торгууль ... төс ... мөн

(мөнгөн дүн үсгээр)

Төлбөрийн зориулалт: (Барааны болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн нэр)

<i>Газрын төлбөр-Дэд алба- 2024-3 улирал хандгайт гол 2059681</i>	Гүйлгээний утга
Дагалдах баримтын дугаар №	

тамга Дарга .....

Нягтлан бодогч .....

Банкинд гүйлгээ хийсэн  
...он...сар...өдөр  
(тэмдэг, гарын үсэг)





## АТВАРЫН АЛБА:

гварын алба: Сэлэнгэ

гварын дэд алба: Ерөө

йлант хугацаа: 2024 - 1

пөх дүн: 5,337,339.00 ₮

гварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба

лбөр хураамжийн төрөл: -

рлийн задаргаа: -



1240203075313

## ТАТВАР ТӨЛӨГЧ:

Регистр /ТТД: 2059681 / 46900830235

Татвар төлөгчийн нэр: Хандгайтгол

Нэхэмжлэх үүсгэсэн огноо: 2024-02-08 17:53:46

Төлөх огноо: 2024-02-08 17:53:46



30/09/2025, 20:01

Шилжүүлгийн мэдээлэл

## Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2025.09.30 19:47:29

## Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 282580309

Системийн огноо: 2025.09.30

Нэр: ДОРЖПҮРЭВ ЭРДЭНЭГЭРЭЛ

Илгээгч	Дансны дугаар:	Нэр	Дүн	Ханш
	470001838	ДОРЖПҮРЭВ ЭРДЭНЭГЭРЭЛ	5,337,339.00 MNT	1.00
/ таван сая гурван зуун гучин долоон мянга гурван зуун гучин есөн төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар:	Банкны нэр	Дүн	Ханш
	040000	Худалдаа Хөгжлийн Банк	5,337,339.00 MNT	1.00
	Дансны дугаар	Нэр		

Гүйлгээний утга:

ЕВ -1240203075313-Газрын төлбөр-Дэд алба-Сэлэнгэ

## Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо: \_\_\_\_ Он \_\_\_\_ Сар \_\_\_\_ Өдөр



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН  
НУТАГТ “БАЯНГОЛЫН ОРДЫН БАРУУН  
ХҮДРИЙН БИЕТИЙН VI ОРД” НЭРТЭЙ  
ИЛ УУРХАЙН ТӨСЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

**2025 ОН**

**Гүйцэтгэгч: Эко-Акюрэси ХХК**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ “БАЯНГОЛЫН ОРДЫН БАРУУН  
ХҮДРИЙН БИЕТИЙН VI ОРД” НЭРТЭЙ ИЛ УУРХАЙН ТӨСЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

Гүйцэтгэгч: Эко-Акюрэси ХХК  
06/10/2025

ГҮЙЦЭТГЭСЭН:



ЭКО-АКЮРЭСИ ХХК-ИЙН АХЛАХ  
АУДИТОР М.ОТГОНЦЭЦЭГ

2025 он

## АГУУЛГА

АГУУЛГА .....	1
ТОВЧИЛСОН ҮГС .....	3
ХУРААНГУЙ .....	4
НЭГ. ОРШИЛ.....	6
1.1 БОА-ЫН ЗОРИЛГО .....	6
1.2 БОА-ЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ШАЛГУУР.....	7
1.3 БОА-ЫН БАГ .....	7
1.4 БОА-ЫН АРГАЧЛАЛ, ДЭС ДАРААЛАЛ .....	7
1.5 БОА-ЫН ХЯЗГААРЛАЛ.....	9
ХОЁР. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ .....	10
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ДҮН .....	13
3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО .....	14
3.2 АГААРЫН ЧАНАР.....	18
3.3 ГАЗАР АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ.....	21
3.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ .....	25
3.5 УСНЫ МЕНЕЖМЕНТ.....	28
3.6 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТ .....	32
ДӨРӨВ. БОА-ЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	34
4.1 ДҮГНЭЛТ.....	34
4.2 ЗӨВЛӨМЖ.....	40
4.3 ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	42
АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	43
ТАВ. ХАВСРАЛТУУД .....	44
5.1 ГЭРЭЛ ЗУРАГ .....	44

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЯНГОЛЫН ЭХ  
ХӨНДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт 2. БОА-ын шалгуур.....	7
Хүснэгт 3. Зөрчлийн эрсдэлийн зэрэглэл.....	9
Хүснэгт 5. БОА-ын дүн: Байгаль орчны удирдлагын тогтолцоо.....	15
Хүснэгт 6. БОА-ын дүн: Агаарын чанар.....	19
Хүснэгт 7. БОА-ын: Газар ашиглалт, нөхөн сэргээлт.....	22
Хүснэгт 8. БОА-ын дүн: Хог хаягдлын менежмент.....	26
Хүснэгт 10. Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө.....	42
Зураг 1. <i>Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын</i> .....	10
Зураг 2. БОА-ын дүн.....	13

## ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
АтХ	Агаарын тухай хууль
БО	Байгаль орчны
БОА	Байгаль орчны аудит
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОНБУТХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай хууль
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОМТБХБТЖ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
БОХтХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГтХ	Газрын тухай хууль
ГУХЭ	Гадаад улсын хуулийн этгээд
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
км	километр
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНӨААТУУГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар
УЦУОШТ	Ус цаг уур орчны шинжилгээний төв
тн	тонн
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХХЦСтХ	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХтХ	Хог хаягдлын тухай хууль
УУХҮЯ	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам
УАХТЖ	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
ш	ширхэг
ШТС	Шатахуун түгээх станц
ШТМ	Шатах тослох материал

## ХУРААНГУЙ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10<sup>1</sup>-д байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага бүр хоёр жил тутамд Байгаль орчны аудитыг (БОА) мэргэжлийн байгууллагаар хийлгэх тухай заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах Баянголын эх хөндий газарт байрлах Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 дугаартай төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн Байгаль орчны аудитыг Эко-Акюрэси ХХК-ийн БОА-ын баг 2025 оны 09 дугаар сарын 06-ны өдрөөс 10 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл 30 хоногт гүйцэтгэж, тайланг захиалагч талд хүлээлгэн өгөв.

Компани зайлшгүй мөрдөх шаардлагатай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, төслийн БОННУ, БОМТ-ний хэрэгжилтэнд үнэлгээ өгч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өгөхийг зорьж ажиллав. Төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн талбайд БОА-ын газар дээрх үзлэгийг захиалагчийн санал болгосон цэгүүд болон хайгуулын үйл ажиллагаанд өртөөгүй байгалийн бүрдэл хэсэгт санамсаргүй, түүврийн аргаар гүйцэтгэгч сонгож дараах авсан цэгүүд дээр гүйцэтгэсэн болно.

Хээрийн ажлын үед талбайн бодит нөхцөл байдлыг тодорхойлон үзэж танилцаж, фото зургаар баримтжуулан, зураглал хийсэн. Хандгайт гол ХХК-ийн төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд дараах байршлуудад байгаль орчны аудитын газар дээрх үзлэг хийсэн.

Энэ удаагийн БОА-ын 6 чиглэлээр 83 шалгуур сонгон авч, шалгуур бүрт холбогдох нотлогоонд үндэслэн үнэлэхэд 80 биелсэн буюу **94** хувийн биелэлттэй үнэлэгдэв.

Биелээгүй 3 зүйл буюу 4%, үнэлэх боломжгүй 2 зүйл буюу 2% эзэлж байна. БОУТ 100%, Агаарын чанар 91%, Газар ашиглалт, нөхөн сэргээлт 78%, Хог хаягдлын менежмент 100%, Ус ашиглалт 100%, Биологийн олон янз байдлын хамгааллын менежмент 100% гүйцэтгэлтэй үнэлэгдлээ.

Хандгайт гол ХХК нь 2024-2025 онд гүйцэтгэсэн төмрийн хүдэр олборлолтын үйл ажиллагаанд компанийн дагаж мөрдвөл зохих байгаль орчны холбогдох хууль тогтоомж, стандарт, журмыг **"Маш сайн"** биелүүлж ажиллаж байна.

Хандгайт гол ХХК нь төмрийн хүдрийн ашиглалтын үйл ажиллагааг үргэлжлүүлэх тохиолдолд БОА-ын зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөнд оруулсан (Хүснэгт10) зайлшгүй биелүүлэх үүрэг хүлээж буй 11 зөвлөмжийг хэрэгжүүлж, энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай тайлангаа зөвлөмжид заасан хугацаанд Сэлэнгэ аймгийн БОАЖГ-т хүргүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч зөвлөмж хэрэгжүүлэх хүснэгтэд тусгагдсан 11 зөвлөмжийг биелүүлэх арга хэмжээг даруй авч хэрэгжүүлж ажиллах шаардлагатай бөгөөд биелэлтэд нь хяналт тавих дотоод хяналтыг бий болгон, биелэлтийн талаар холбогдох тайлан мэдээнд тусгах ажлыг цаг алдалгүй зохион байгуулах нь зүйтэй. Үлдсэн 8 зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч биелүүлсэн тохиолдолд төслийн байгаль орчны гүйцэтгэл сайжрах ач холбогдолтой.

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ийн ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЯНГОЛЫН ЭХ ХӨНДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

БОА-ын шалгуур хангаагүй зүйлс

Д/д	Код	Биелэгдээгүй зүйлс	Эрсдэлийн зэрэг	Зөрчлийн төрөл
<b>Агаарын чанарын менежмент</b>				
1	FB10	Дуу шингээх ба тусгаарлах хэрэгсэл ашиглан шуугианы тархалтыг хязгаарлах БОННУ-ний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	Бохирдлоос сэргийлэх
<b>Газар ашиглалт, нөхөн сэргээлтийн менежмент</b>				
2	FC10	Ослын үед бохирдсон хөрсөн бүрхэвчийг саармагжуулах, нөхөн сэргээх гарын авлага боловсруулах БОННУ-ний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	Менежмент
3	FC14	Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх.	2	Бохирдлоос сэргийлэх

## НЭГ. ОРШИЛ

Монгол улсын нутаг дэвсгэрт байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу хоёр жил тутамд БОА хийлгэх заалтын хэрэгжилтийн хүрээнд Хандгайт гол ХХК-ийн хэрэгжүүлж буй Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий газарт байрлах Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд Байгаль орчны аудитын 2023-2024 онд хийгдсэн ажлуудын гүйцэтгэлд талуудын хооронд 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан Байгаль орчны аудитын ажил гүйцэтгэх гэрээний дагуу Байгаль орчны холбогдох хуулиудын хэрэгжилтийн нийцлийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, цаашид олборлолтын үйл ажиллагааны үеэр байгаль орчны хамгааллын талаар анхаарч ажиллах зөвлөмж боловсруулж, саналаа өгөх зорилгоор Эко-Акюрэси ХХК-ийн БОА-ын баг 2025 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл 30 хоногт энэхүү БОА-ын тайланг боловсрууллаа.

### 1.1 БОА-ЫН ЗОРИЛГО

Энэ удаагийн БОА-ын зорилго нь:

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий газарт байрлах Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд Байгаль орчны аудитыг дараах үндсэн чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Байгаль орчны удирдлагын тогтолцоо
- Агаарын чанар
- Ус ашиглалт
- Газар ашиглалт, нөхөн сэргээлт
- Хог хаягдлын менежмент
- Биологийн олон янз байдлын менежмент

Байгаль орчны аудитын тайлангийн төслийг захиалагч талд танилцуулж, хүлээлгэн өгөх үе шат:

- Үйл ажиллагааны үед анхаарч, хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулж, саналаа өгөх.
- БОА-ын газар дээрх үзлэгийг төмрийн хүдрийн олборлолтын талбай болон ажилтнуудын амрах кемп зэргийг бүхэлд нь хэрэгжүүлнэ. Үүнд:
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ), Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний хэрэгжилтэнд үнэлгээ, зөвлөмж өгөх:
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий газарт байрлах Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд Байгаль орчны аудитын боловсруулах, захиалагч талд танилцуулах болно.

## 1.2 БОА-ЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ШАЛГУУР

Энэ удаагийн БОА-ыг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий газарт байрлах Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд Байгаль орчны холбогдох хуулиудын нийцлийн үнэлгээ хийх байгаль орчны гүйцэтгэл, нөхөн сэргээлтийн чанар, үр дүнд байгаль орчны удирдлагын тогтолцоо, агаарын чанар, нөхөн сэргээлт, хөрсний чанар, үс ашиглалт, биологийн олон янз байдлын менежмент, хог хаягдлын менежментийн чиглэлд гүйцэтгэв. Байгаль орчны холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт болон төслийн БОННУ-ний тайлан, БОМТ зэрэг баримт бичигт туссан шаардлагуудыг БОА-ын шалгуур үзүүлэлт болгон авав. Нийт 6 төрлийн 83 шалгуурыг энэ удаагийн БОА-ын шалгуур болгон авч үзлээ.

Хүснэгт 1. БОА-ын шалгуур

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд	Шалгуурын тоо
1	Байгаль орчны удирдлагын тогтолцоо	16
2	Агаарын чанар	12
3	Нөхөн сэргээлт, хөрсний чанарын менежмент	20
4	Хог хаягдлын менежмент	14
5	Усны менежмент	15
6	Биологийн олон янз байдлын менежмент	6

## 1.3 БОА-ЫН БАГ

БОА багийг ахлах аудитор М.Отгонцэцэг удирдаж ажиллав.

## 1.4 БОА-ЫН АРГАЧЛАЛ, ДЭС ДАРААЛАЛ

ISO 19011: 2018 Удирдлагын тогтолцооны аудит хийх заавар, олон улсын стандарт, Эко-Акюрэси ХХК-ийн захирлын 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 20/02 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны аудиторын ажиллах журам”-ыг мөрдлөг болгов.

Бэлтгэл шат

1. Судалгаа хийх- БОА захиалагч буюу БОА хийлгэгч байгууллагын үйл ажиллагааг судлах, байгууллагаас шаардлагатай бичиг баримтыг гаргуулан судалж танилцах.
2. БОА-ын шалгуур, үзүүлэлт боловсруулж, батлах - Төслийн үйл ажиллагаанд дагаж мөрдвөл зохих хууль, журам, стандарт, төслийн БОННУ, БОМТ, байгууллагын байгаль орчны бодлого, дотоод журам, дүрэм зэргийг судлан тухайн байгалийн нөөцийг ашиглан үйл ажиллагаа явуулахдаа заавал биелүүлэх шаардлагатай үзүүлэлтүүдийг тодорхойлох.
3. БОА-ын удирдамж боловсруулж, батлах - БОА-ын шалгуурын дагуу газар дээр хийх аудитын үзлэгийн удирдамж боловсруулж, батлах.

Бичиг баримтын аудит- БОА-ын баг 2025 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлүүлэв.

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ийн эзэмшил MV-021595 дугаартай тусгай зөвшөөрөлтэй баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах “Хандгайт гол” ХХК-ийн MV-021595 тусгай зөвшөөрөл бүхий баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, Эм И Си Эс Зэт Би ХХК
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт баянголын эх хөндий газарт байрлах “Хандгайт гол ХХК” ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан-2021, Дорнын байгаль ХХК
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөл, 2024 оны үс ашиглалтын тайлан
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Газар дээрх үзлэг- БОА-ын баг 2025 оны 09 дүгээр сарын 06-ны өдөрт гүйцэтгэв.

Ажиглалт хийх- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт баянголын эх хөндий газарт байрлах Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 дугаартай төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн төслийн талбайд 2024 онд хийгдсэн ажлуудын байгаль орчны гүйцэтгэлд талуудын хооронд байгуулсан 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн КНГ-2025-08-27 дугаартай гэрээний дагуу Байгаль орчны аудитын газар дээрх үзлэгийг зохион байгуулав. БОА-ын газар дээрх үзлэгийн өмнө төслийн байгаль орчны мэргэжилтэн Б.Батчимэгтэй, БОА-ын газар дээрх үзлэгээр төслийн талбай дээр Уурхай хариуцсан захирал Г.Нэмэхбаяр, ХАБЭА инженер Ц.Дэлгэрмөрөн, кемп менежер М.Хатанбаатар нартай уулзаж, ярилцлага хийж, тайлан боловсруулах үе шатанд ажлын явцыг танилцуулж, зарим тодруулах зүйлсийг танилцуулав.

Тайлагнах шат

1. БОА-ын тайлан гаргах - БОА-ын үр дүнг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдээр ангилав.

БОА-аар илэрсэн зөрчилд эрсдэлийн зэрэглэлийг (Хүснэгт2)-т харуулж, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөний хугацаатай үялдуулав. Илэрсэн зөрчлийн мөн чанарыг багцалж үнэлэх үүднээс дараах төрөлд ангилав. Үүнд:

- Зөвшөөрөл/бүртгэл
- Аюулгүй байдал
- Менежмент
- Бохирдлоос сэргийлэх
- Үүрэг хариуцлага

Хүснэгт 2.Зөрчлийн эрсдэлийн зэрэглэл

		Байгаль орчинд хохирол үчрах магадлал		
		Гарцаагүй	Дунд зэрэг	Бага
Байгаль орчны нөлөөллийн түвшин	Их	3	3	2
	Дунд	3	2	1
	Бага	2	1	1

Өндөр эрсдэлтэй

Дунд эрсдэлтэй

Бага эрсдэлтэй

Тайлангийн төслийг танилцуулах шат


2. БОА-ын тайлангийн төсөл танилцуулах - Цуглуулсан баримт, мэдээлэлд үндэслэн БОА-ын дүгнэлтийг харьцуулсан дүн шинжилгээний аргаар, БОА-ын зөвлөмж, төлөвлөгөөг биелэгдэх боломжид тулгуурлан БОА-ын тайланг боловсруулах явцад БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй ярилцлага хийж, нэмэлт мэдээлэл цуглуулж, тайлангийн төсөл боловсруулсан. Тайлангийн төслийг Уурхай хариуцсан захирал Г.Нэмэхбаяр, БО-ны мэргэжилтэн Б.Батчимэг нарт танилцуулж, БОА-ын тайлангийн төсөлд санал авч, зарим шаардлагатай залруулга, сайжруулалт хийж ажиллав.

### 1.5 БОА-ЫН ХЯЗГААРЛАЛТ

Эко-Акюрэси ХХК-ийн БОА-ын баг 2025 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийг дуустал БОА-ын газар дээрх үзлэг, бичиг баримтын аудит хийх явцад болон БОА-ын тайлан боловсруулах явцад нэмэлт нотолгоо, тайлбар авах үе шатанд ямар нэг БОА-ын хязгаарлалт гараагүй болно.

## ХОЁР. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зураг 1. Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн байршил зураг



**Эко-Акюрэси ХХК** *Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн байршил зураг*

Эх сурвалж: Google earth      Огноо: 2025.09.06

Төслийн нэр: *Баянголын эх хөндийн төмрийн хүдрийг ил аргаар ашиглах*

Төсөл хэрэгжүүлэгч: *Хандгайт гол ХХК*

Төслийн байршил: 198 км, Улаанбаатар хотоос 798 км зайд оршино.

Ашигт малтмалын төрөл: Газрын тосны ашиглалт

Талбайн хэмжээ: 218 км<sup>2</sup>

*Ил уурхайн ажиллах горим:* Баянголын төмрийн хүдрийн баруун хүдрийн биетийн үргэлжлэл Баруун VI ордын ил уурхай, баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг жилд 1000.0 мян.тн-оор сонгов. Эхний жилээс уурхайн хөрс хуулалтыг эхлүүлэх, 2-р жилээс баяжмал үйлдвэрлэж, баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг 100%-д хүргэж үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулахаар төлөвлөв. Ийнхүү тооцоход ил уурхайн ашиглалтын хугацаа 12 жил, баяжуулах үйлдвэрийн ашиглалтын хугацаа мөн 12 жил гарч байна. Ил уурхай ба үйлдвэрийн ажиллагсад 14:14 вахтын системээр (14 хоног амрах, 14 хоног ажиллах) ажиллана. Үйлдвэр, уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжид 12 цагаар ажиллана. Баяжуулах үйлдвэр тасралтгүй ажиллагаатай байна. Ил уурхай нь жилд 273 хоног, 2384.5 цаг ажиллана. Баянголын төмрийн хүдрийн баруун хүдрийн биетийн үргэлжлэл Баруун VI ордын ашиглалтын нийт хугацаанд 25.25 сая.м3 хөрс хуулж, 12.24 сая.тн хүдэр олборлож, энэ нь уулын цулын эзлэхүүнээр 28.10 сая.м3 байна. Ордын дундаж хөрс хуулалтын итгэлцүүр 2.06 м3/тн байх бөгөөд ил уурхайгаас жилд 1000,000 тн хүдэр олборлож, Баяжуулах үйлдвэрийн агуулахад агуулгыг дундажлан, жигдрүүлж өгнө. <sup>1</sup>

*Ил уурхайн тоног төхөөрөмж:* Баянголын төмрийн хүдрийн баруун хүдрийн биетийн үргэлжлэл Баруун VI ордод хөрс ба хүдрийг өрөмдлөг тэсэлгээгээр сийрэгжүүлж авто тээвэртэй ашиглалтын системээр олборлоно. Өрөмдлөгийн ажилд Atlas Copco фирмийн 1302 маркийн 150 мм диаметр бүхий өрмийн хошуутай, 285 квт-ын хөдөлгүүрийн чадалтай цохилтод өрмийн машин 2 ш, хөрс хуулалтад 5 м3 шанагатай, CAT 390F маркийн шууд утгуурт экскаватор 3 ш, хүдэр олборлолтод 2.8 м3 шанагатай, CAT 349 маркийн шууд утгуурт экскаватор 1 ш, хөрс тээвэрлэлтэд 20 м3 тэвшний багтаамжтай, 55 тн даацтай LGMG-MT 86 маркийн өөрөө буулгагч автосамосвал 15 ш, хүдэр тээвэрлэлтэд 17 м3 тэвшний багтаамжтай, 40 тн даацтай HOWO-40 маркийн өөрөө буулгагч автосамосвал 4 ш, хөрсний овоолго түрэх, зам талбайн туслах ажилд 240 квт-ын хүчин чадалтай D-8 маркийн бульдозер 1 ш, CAT-14M маркийн автогрейдр 1 ш, уурхайн дотоод замын үсалгааны ажилд 20 тн даацтай HOWO автосамосвал 1 ш ажиллана. Хүдэр баяжуулах үйлдвэрт бутлуур тэжээх ажилд 3 м3 шанагатай, ZL50F маркийн утгуурт ачигч 1 ш тус тус хэрэгтэй байна. <sup>2</sup>

*Өрөмдлөг тэсэлгээний ажил:* Тус ордын агуулагч ба хажуугийн чулуулаг нь доод пермийн боржин, кварцын порфир, кварцын моноцит, моноцит байх ба боржин нь түгээмэл тархсан. Агуулагч чулуулаг болон хүдрийн биет нь нь физик, механик шинж чанарын хувьд В.В. Ржевскийн ангиллаар чулуулгийн өрөмдөгдөх зэрэглэлийн хувьд 14-25 буюу III-V ангид багтана. Чулуулгийн бат бэх М.М. Протодьяконовын ангиллаар бат бэх /f=10-19/ буюу I-III зэрэглэлд хамаарна. Дотоод үрэлтийн өнцөг нь 33-35о байна. Чулуулгийн шинж чанараас ордын хөрс болон хүдрийн биет нэлээд хатуу тұл уулын ажлыг жигд найдвартай явуулах үүднээс хөрсөнд өрөмдлөг тэсэлгээ шаардлагатай. <sup>3</sup>

<sup>1</sup> Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ийн MV-021595 тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, Эм И Си Эс Зэт Би ХХК

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Мөн тэнд


*Тэсэлгээний ажил:* Тэсэлгээний ажилд дотооддоо үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” “Аянга” зэрэг усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг 7 хоногт 1 удаа явуулахаар тооцсон. Агуулахын хэмжээ нь “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заасан заалтын дагуу хийгдэнэ. Уурхайн 3 сарын хэрэгцээнээс хэтрүүлэхгүй тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тэсрэх материалын агуулахад хадгална. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг Улаанбаатар хотоос тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Нэг удаагийн тэсэлгээний ажил уурхайн 7 хоногийн ажлыг хангана. Жилд хөрсний мөргөцөгт 167940 м, хүдрийн мөргөцөгт 48060 м өрөмдлөг хийнэ. Тэсэлгээний үр дүнг сайжруулах, хөрсний тархалт, аваар ослыг багасгах 20 мс-ийн хором удаашруулагч хэрэглэнэ.

*БОА-ын шалгуур хангаагүй зүйлс*

Д/д	Код	Биелэгдээгүй зүйлс	Эрсдэлийн зэрэг	Зөрчлийн төрөл
<b>Агаарын чанарын менежмент</b>				
1	FB10	Дуу шингээх ба тусгаарлах хэрэгсэл ашиглан шуугианы тархалтыг хязгаарлах БОННУ-ний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	Бохирдлоос сэргийлэх
<b>Газар ашиглалт, нөхөн сэргээлтийн менежмент</b>				
2	FC10	Ослын үед бохирдсон хөрсөн бүрхэвчийг саармагжуулах, нөхөн сэргээх гарын авлага боловсруулах БОННУ-ний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	Менежмент
3	FC14	Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх.	2	Бохирдлоос сэргийлэх

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ДҮН

Зураг 2. БОА-ын дүн



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий газарт байрлах Хандгайт гол ХХК-ийн эзэмшил MV-021595 дугаартай төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн төслийн талбайд 2024-2025 онд гүйцэтгэсэн төмрийн хүдэр олборлолтын үйл ажиллагааны байгаль орчны гүйцэтгэлд энэ удаагийн байгаль орчны аудитыг БОА-ын 6 чиглэлээр 83 шалгуур сонгон авч, шалгуур бүрт холбогдох нотлогоонд үндэслэн үнэлэхэд 80 нь биелсэн буюу 94 хувьтай үнэлэгдэв. Биелээгүй 3 зүйл буюу 4%, үнэлэх боломжгүй 2 зүйл буюу 2% эзэлж байна.

БОУТ 95%, Агаарын чанар 91%, Газар ашиглалт, нөхөн сэргээлтийн менежмент 78%, Хог хаягдлын менежмент 100%, Ус ашиглалт 100%, Биологийн олон янз байдлын хамгааллын менежмент 100% гүйцэтгэлтэй үнэлэгдлээ. БОА-ын үзлэг шалгалтаар зөрчил, дутагдал илрээгүй тул цаашид компанийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дагаж мөрдөх нь төслийн байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах ач холбогдолтой зөвлөмжийг тайлангийн зөвлөмж хэсэгт тусгасан.

Хандгайт гол ХХК нь 2024-2025 онд гүйцэтгэсэн төмрийн хүдэр олборлолтын үйл ажиллагаанд компанийн дагаж мөрдвөл зохих байгаль орчин, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн болон холбогдох хууль тогтоомжийг "Маш сайн" биелүүлж ажиллаж байна.

### 3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Хандгайт гол ХХК-ийн MV-021595 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг 2021 онд Эм И Си Эс Зэт Би ХХК гүйцэтгэсэн байна. Тайланд 5 жилээр боловсруулсан төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу жил бүр буюу 2024-2025 онд боловсруулж, хэрэгжүүлсэн БОМТ нь нь төслийн байгаль орчны удирдлагын тогтолцоог бүрдүүлж байна.

Хандгайт гол ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших 543.33 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах MV-021595 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд “Баянголын эх хөндий-ын төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах зорилготой төмрийн хүдэр олборлож, төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах аргаар баяжуулан, баяжмал үйлдвэрлэж гадаад зах зээлд экспортлон борлуулахад чиглэнэ. Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах, хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллага Кеестон ресурс ХХК боловсруулж Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны 7-р сарын 20-р Т/135 тушаалаар Техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан байна.

Хандгайт гол ХХК нь төмрийн хүдрийг ил аргаар ашиглах үйл ажиллагааны бэлтгэл хангаж, 2024 оноос олборлолтын үйл ажиллагааг эхлүүлж, байгаль орчинд ээлтэй арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг хангаж, Байгаль орчны удирдлагын тогтолцоог амжилтай хэрэгжүүлж ажиллаж байна.

*Мэргэжлийн байгууллагатай:* Хандгайт гол ХХК нь байгаль орчны аудитын Эко-Акюрэси ХХК, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, хяналт мониторинг боловсруулж, хэрэгжүүлэх Эм И Си Эс Зэт Би ХХК, Сэлэнгэ аймгийн УЦУОШТ, Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ, Хараа-Ерөө голын сав газрын захиргаа, Утра камел Транс ХХК зэрэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Ашиглалтын жилүүдэд 1,000 мян.тн төмрийн хүдрийн хуурай баяжмал үйлдвэрлэнэ. Уурхайн гадаад тээврээр жилд дунджаар 587.98 мян.тн баяжмал тээвэрлэх шаардлагатай байна. Баянголын баруун хүдрийн биетийн төмрийн хүдрийн ордын гадаад тээвэр нь уурхайгаас Баянголын төмөр замын өртөө хүртэл 12.8 км шороон замаар тээвэрлэх бөгөөд үг өртөөнөөс БНХАУ-ын Эрээн боомт хүртэл төмөр замаар тээвэрлэнэ.

*Нийгмийн хариуцлага:* Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг дарга Э.Одгаравтай Хандгайт гол ХХК-ийн 2025 оны нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж ажиллаж байна. Энэхүү гэрээний хүрээнд орон нутгийн хөгжлийг дэмжих тодорхой заалтууд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

*ХАБЭА, сургалт:* Ажилчдын хөдөлмөр хамгааллын хамгаалах нэг бүрийн хэрэгслээр хангаж, инженер, техникийн ажилтнуудын, байгаль орчны, шинэ ажилтны, аюулгүй ажиллагааны заавар, сургалт зохион байгуулж ажиллаж байна.

**ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгт 3. БОА-ын дүн: Байгаль орчны удирдлагын тогтолцоо

Код	БОА-ын шалгуур	БОА-ын үнэлэмж	Нөхцөл байдлын тодорхойлолт	Нотломж
FA1	Байгаль орчныг хамгаалах тухай хууль (БОХТХ) 7.1 Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.	Биелсэн	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Хандгайт гол ХХК-ийн MV-021595 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, Эм И Си Эс Зэт Би ХХК 2021 онд боловсруулсан байна.	EA1 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Хандгайт гол ХХК-ийн MV-021595 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, Эм И Си Эс Зэт Би ХХК 2021 EA2 БОА-ын ажиглалт
FA2	БОНУЖ 7.2.1 төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд боловсруулан батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг удирдлага болгон тухайн жилд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулан, ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан эрх бүхий байгууллагаар батлуулна. Уг төлөвлөгөөг шаардлагатай тохиолдолд эрх бүхий ААНБ-тай хамтран боловсруулах.	Биелсэн	Төсөл хэрэгжүүлэгч 2024, 2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	EA3 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт оршиж Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан
FA3	(БОХТХ) 9.4 Нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй. БОМТБХТЖ 3.1 Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан баталснаар төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ.	Биелсэн	Төсөл хэрэгжүүлэгч 2024 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, хэрэгжилтэд нийт 457072.0 мян.төг зарцуулсан байна.	EA4 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт оршиж Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах
FA4		Биелсэн	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан баталсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтийн тайланг боловсруулсан байв.	

**ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

FA5	<p>БОХТХ 10.1 Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх, зөвлөмжид заасан хугацаанд тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.</p>	Биелсэн	<p>Хандгайт гол ХХК нь 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн КНГ-2025-08-27 дугаартай Байгаль орчны аудит хийх үйлчилгээний гэрээгээр төслийн БОА-ыг Эко-Акиорэси ХХК гүйцэтгүүлж байна.</p>	<p>төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан EA5.1 Байгаль орчны аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ, Хандгайт гол ХХК, Эко-Акиорэси ХХК, 2025.08.27</p>
FA6	<p>БОХТХ 31.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх</p>	Биелсэн	<p>Энэ удаагийн БОА-ын хамрах хугацаанд улсын байцаагчийн албан шаардлага ирээгүй гэв.</p>	<p>EA6 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага</p>
FA7	<p>БОХТХ 31.7 Бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх</p>	Биелсэн	<p>БОМТ-ний хэрэгжилтийг хангах байгаль орчны мэргэжилтэнтэй. Үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжийг томилсон байв.</p>	<p>EA7 БОА-ын ажиглалт</p>
FA8	<p>БОНБУТХ 9.9 Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.</p>	Биелсэн	<p>Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны БОМТ боловсруулж, БО-ны нөхөн сэргээх барьцаа төлбөр шилжүүлсэн байв.</p>	<p>EA8 БОА-ын ажиглалт</p>
FA9	<p>БОНБУТХ 14.1.2 Байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх</p>	Биелсэн	<p>Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны БОМТ боловсруулж, БО-ны нөхөн сэргээх барьцаа төлбөр шилжүүлсэн байв.</p>	<p>EA9 БОА-ын ажиглалт</p>
FA10	<p>БОНБУТХ 14.1.2 байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон</p>	Биелсэн	<p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн иргэд</p>	<p>EA10 БОА-ын ажиглалт</p>

**ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

FA11	<p>нүгтийн захиргаа, төслийн нөлөөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах</p> <p>БОМТБХБТЖ 4.1 Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гарган, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.</p>	Биелсэн	<p>захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнасан байв.</p> <p>2022 оны 09-р сарын 23-ны өдөр сумын ЗДТ-ын мэргэжилтнүүд, сумын иргэдийн төлөөлөгчөөс ирж уурхайн үйл ажиллагаа болон хийж гүйцэтгэсэн ажлуудтай танилцсан. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн БОМТ-г биелүүлж, үр дүнг тусгасан биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд нь тайлагнасан байна.</p>	EA11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн ажлын хэсгийн дүгнэх хүүдас, №13 2024.11.20
FA12	<p>БОННУ-ний зөвлөмж</p> <p>Хүдэр бутлах, нунтаглах, баяжуулах хэсэгт ажилладаг ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд тогтмол хамруулах хэрэгтэй.</p>	Биелсэн	<p>Хүдэр бутлах, нунтаглах, баяжуулах хэсэгт ажилладаг ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд тогтмол хамруулах ажлыг жил бүр зохион байгуулж байна.</p>	EA12 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага
FA13	<p>БОННУ-ний зөвлөмж</p> <p>Бүх ажилчдад болзошгүй осол эрсдэлийн тухай ойлголтыг өгч, түүнээс урьдчилсан сэргийлэх, бууруулах хамгаалах арга хэмжээний анхан шатны мэдлэгийг эзэмшүүлж, дасгал сургуулилт хийх.</p>	Биелсэн	<p>Болзошгүй осол эрсдэлийн тухай ойлголтыг өгч, түүнээс урьдчилсан сэргийлэх, бууруулах хамгаалах арга хэмжээний анхан шатны мэдлэгийг эзэмшүүлэх сургалт зохион байгуулдаг.</p>	EA13 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага
FA14	<p>БОННУ-ний зөвлөмж</p> <p>Үйл ажиллагааны эрсдэлийг хянах зорилгоор ажил үүргээ аюулгүй явуулахад шаардлагатай сургалт, үр чадвар, мэдлэгийг ажилтан бүрт олгож, ажилтны ажлын байранд өртөх боломж бүхий аюулуудыг таньж үнэлгээ хийдэг чадвартай болгох.</p>	Биелсэн	<p>Үйл ажиллагааны эрсдэлийг хянах, ажил үүргээ аюулгүй явуулахад шаардлагатай сургалт, үр чадвар, мэдлэгийг ажилтан бүрт олгож, ажилтны ажлын байранд өртөх боломж бүхий аюулуудыг таньж үнэлгээ хийдэг чадвартай болгохоор эрсдэлийн үнэлгээ хийж байна.</p>	EA14 Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан
FA15	<p>БОННУ-ний зөвлөмж</p> <p>Гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журамтай байх.</p>	Биелсэн	<p>Гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам боловсруулж, төсөлд санал авч байна.</p>	EA15 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага
FA16	<p>БОННУ-ний зөвлөмж</p> <p>Ажилтан албан хаагчдаа гал түймрийн голомтонд үүрэг гүйцэтгэх, аврах үйл ажиллагаа явуулах, гал түймрийн тухай ойлголт, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг хэрхэн ашиглах зэрэг сэдвээр мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах.</p>	Биелсэн	<p>Инженер техникийн ажилтнууд болон шинэ ажилчдад гал түймрийн голомтонд үүрэг гүйцэтгэх, аврах үйл ажиллагаа явуулах, гал түймрийн тухай ойлголт, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг хэрхэн ашиглах зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан байна.</p>	EA16 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

### 3.2 АГААРЫН ЧАНАР

Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл: Хандгайт Гол ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Баянголын төмрийн хүдрийн Баруун VI ордыг ил аргаар төмрийн хүдэр олборлож, хуурай нойтон аргаар боловсруулахаар төлөвлөсөн. Төсөл хэрэгжих 12 жилийн хугацаанд уурхайн ухаашаас 25.2 сая.м<sup>3</sup> хөрс болон 12.24 сая.тн төмрийн хүдэр олборлоно. Уурхайг ил аргаар тээврийн хэрэгсэл ашиглан олборлоно. Ил уурхайн олборлолтын үйл ажиллагаас уурхайн ухааш олборлолт, хүнд механизмуудын хөдөлгөөн, хүдэр болон хөрсийг ачих, буулгах, тээвэрлэлтээс тоос, тоосонцор үүсдэг.

*Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, Уурхайн тээврийн зам:* Уурхайн гол агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь уурхайн тээврийн замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилт юм. Уурхайн тээвэрлэлт нь овоолго тээврийн хүнд даацын тээвэр болон үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бүрдэнэ.

Тээврийн замаас үүсэх тоос, тоосонцрын ялгарлын хэмжээг Америкийн нэгдсэн улсын Байгаль орчныг Хамгаалах Агентлаг AP-42 section 13.2.2 Unpaved Road эх үүсвэрийн гарын авлагын аргазүйг ашиглан тооцоолов. Тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа нийт тоос, тоосонцрын 80%-с илүүг үүсгэдэг.Үйлдвэр дотоод тээвэрлэлт нь овоолго болон хүдрийн бункер хооронд хийгдэх хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн юм.

*Ухааш олборлолт:* Уурхайн үндсэн үйл ажиллагаа буюу олборлолт уурхайн ухааш дотор явагддаг. Уулын цулыг үтгүүрт ачигч буюу экскаватороор тээврийн хэрэгсэлд ачихад хялбар болгохын тулд уурхайн хүдэр болон хөрсний биетэд өрөмдөж тэсрэх бодисоор тэсэлгээ хийнэ. Тэсэлгээгээр суларсан хөрс, хүдрийг тээврийн хэрэгсэлд хутгүүрт ачигчаар ачдаг тул өрөмдлөг, тэсэлгээ, ухааж ачих, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүснэ.

*Овоолго үүсэх:* Ухааш олборлолтоор тээврийн хэрэгсэл уулын цулыг уурхайн овоолго дээр тээвэрлэж буулгана.Тээврийн хэрэгсэлээс овоолгод материал буулгахад болон овоолго үүсгэх автомеханизм болох экскаваторийн үйл ажиллагаар орчны агаарт тоос, тоосонцор ялгарна.

*Баяжуулах үйлдвэрийн анлан ялгах хэсэг:* Ил уурхайн ухаашаас олборлосон хүдрийг баяжуулах үйлдвэрийн технологид нийцүүлэн тохирсон хэмжээнд хүртэл механик боловсруулалт буюу бутлах, шигших үе шат бүрээс тоос, тоосонцор ялгарна.

*Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагч:* Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг.Түлшний найрлаганд агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч, дэгдэмхий органик нэгдлүүдээс шаталтаар агаарт хүхэрийн ислүүд, нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд, метан болон метан агуулаагүй ууршимтгай органик, нэгдлүүд болон азотын ислүүд ялгардаг.<sup>4</sup>

<sup>4</sup> Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хандгайт гол" ХХК-ийн MV-021595 тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, Эм И Си Эс Зэт Би ХХК

**ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БУХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгт 4. БОА-ын дүн: Агаарын чанар

Код	БОА-ын шалгуур	БОА-ын үнэлэмж	Нөхцөл байдлын тодорхойлолт	Нотломж
FB1	Агаарын тухай хууль (АТХ) 9.1.1 Агаарын хууль тогтоомж, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, Засаг даргын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;	Биелсэн	Агаарын хууль тогтоомж зөрчсөн талаар ямар нэгэн шийдвэр, шаардлага БОА-ын хамрах хугацаанд ирээгүй байна.	EB1 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага
FB2	АТХ 9.1.4 ААНБ нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах	Биелсэн	Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн байгууллага Сэлэнгэ аймгийн УЦУОШТ гэрээний дагуу гүйцэтгэсэн байна.	EB2 Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ хийх талаар байгуулсан гэрээ-43/, Сэлэнгэ аймгийн УЦУОШТ, 2024-09-10
FB3	АТХ 9.1.6 Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах АТХ 9.1.2 Агаар хамгаалахтай холбоотой дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах АТХ 9.1.7 Агаарын бохирдлыг бууруулах талаарх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх	Биелсэн	Гадаад орчны агаарын чанарын үзүүлэлтийг хянах ажлыг Сэлэнгэ аймгийн УЦУОШТ гэрээний дагуу гүйцэтгэсэн байна. Дээжний үр дүнгээс харахад Агаарын чанарын стандарт MNS4585-2016 стандарт дах хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтгүй байна.	EB3 Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ хийх талаар байгуулсан гэрээ-43/, Сэлэнгэ аймгийн УЦУОШТ, 2024-09-10 Хавсралт. Хандгайт гол ХХК-д хийгдэх байгаль орчны шинжилгээ хийх төлөвлөгөө.
FB4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль 9.3 Төлбөр төлөгч нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 сарын 01 өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлөх энэ тухай тэмдэглэгээ хийлгэх	Биелсэн	Хандгайт гол ХХК тээврийн хэрэгслийн 2024-2025 онд ногдох агаарын бохирдлын төлбөр төлж, энэ тухай холбогдох тэмдэгдэл хийлгэсэн байна.	EB4 БОА-ын ажиглалт
FB5	MNS 4585:2016 Агаарын Чанар Техникийн Ерөнхий шаардлага Гадаад орчны агаарын чанарыг үнэлэх үзүүлэлт нь агаар дахь түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх түвшний хэмжээг заана. (24 цаг/20 минутын дундаж/хэмжих нэгж мкг/м3) Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )-50/ 450 Азотын давхар исэл (NO <sub>2</sub> )- 50/200 PM 10 тоосонцор-100, PM 2.5 тоосонцор-50	Биелсэн	Хандгайт гол ХХК төслийн гадаад орчны агаарын чанарыг хянах ажлыг Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ хийх ажлыг Сэлэнгэ аймгийн УЦУОШТ гэрээний дагуу гүйцэтгэсэн байна.	EB5.1 Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ хийх талаар байгуулсан гэрээ-43/, Сэлэнгэ аймгийн УЦУОШТ, 2024-09-10 Хавсралт. Хандгайт гол ХХК-д хийгдэх байгаль орчны шинжилгээ хийх төлөвлөгөө. EB5.2
FB6	БОННУ-ний зөвлөмж Үйлдвэрийн хүдэр бутлах, нунтаглах хэсэгт байнгын	Биелсэн	Компани нэг замын бодлого баримталж ажиллаж байгаа нь жолооч нарын тоосонцрын нөлөөлөлд өртөх эрсдэлийг	EB6 Хандгайт гол ХХК-ийн уурхайн замын орчны гэрэл зураг

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ МУ-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

лагаатай агааржуулагчтай байх, ус шуршин тоосгах зориулалтын тоног төхөөрөмжтэй байх	Биелсэн	бүүруулах, байгаль орчныг хамгаалахад чухал нөлөөтэй гэж ажиглагдлаа.	ЕВ7 УЦУОШТ-ийн БОШЛ-ийн Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн, дугаар: 2024/А99-104, 2024.09.24
НҮ-ний зөвлөмж ын байрны тоосжилтыг тогтмол хянах, жилгээний дээж авах	Биелсэн	Агаарын дээжийг ажилчдын кемп, баяжуулах үйлдвэр, ил уурхай, хаягдлын овоолго, тээвэрлэлтийн зам-1, тээвэрлэлтийн зам-2, худаг гэсэн 7 цэгээс авч, хяналт шинжилгээг хийдэг.	ЕВ8 БОА-ын ажиглалт
НҮ-ний зөвлөмж г ажилтан, ажиллагсдыг зориулалтын ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажиллаж байна.	Биелсэн	Уурхайн ажилтан, ажиллагсдыг зориулалтын ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажиллаж байна.	ЕВ9 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн МУ-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан
НҮ-ний зөвлөмж шингээх ба тусгаарлах хэрэгсэл шалтгаарлах	Биелээгүй	ХАБЭА, үйлдвэрлэлийн эрүүл ахуй болон галын аюулгүйн дүрэм, норм зааварын шаардлагыг чанд мөрдүүлэх, үйлдвэрлэлийн осол мэргэжлийн өвчнүүдээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, шинэ ажилчдын сургалтыг 2024 онд зохион байгуулсан байна.	ЕВ10 БОА-ын ажиглалт
НҮ-ний зөвлөмж ог төхөөрөмжийн технологийн горим нь дээрлэлийн явцад олон удаа шалгагдсан оворонгуй дуу шүүгиан намсгалтай байх.	Биелсэн	Дуу шингээх ба тусгаарлах хэрэгсэл ашиглан шүүгианы тархалтыг хязгаарлах арга хэмжээ авсан талаар нотломж олдоогүй тул хэрэгжээгүй гэж үнэлэв. Тоног төхөөрөмжийн технологийн горим нь үйлдвэрлэлийн явцад олон удаа шалгагдсан боловсроггүй дуу шүүгиан намсгалтай бөгөөд тогтмол хугацаанд шинэчилж байна.	ЕВ11 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага
НҮ-ний зөвлөмж эр бутлах, шигших явцад тоос үүсгэх цэгүүдийг үмжлэх, механик тоос дарах төхөөрөмж зилуулах зэрэг арга хэмжээг авах.	Биелсэн	Хүдэр бутлах, шигших явцад тоос үүсгэх цэгүүдийг битүүмжлэх, механик тоос дарах төхөөрөмж суурилуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.	ЕВ12 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

### 3.3 ГАЗАР АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

*Уурхайн дотоод болон гадаргуугийн авто зам:* төслөөр ордын цаашдын ашиглалтын хэтийн төлөв, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ахуйн эрүүл таатай орчныг бий болгох зорилгоор үйлдвэрлэлийн бусад замуудыг хайрган хүчилтэй авто зам ашиглана. Авто замын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу нэг үрсгалтай, замын зорчих өргөн тооцоогоор 9.5 м, сонгосон өргөн нь 12 м байна.

Судалгааны талбайд урьд өмнө явагдаж байсан уурхай болон мод боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас 2.43 км үрттай шороон зам, 1.55 га талбайд уурхайн олборлолт, овоолго, 10.15 га талбайд ажилчидын сууц, уурхайн агуулах зориулалтаар ашиглаж байна. Цаашид уурхайн үйл ажиллагааны явцад нийт 101.01 га талбай эвдрэлд нэмж өртөхөөр төлөвлөсөн байна.

“Хандгайт гол” ХХК-ийн төмрийн хүдэр олборлох төслийн талбайд аж ахуйн үйл ажиллагаа эхлээгүй байгаа тул хүнд металлын өнөөгийн агууламжийн түвшинг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах зорилгоор талбайд жигд тархахаар 5 цэгээс өнгөн хөрсний дээж авч өнгөн хөрсөнд агуулагдах хүнд элементүүдийг шинжиллээ. Хөрсний хүнд металлын хувьд төслийн талбайд дугтуйн аргаар хөрсний өнгөн хэсгээс хөрсний дээжлэлт авч өргөн тархалттай хром, хар тугалга, кадми, никель, цайр гэсэн 5 элементийг агууламжийг тодорхойлуулсан. Лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд, хромын агууламж талбайн хэмжээнд 40-48мг/кг орчим, хар тугалга 29-41мг/кг, кадми илрээгүй буюу багажны мэдрэг чанарт бүртгэгдээгүй, цайр 54-58мг/кг, зэс 18-26мг/кг, никель 28-36мг/кг тус тус агууламжтай байна. Төслийн талбайн хүрээнд агуулагдсан хүнд элементийн дээрхи агууламж нь стандарт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй буюу бохирдолгүй үзүүлэлт болно.

*Замын тоос дарах ажиллагаа:* орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 2 цаг тутамд явуулна. Автоцистерн тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Цаг агаар, хөдөлгөөний эрчмийн байдлаас шалтгаалан тоосжилт ихэсвэл замын тоос дарах ажиллагааг давтана. Замын тоос дарах ажлыг 1 ширхэг тоногдсон авто цистерн гүйцэтгэнэ.

*Овоолгын аж ахуй:* ашиглалтын хугацаанд уурхайнуудаас нийт 25.25 сая.м<sup>3</sup> хөрс гарах ба энэ нь сийрэгжсэн эзлэхүүнээр 30.3 сая.м<sup>3</sup> болно. Төсөлд хөрсний гадаад овоолго үүсгэхээр тусгасан. Гадаад овоолго нь урд ил уурхайн зүүн урд талд 48.2 га талбай эзлэн байршина. Хөрс хуулалтын явцад хуулагдах шимт хөрсийг нийлүүлэн нэг овоолгод хураана.

#### Ашиглалтын жилүүд дэх хөрс хуулалтын хэмжээ

Ашиглалтын жилүүд мян.м <sup>3</sup>	Хөрс хуулалт тн	Сийр.коэффициент	Сийрэгжсэн хөрсний эзлэхүүн мян.м <sup>3</sup>	Хөрсний овоолгод хураагдах хөрс /өссөн/ мян.м <sup>3</sup>	
1-р жил	2025.09	5670.25	1.2	2430.10825	2430.10825
2-р жил	2134.59	5976.84	1.2	2561.5038	4991.61205
3-р жил	2166.60	6066.49	1.2	2599.92439	7591.53644
4-р жил	2338.57	6548.00	1.2	2806.28556	10397.822
5-р жил	2171.12	6079.15	1.2	2605.349849	13003.17185
6-12-р жил	14425.18	40390.51	1.2	17310.21742	30313.38927
Нийт	25261.16	70731.24	1.2	30313.38927	30313.38927

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ МУ-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт 5. БОА-ын: Газар ашиглалт, нөхөн сэргээлт

Код	БОА-ын шалгуур	БОА-ын үнэлэмж	Нөхцөл байдлын тодорхойлолт	Нотломж
FC1	Газрын тухай хууль (ГТХ) 21.4.3 Сумын ЗД нь энэ хуулийн 21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд баталсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулах.	Биелсэн	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий байршил 4301004091 дугаар бүхий 2446878 м.кв газрыг нөөц газрын зориулалтаар эзэмшүүлсэн байв.	ЕС1 Монгол Улс, Аж ахуйн нэгжийн газар эзэмших гэрчилгээ, №00000051542 2022.03.30
FC2	ГТХ 35.1.1 Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах. ГТХ 27.1 Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.	Биелсэн	Тус компанид 15 жилийн хугацаатай Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий байршил 4301004091 дугаар бүхий 2446878 м.кв газрыг нөөц газрын зориулалтаар эзэмшүүлсэн байв.	ЕС2 Монгол Улс, Аж ахуйн нэгжийн газар эзэмших гэрчилгээ, №00000051542 2022.03.30
FC3	ГТХ 35.3.3 Газрын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх. ГТХ 7.1 Газар эзэмшин, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих хууль тогтоомж, гэрээний дагуу газрын төлбөр төлнө.	Биелсэн	Хандгайт гол ХХК газрын төлбөр тухай бүр төлж ажиллаж байна. Тухайлбал, газрын төлбөрт 17,953,070 төгрөгийг төлбөрийн нэхэмжлэхийн дагуу төлсөн байна.	ЕС3 Улсын газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн систем, газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт, 2025.08.08
FC4	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (ХХЦСтХ) 7.2.1 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх.	Биелсэн	БОА-ын газар дээрх үзлэгээр төслийн талбай, орчимд ил задгай хог хаягдалгүй, цэвэр цэмцгэр байв.	ЕС4 Ажилдчин кемп, түүний орчны гэрэл зураг
FC5	ХХЦСтХ 7.2.2 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх	Биелсэн	Эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байна.	ЕС5 Ахуйн бохир ус хадгалах, ус зайлуулах байгууламжийн гэрэл зураг
FC6	ХХЦСтХ 7.2.5 Тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох БОННУ-ний зөвлөмж Машин техникийн зогсоол байгуулах.	Биелсэн	Тогтоосон авто зогсоолтой бөгөөд нэг замын бодлогыг хэрэгжүүлж маршрут гарган, зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоохыг хориглож ажиллаж байна.	ЕС6 Авто зогсоолын орчны гэрэл зураг

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БУХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

FC7	<p>БОННУ-ний зөвлөмж Хөрсний бохирдлын шинжилгээг хийлгэх. Хяналт шинжилгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, зураг хэмжилтээр үр дүн гарна.</p>	<p>Биелсэн</p>	<p>Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-тэй гэрээ байгуулж, Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг хийлгэж байна. ШТС, засварын газарт хөрсний химийн шинжилгээ хийхэд нефтийн бүтээгдэхүүн илрээгүй байна.</p>	<p>EC7.1 Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ хийх талаар байгуулсан гэрээ, №34/2024.09.10 EC7.2 Байгаль орчны шинжилгээний лабораторийн сорилтын дүн. 2024.09.30 Дугаар: 2024/№ Х93-94 EC8 Хог хаягдлын цэгийн гэрэл зураг EC9 Шимт хөрсний овоолгын гэрэл зураг</p>
FC8	<p>БОННУ-ний зөвлөмж Хог хаягдал хадгалах зориулалтын цэг байгуулах. Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад Хог хаягдлын менежментийн тайланг гаргана.</p>	<p>Биелсэн</p>	<p>Хог хаягдал хадгалах зориулалтын цэг байгуулж, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад хог хаягдлын менежментийн тайланг гаргадаг.</p>	
FC9	<p>БОННУ-ний зөвлөмж Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарина.</p>	<p>Биелсэн</p>	<p>Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу байгуулж, хадгалж байна.</p>	<p>EC9 Шимт хөрсний овоолгын гэрэл зураг</p>
FC10	<p>БОННУ-ний зөвлөмж Ослын үед бохирдсон хөрсөн бүрхэвчийг саармагжуулах, нөхөн сэргээх гарын авлага боловсруулах</p>	<p>Биелээгүй</p>	<p>БОА-ын үед ослын үед бохирдсон хөрсөн бүрхэвчийг саармагжуулах, нөхөн сэргээх гарын авлага боловсруулж, ашигладаг байдал ажиглагдаагүй.</p>	<p>EC10 БОА-ын ажиглалт</p>
FC11	<p>БОННУ-ний зөвлөмж Авто зам тавих үед ашигласан хэсгийн хайрганы карьерыг нөхөн сэргээх, шимт хөрсөөр хүчих, ургамалжуулах</p>	<p>Биелсэн</p>	<p>Компани авто зам тавих үед ашигласан хэсгийн хайрганы карьерыг нөхөн сэргээх, шимт хөрсөөр хүчих, ургамалжуулах ажил хэрэгжээгүй байна.</p>	<p>EC11 БОА-ын ажиглалт</p>
FC12	<p>БОННУ-ний зөвлөмж Хүнд машин техник зорчих хэсгийн замын хэсэгт усалгаа хийх</p>	<p>Биелсэн</p>	<p>БОА-ын газар дээрх үзлэгээр хүнд машин техник зорчих хэсгийн замын хэсэгт усалгаа хийж хэвшсэн байна.</p>	<p>EC12 БОА-ын ажиглалт</p>
FC13	<p>БОННУ-ний зөвлөмж Олон салаа зам гаргахгүй байх, үйлдвэр рүү очих, тээвэрлэх замын маршрутыг тодорхой тогтоож тэмдэгжүүлэх, тоос босохгүй байх нөхцлийг хангах.</p>	<p>Биелсэн</p>	<p>Олон салаа зам гаргахгүй байх, үйлдвэр рүү очих, тээвэрлэх замын маршрутыг тодорхой тогтоож тэмдэгжүүлэх, тоос босохгүй нөхцлийг хангаж ажилладаг.</p>	<p>EC13 БОА-ын ажиглалт</p>
FC14	<p>БОННУ-ний зөвлөмж Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх.</p>	<p>Биелээгүй</p>	<p>Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх ажил хийгээгүй байв.</p>	<p>EC14 Засварын талбайн гэрэл зураг</p>

**ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

FC15	<p><b>БОННУ-ний зөвлөмж</b> Олборлолт дууссаны дараа дээрх хэсгүүдийн ашиглагдсан талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх.</p>	<p>Үнэлэх боломжгүй</p>	<p>Олборлолт дууссан хэсгүүдийн ашиглагдсан талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх ажил хараахан эхлээгүй байна.</p>	<p>EC15 БОА-ын ажиглалт</p>
FC16	<p><b>БОННУ-ний зөвлөмж</b> Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг өтөг бууцаар бордож, олон наст ургамлын үр цацах, мод бут суулгах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх.</p>	<p>Үнэлэх боломжгүй</p>	<p>Нөхөн сэргээлт хийх хугацаа эхлээгүй тул газрыг бордож, мод бут суулгах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийсэн зүйл ажиглагдаагүй.</p>	<p>EC16 БОА-ын ажиглалт</p>
FC17	<p><b>БОННУ-ний зөвлөмж</b> Шимт хөрсийг ажлын явцад шууд хэрэглэхгүй тохиолдолд тусгай талбайд овоолж хадгална.</p>	<p>Биелсэн</p>	<p>Шимт хөрсийг шууд хэрэглэхгүй тохиолдолд тусгай талбайд овоолж хадгалж хэвшсэн нь ажиглагдав. Шимт хөрсний шимт байдлыг алдахгүй байх талаар зөвлөмж өгсөн болно.</p>	<p>EC17 БОА-ын ажиглалт</p>
FC18	<p><b>БОННУ-ний зөвлөмж</b> Уурхайн үйл ажиллагааг аюулгүйгээр явуулах нөхцөлийг хангахад гарцаагүй шаардлагатайгаас бусад нөхцөлөөр газар, хөрсийг эвдрэлд оруулахгүй байх, эвдрэлд орох газрын хэмжээг хамгийн бага байлгах удирдлага зохион байгуулалт, техник технологийн арга хэмжээг байнга авч байх.</p>	<p>Биелсэн</p>	<p>Газар, хөрсийг эвдрэлд оруулахгүй байх, эвдрэлд орох газрын хэмжээг хамгийн бага байлгах удирдлага зохион байгуулалт, техник технологийн арга хэмжээг байнга авч хэрэгжүүлж байна. Цаашид засварын цех байгуулж, хөрсийг шингэн үл нэвтрэх дэвсгэр дэвсэж хамгаалж байх талаар зөвлөсөн.</p>	<p>EC18 БОА-ын ажиглалт</p>
FC19	<p><b>БОННУ-ний зөвлөмж</b> Ил уурхайн авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний маршрутын дагуу замыг тэмдэгжүүлэх, гэрэлтүүлэх.</p>	<p>Биелсэн</p>	<p>Ил уурхайн авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний маршрутын дагуу замыг тэмдэгжүүлсэн байв.</p>	<p>EC19 Уурхайн замын гэрэл зураг</p>
FC20	<p><b>БОННУ-ний зөвлөмж</b> Замын эвдрэлийг тухайн бүрт нь засаж хэвийн нөхцөл бүрдүүлэх.</p>	<p>Биелсэн</p>	<p>Ерөө сумаас Бугант чиглэлийн орон нутгийн зам засварын ажилд 39,5-40 км замыг түрж тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.</p>	<p>EC20 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан</p>

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт 6. БОА-ын дүн: Хог хаягдлын менежмент

Код	БОА-ын шалгуур	БОА-ын үнэлэмж	Нөхцөл байдлын тодорхойлолт	Нотломж
FD1	ХХТХ 10.2.3 Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах.	Биелсэн	Ашиглалтын үйл ажиллагааны 2024 онд Хог хаягдал цуглуулж, тээвэрлүүлэх үйлчилгээний гэрээг "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ, ОНӨААТҮГ -тай байгуулж ажилласан байв.	ED1 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний гэрээ "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ, 2024.06.24
FD2	ХХТХ 10.2.4 Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх.	Биелсэн	Хог хаягдал цуглуулж, тээвэрлүүлэх үйлчилгээний гэрээг 2024 онд байгуулж, эрх бүхий байгууллагад шилжүүлсэн.	ED2 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний гэрээ "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ
FD3	ХХТХ 10.2.8 Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг эзэмшүүлэх. ХХТХ 40.1 Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэнэ.	Биелсэн	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг эзэмшүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан байв. БОА-ын газар дээрх үзлэгээр төслийн талбайд ил задгай хог хаягдалгүй байв.	ED3 БОА-ын ажиглалт
FD4	ХХТХ 10.2.17 Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх.	Биелсэн	Тус компанийн ХАБЭА, БО-ны мэргэжилтэн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт ажиллаж байна.	ED4 БОА-ын ажиглалт
FD5	ХХТХ 10.2.18 ААНБ нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээ авах, аюулгүй ажиллагааг хангах.	Биелсэн	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээ авах, аюулгүй ажиллагааг хэрэгжүүлдэг.	ED5 БОА-ын ажиглалт
FD6	ХХТХ 10.3.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно.	Биелсэн	БОА-ын багийн газар дээрх үзлэгээр ил задгай хог шатаасан зүйлгүй байв.	ED6 Талбайн орчны гэрэл зураг
FD7	ХХТХ 10.3.6 Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулахыг хориглоно	Биелсэн	Нүхэн жорлон ажилчдын кемп дотор байгуулж, ашиглахдаа доторлогоо хийсэн байна.	ED7 БОА-ын ажиглалт

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ МУ-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

FD8	<p>ХХТХ 20.1 Хог хаягдлын төвлөрсөн цэгт дараах хог хаягдал булшлахыг хориглоно:</p> <ul style="list-style-type: none"> <li>- аюултай хог хаягдал;</li> <li>- халдвартай хог хаягдал;</li> </ul> <p>шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал.</p>	Бие лсэн	Төслийн талбайд аюултай хог хаягдал, халдварт хог хаягдал хог хаягдлын төвлөрсөн цэгт булшилдаг байдал БОА-ын газар дээрх үзлэгийн үеээр ажиглагдсангүй.	ED8 БОА-ын ажиглалт
FD9	<p>ХХТХ 22.1, 25.2 Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартгаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.</p>	Бие лсэн	Хог хаягдлын цэгт ангилан ялгаж хадгалж байна. Цаашид аюултай хог хаягдал хадгалахдаа "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартгаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй болгох талаар зөвлөмж өгөв.	ED9 Аюултай хог хаягдлын цэгийн гэрэл зураг
FD10	<p>БОННУ-ний зөвлөмж "Хог хаягдал хадгалах зориулалтын цэг"-ийг байр сууц, хоолны газраас 60 метрээс багагүй зайд бие засах газраас тусад нь зонхилох салхины доод зүгт байрлуулж, салхинд хийсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн, хөрсөнд шингээлт үүсэхээс хамгаалах.</p>	Бие лсэн	Уурхайн тосгоны "Хог хаягдал хадгалах зориулалтын цэг"-ийг байр сууц, хоолны газраас 60 метрээс багагүй зайд бие засах газраас тусад нь зонхилох салхины доод зүгт байрлуулсан байна.	ED10 Хог хаягдлын нэгдсэн цэгийн гэрэл зураг
FD11	<p>БОННУ-ний зөвлөмж Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, ариутгах, тээвэрлэх графикийг гаргаж, Ерөө сумын ЭДТТ гэрээ байгуулан хог хаягдлыг тогтмол хугацаанд ачиж, зайлуулах гэрээ байгуулан ажиллах шаардлагатай.</p>	Бие лсэн	Гэрээний дагуу Ерөө сумын татвар хэлтэст хог хаягдлын төлбөрийн 1 жилээр нь 1188.0 төгрөг төлсөн байна.	ED11 Төлбөрийн даалгавар, №1 2024.09.02
FD12	<p>БОННУ-ний зөвлөмж Хуурай хог хаягдлыг таглаатай нийлэг эсвэл металл саванд хуримтлуулан тээвэрлэж байх /цаашид хуурай хог хаягдалгүй байх технологи нэвтрүүлэх/.</p>	Бие лсэн	Хуурай хог хаягдлыг таглаатай нийлэг эсвэл металл саванд хуримтлуулан тээвэрлэж байна.	ED12 Хуурай хог хаягдал хадгалж буй байдлын гэрэл зураг
FD13	<p>БОННУ-ний зөвлөмж Баазын үйл ажиллагааны ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал бохир усыг зайлуулахдаа батлагдсан зураг төслийн дагуу шугам хоолой, цэвэрлэх байршуулж тодорхой хугацаа бүрд цэвэрлэн зайлуулж шалгаж байх.</p>	Бие лсэн	Баазын үйл ажиллагааны ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал бохир усыг зайлуулахдаа батлагдсан зураг төслийн дагуу шугам хоолой, цэвэрлэх байршуулж тодорхой хугацаа бүрд цэвэрлэн зайлуулж шалгаж байна.	ED13 БОА-ын ажиглалт
FD14	<p>БОННУ-ний зөвлөмж Хатуу хог хаягдлыг шүүд хөрсөнд хүрэхгүйгээр зориулалтын битүү тагтай, ялаа шавьж үржихээс сэргийлсэн ариутгал хийсэн саванд хуримтлуулах.</p>	Бие лсэн	Хатуу хог хаягдлыг шүүд хөрсөнд хүрэхгүйгээр зориулалтын битүү тагтай, ялаа шавьж үржихээс сэргийлсэн ариутгал хийсэн саванд хуримтлуулдаг.	ED14 Хог хаягдлын нэгдсэн цэгийн гэрэл зураг

### 3.5 УСНЫ МЕНЕЖМЕНТ

Баянголын эх талбайн төмрийн хүдрийн ордын орчим дахь гадаргын усны гол артери нь Баянгол юм. Баянгол нь Хэнтий нүүрүны баруун хойт хажуугийн салбар уулс болох Дулаан уулын өврөөс эх авах бөгөөд эхнээс 29 орчим км үрсэн, Ерөө голын баруун гар талын цутгал болно. Монгол орны гидрогеологийн дүүрэгчлэлээр гидрогеологийн хойт системийн Сэлэнгэ мөрний ай савын Ерөө голын ай савын хүрээнд Ерөө-Баянголын сав газрын дундаж өндөртэй уулс, хотгорын дэд мужид оршино. “Баянголын эх хөндий” нэртэй XV-014491 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байр зүйн зургийн М-48-94 хавтгайд нийт 6092.45 гектар талбайг хамрана. Тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос хойш 230 км, Дархан хотоос зүүн хойш 70 км, Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос зүүн урагш 90 км-т оршдог.

*Газрын доорх усны шинж чанар:* Талбайн хэмжээнд тархсан усны химийн найрлага, чанарыг тогтоохын тулд химийн бүрэн шинжилгээг Шинжлэх ухааны академийн харъяа Геоэкологийн хүрээлэнд хийлгэлээ. “Баянгол эх хөндий” талбайн хэмжээнд газрын доорх усны химийн найрлага, чанарын судалгааг өмнө хийгдсэн гидрогеологийн судалгаагаар тогтоож байжээ. Ордын талбайд урсах Баянголын үрсгалын усны зарцуулалтыг тодорхойлж байгаагүй. Түүнтэй адилтгах Толгойтын голд ажиглалт явуулж түүнтэй адилтгах зарчмаар тус голын усны үрсацыг ойролцоогоор хамгийн бага үрсац нь 0.3-0.6 м<sup>3</sup>/сек, хамгийн их үрсац нь 7-9-р сарын хооронд 2.5-3.0 м<sup>3</sup>/сек гэж үзсэн байдаг /1993 он/. Голын усны химийн шинжилгээнд ерөнхий эрдэсжилт нь 0.326 гр/л. Гидрокарбонати -сульфатлаг буюу холимог найрлагатай. Ерөнхий хатуулаг 4.18 мг.экв, хүчиллэг PH-7.4. Ус нь цэнгэг, амт үнэргүй, нүгтийн ардууд унд ахуй, мал усалгаанд өргөн ашигладаг. Баянгол нь гандуу хуурай үед зарим газраа тасарч шургадаг. Баянголын усны химийн найрлага чанарын хувьд онц өөрчлөлтгүй. /Дээж №1/ Болд төмөр Ерөөгийн уурхай, уурхайн тосгон, ойр орчимд малчид олноор амьдарч байгаагаас “Гадаргын усны цэврийн зэрэглэлийн норм”-той харьцуулахад ууссан бодисын үлдэгдэл ба нитрит, нитратын азотын бага зэрэг бохирдолтой үнэлэгдсэн.

*Унд-ахуйн ус:* Ундны усан хангамжийн зориулалтаар усны мэргэжлийн байгууллага болох Ихэр чандмань ХХК-иар 80 м гүнтэй, усны статик түвшин 15 м, усны үндарга 2.5 л/сек үндаргатай хүдгийн 2020 оны 8 сард гаргуулсан байна. Газарзүй гео-экологийн хүрээлэнгийн усны лабораторид шинжлүүлэхэд хүдгийн ус химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байх бөгөөд химийн үндсэн үзүүлэлтүүд “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS900-2018” стандартын шаардлага хангаж байна.

*Усны хяналт, мониторинг:* Унд-ахуй, технологийн хэрэгцээнд үйлдвэрийн талбайд 1 гүний худаг ашиглаж байна. Энэхүү өрөмдмөл хүдгийн болон зөөврийн усны хяналт, мониторингийг Эм И Си Эс Зэт Би ХХК мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хамтран ажилласан байна.

*Зам усалгааны усан хангамж, хэрэглээ:* Тус төслийн зам талбайн хэмжээ буюу усалгаанд хамрагдах зам, мөргөцөгүүд, бусад талбайн хэмжээ ТЭЗҮ-д 11.1 га байна. Хатуу хучилттай зам талбайг механикаар услах норм нь Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын яамны сайдын 2015 оны 7-р сарын 30-ны өдрийн А/301- тушаалын дагуу 1м<sup>2</sup> талбайг 2 л усаар угаах бол нийт 222.0 м<sup>3</sup> /2.56 л/сек/ ус 1 өдөрт зарцуулна. /өдөрт 1 удаа усална/ Уурхайн ашиглалтын явцад 1 жилд: 222 м<sup>3</sup>/хон \* 90 хоног =19.98 мян.м<sup>3</sup> ус усалгаанд зарцуулна. Уурхайн зам талбайн услах хэрэглээний усыг уурхайд шүүрч орох 1955.8 м<sup>3</sup>/хоног шүүрлийн усаар хангана.<sup>6</sup>

<sup>6</sup> Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Хандгайт гол ХХК-ийн MV-021595 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ МУ-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт 9. БОА-ын дүн: Ус ашиглалтын менежмент

код	БОА-ын шалгуур	БОА-ын үнэлэмж	Нөхцөл байдлын тодорхойлолт	Нотломж
FE1	УТХ 7.5 Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан сав газрын захиргаанд гаргаж өгөх үүрэгтэй.	Биелсэн	Усны газраар 2022 оны 05-р сарын 23-ны өдөр усны тухай хуулийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөлд ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, Хараа-Ерөө голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг 2024 онд байгуулсан.	EE1 Сэлэнгэ аймгийн Е рөө сумын нутагт орших Хандгайтгол ХХК-ийн МУ-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөл, 2024 оны ус ашиглалтын тайлан
FE2	УТХ 26.1 Иргэн, ААНБ, ГУХЭ нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй. УТХ 28.11 Энэ хуулийн 28.б-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.	Биелсэн	Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас ус ашиглах гэрээг 2024 онд байгуулсан байна.	EE2.1 Ус ашиглах гэрээ, зөвшөөрөл хүргүүлэх тухай 62, Хараа-Ерөө голын сав газрын захиргаа 2024.05.28 EE2.2 Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай Ерөө голын сав газрын захиргааны даргын тушаал-А/23, 2024.05.28
FE3	УТХ 30.1.1 Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх.	Биелсэн	Үйл ажиллагааны 2024 онд ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд зааснаас ус хэтрүүлж ашиглаагүй байна.	EE3 БОА-ын ажиглалт
FE4	УТХ 30.1.5 Ус, рашааны нөөц ашигласны болон ус бохидуулсны төлбөр төлөх УТХ 31.1 Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.	Биелсэн	Хандгайт гол ХХК нь ус ашигласны төлбөрт 2024 онд 845,000₮ төлсөн байна.	EE4 Хаан банкны шилжүүлгийн мэдээлэл, 2024.12.10
FE5	УТХ 30.1.4 Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах УАХТЖ 1.3 Унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын усны олборлолт, дамжуулалт, нөөцлөлт, борлуулалт, хаягдал усны тоо хэмжээг тогтоох ба ашиглалтын тайлан мэдээг гаргах ажилд эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурын заалтыг үндэслэнэ.	Биелсэн	Гүнийн хүдгийн шугам хоолойг тоолууржуулсан байна. Усны тоолуурын улсын баталгаажуулалтын гэрчилгээ нь 2027 оны 06 сарын 26-ны өдөр хүртэл хүчинтэй байна.	EE5 Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ, № ЭУ 251520 Стандарт, хэмжил зүйн газар

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

FE6	<p>УАХТЖ 3.6.1 Ус ашиглагч, хэрэглэгч нь цэвэр болон хаягдал усны тоолууртай байх бөгөөд тоолууржуулах ажлын зардлыг хариуцах.</p> <p>УгХ 25.1 Ус бохирдуулагч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах үүрэг хүлээнэ.</p> <p>УгХ 30.1.3 Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах.</p> <p>УТХ 30.2.2 Үйл ажиллагаанаас гарах хаягдал ус, рашааныг цэвэрлэх байгууламж барьж ашиглах, эсхүл зайлуулах цэг тогтоологх.</p> <p>MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.</p> <p>Зэсийн (Cu) агууламж (1.0) цайрын (Zn) агууламж (3.0) кадмийн (Cd) агууламж (0.03) хромын (Cr) агууламж (0.3) хар тугалганы (Pb) агууламж (0.1)</p>	Биелсэн	<p>Хаягдал усандаа химийн шинжилгээ ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэхээс өмнө 11 үзүүлэлтээр хийлгэхэд хийлгэхэд бохирдуулагч бодис MNS 4943:2015 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй байна.</p>	<p>EE6 Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн сорилтын дүн, 2024.09.30, Дугаар: 2024/№ 998-99</p>
FE7	<p>УгХ 32.10 Усны аливаа барилга байгууламж нь паспорттай байна</p>	Биелсэн	<p>Уурхайн тосгон дахь гүний худагт өрөмдмөл хүдгийн паспорттай байна.</p>	EE7 БОА-ын ажиглалт
FE8	<p>УАХТЖ 2.1.1 Тоолуур нь техникийн болон ашиглалтын баримт бичигтэй байхын зэрэгцээ загварын туршилтад орж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэмжил зүйн хяналтад хамрагдсан байх (гэрчилгээ)</p>	Биелсэн	<p>Цэвэр усны тоолуурын голч нь шугам хоолойн оруулгын голчтой адил байх бөгөөд бодит зарцуулалтад тохирсон байна.</p>	<p>EE8 Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ, № ЭУ 251520 Стандарт, хэмжил зүйн газар EE9 БОА-ын ажиглалт</p>
FE9	<p>УАХТЖ 2.1.3 Хэмжил, тооцооны үнэн зөв байдлыг хангахын тулд хэрэглэгч, ашиглагчийн сүүрилуулах цэвэр усны тоолуурын голч нь шугам хоолойн оруулгын голчтой адил байх бөгөөд бодит зарцуулалтад тохирсон байх</p>	Биелсэн	<p>Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал бохир усыг зайлуулахдаа батлагдсан зураг төслийн дагуу шугам хоолой, цэвэрлэх байгууламжид цэвэрлэж байна.</p>	EE10 БОА-ын ажиглалт
FE10	<p>БОННУ-ний зөвлөмж Төслийн үйл ажиллагааны ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал бохир усыг зайлуулахдаа батлагдсан зураг төслийн дагуу шугам хоолой, цэвэрлэх</p>	Биелсэн		

**ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ МУ-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

FE11	<p>байгууламжийг байршуулж тодорхой хугацаа бүрт цэвэрлэн зайлуулж шалгаж байх.</p> <p>БОННУ-ний зөвлөмж Херсийг бохирдуулахгүйн тулд шингэн хаягдал бохир усыг бохирын цооногт нийлүүлэхдээ шугам хоолойн хэвийн ажиллах нөхцөлд анхаарах, шугам хоолойн техникийн гэмтэл доголдлыг тогтмол хугацаанд шалгаж байх, засвар, үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар чанартай хийлгэх, уг тайланд зөвлөсөний дагуу бага оврын бохир ус цэвэрлэх байгууламж суурилуулах.</p>	Биелсэн	<p>Шингэн хаягдал бохир усыг бохирын цооногт нийлүүлэхдээ шугам хоолойн хэвийн ажиллах нөхцөлд анхаарах, шугам хоолойн техникийн гэмтэл доголдлыг тогтмол хугацаанд шалгаж байна. Утра камел Транс ХХК-ийн Бага оврын "Биолос" бохир ус цэвэрлэх байгууламж суурилуулж, хаягдал усны шинжилгээг тогтмол хийлгэж байна.</p> <p>Бохир ус хөрсөнд нэвчиж эхэлсэн даруйд түүнийг арилгах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлдэг.</p>	EE11 Тохирлын гэрчилгээ, № УБИ129, Стандарт, хэмжил зүйн газар
FE12	<p>БОННУ-ний зөвлөмж Ямар нэг шалтгаанаар бохир ус хөрсөнд нэвчиж эхэлсэн даруйд түүнийг арилгах арга хэмжээг яаралтай авах</p>	Биелсэн	<p>Бохир ус хөрсөнд нэвчиж эхэлсэн даруйд түүнийг арилгах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлдэг.</p>	EE12 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага
FE13	<p>БОННУ-ний зөвлөмж Үер усны аюулаас сэргийлэх далан бүсад байгууламж байгуулах, цэвэр байлгах.</p>	Биелсэн	<p>Үерийн хамгаалалтын далан байгуулж, уг даланд хог хаягдал хуримтлуулахгүйгээр цэвэр байлгаж байна.</p>	EE13 Орчны гэрэл зураг
FE14	<p>БОННУ-ний зөвлөмж Уурхайн байршлын онцлогтой холбогдон гадаргуугийн түр урсац ус зайлуулах байгууламж төлөвлөж, уг байгууламжийг цэвэр байлгахад анхаарах.</p>	Биелсэн	<p>Төслийн ажилчдын кемп тойруулж, үерийн хамгаалалтын далан байгуулж, уг даланд хог хаягдал хуримтлуулахгүйгээр гадаргуугийн түр урсац ус зайлуулах, уг байгууламжийг цэвэр байлгахад анхаарч ажиллаж байна.</p>	EE14 Орчны гэрэл зураг
FE15	<p>БОННУ-ний зөвлөмж Уурхайн усан хангамжийн худаг Баянгол голын дээд хэсэгт, бариглах гүүрний дээр, болон доод хэсэгт, Ерөө голтой нийлж байгаа хэсэгт Малчин айлын худаг Жилд 2 удаа Усны ерөнхий хими, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, рН, Cl, SO4, NO2, NO3, CO3, HCO3) Ахуйн хаягдал усны ерөнхий хими, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, рН, хүнд металлын шинжилгээ (As, U, Pb, W, Th, Sn, Cs, Cd, Nb, Se, Zn, Zr) хийх.</p>	Биелсэн	<p>Хандгайт гол ХХК-ийн худгийн усны ерөнхий химийн шинжилгээг Газарзүй гео-экологийн усны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байна. Ундны усанд, MNS 900:2018 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс кальци 1.26 дахин, хатуулаг 1.13 дахин их байна.</p>	EE15 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайтгол ХХК-ийн МУ-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөл, 2024 оны ус ашиглалтын тайлан

### 3.6 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТ

*Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ:*

Талбайн хэмжээнд уурхай болон овоолгийн талбайн хүрээнд ойн нарс, хавтаг навчит хус өртөж байгаа бөгөөд нүүлгэн шилжүүлэх боломжтой шилжүүлэн суулгах шаардлагатай. Мөн ойн тухай хуулийн дагаж мөрдөх шаардлагатай. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд тусгажээ. Түүнчлэн уурхайн хөрс хуулалтын явцад өртөх моддыг боломжтой 400 ширхэг нарс модыг шилжүүлэн суулгах бөгөөд 4378 ширхэг хавтаг навчит хус модыг шилжүүлэн боломжгүй учир нь хавтаг навчит хус нь шилжүүлэн суулгахад буцаад ургах магадлал маш бага байдаг учир модны хувьд нөхөн төлбөрийг аймгийн байгаль орчны газарт тушаах шаардлагатай талаар тус тайланд зөвлөсөн байна.

*Мод үржүүлгийн талбай байгуулах:* Уурхай нь ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу эхний таван жил нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй бөгөөд энэ хугацаанд 100 000 модны үржүүлгийн талбай байгуулах шаардлагатай. Мод үржүүлгийн талбайд нарс, шинэс, хус, улиас, агч, бургас зэрэг моддыг үрээр үржүүлж нөхөн сэргээлтэнд ашиглана. Мод үржүүлгийн талбайг 5 га талбайд байгуулах бөгөөд уурхайн 2-3 дахь жилүүдэд байгуулах бөгөөд шүүрлийн үсаар үслана. Уг талбайг кемпийн баруун хойно байгуулахаар төлөвлөсөн. Мод үржүүлгийн талбайг байгуулахдаа модны үр түүх, мод арчилгааг, услалд бордох зураг ажлыг хийж гүйцэтгэхдээ орон нутгийн иргэдээс сургаж 2-3 хүнийг ажиллуулах хэрэгтэй.

*Амьтны аймагт үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ:*

Төслийн үе шат бүрд амьтдад нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлон, нөлөөллөөс сэргийлэх, бууруулах арга хэмжээний нөхцөлийг дараах байдлаар тайланд зөвлөсөн байна. Үүнд:

- Кемпийн орчмын талбайг тохижуулах, мод сөөг тарьж ургуулах машин техникийн хөдөлгөөний тогтсон маршрутыг мөрдөх, Авто машин явах шугам сүлжээг ихэсгэхгүй байх арга хэмжээ авах;
- Төсөл хэрэгжих хугацаанд мониторингийн судалгааг жил тутамд хийлгэж, санал зөвлөлгөөг мөрдөн ажиллах, бүс нутгийн амьтны аймгийн тоо толгой, тархац байршил, амьдрах орчны өөрчлөлтийг тандах мониторинг судалгааг зуны эхэн сард жил бүр хийдэг байх;
- Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар мониторинг хийлгэж зөвлөлгөө авч байх. Орон нутгийн иргэдтэй холбоотой ажиллах.
- Шувуудын зүйлийн тоо толгой цөөрөхөөс сэргийлж, түр кемп орчинд үсан сантай цэцэрлэгт талбайг бий болгох
- Бэлчээрийн талбайд эзэмшигч эзэдтэй нь журам тогтоолын дагуу харилцан нөхөн олговор олгох, байгалийн зэрлэг өвсөн тэжээлт амьтдад зун, намраас бүсэд улиралд тэжээл тавьж өгөх.
- Гарам, гарц барих тохиолдолд тухайн газрын онцлогт тохируулан зарим байгалийн зэрлэг амьтдыг шилжин явах нөхцөлийг бүрдүүлэх, MNS 6515:2015 стандартыг баримтлах
- Машин, механизм, техник, тоног төхөөрөмжийг угааж цэвэрлэхэд зориулсан тусгайлан зассан талбай байх шаардлагатай. Зохих, шаардлага, зарчмын дагуу барилгын болон ахуйн хог хаягдал, түүнчлэх аюултай хог хаягдлыг зайлуулах төлөвлөгөөтэй ажиллах. Эрүүл ахуй, ариун цэврийн зохих шаардлага, стандартыг мөрдөх. Эрсдэлийн үед хэрэгжүүлэх протоколыг гаргах.
- Далангийн хамгаалалтыг зайлшгүй хэсэгт заавал хийх, засаж стандартын дагуу хийх.

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ МВ-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт 9. БОА-ын дүн: Биологийн олон янз байдлын хамгааллын менежмент

Код	БОА-ын шалгуур	БОА-ын үнэлэмж	Нөхцөл байдлын тодорхойлолт	Нотломж
FF1	БОННУ-ний зөвлөмж Олборлолтын үйл ажиллагаа, овоолгоноос үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор байнгын усалгаа хийх арга хэмжээг авч байх шаардлагатай.	Биелсэн	Уурхайгаас Тавин өртөө хүртэлх тээврийн замыг олборлолтын үйл ажиллагаа, овоолгоноос үүсэх тоосжилтыг бууруулахаар байнга усалдаг.	EF1 БОА-ын ажиглалт
FF2	БОННУ-ний зөвлөмж Төслийн талбайд тохиолдох ховор болон нэн ховор зүйлүүдийг барилга байгууламж болон бусад объектуудад дарагдах, устаж үгүй болох эсэхийг судалж, дарагдахаар болсон тохиолдолд ургамлын зүйлийг шилжүүлэн суулгах арга хэмжээ авах.	Биелсэн	Ховор болон нэн ховор зүйлүүдийг барилга байгууламж болон бусад объектуудад дарагдах, устаж үгүй болох эсэхийг судлахын тулд мэргэжлийн байгууллагатай хамтран ажилладаг.	EF2 БОА-ын ажиглалт
FF3	БОННУ-ний зөвлөмж Орон нутгийн унаган ургамлын зүйлийн үрийг цуглуулах	Биелсэн	Орон нутгийн унаган ургамлын зүйлийн үрийг цуглуулах ажлыг төлөвлөж, бэлтгэл хангаж ажиллаж байна.	EF3 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага
FF4	БОННУ-ний зөвлөмж Уурхай нь ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу эхний таван жил нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй бөгөөд энэ хугацаанд 100 000 модны үржүүлгийн талбай байгуулах шаардлагатай. Мод үржүүлгийн талбайд нарс, шинэс, хус, улиас, агч, бургас зэрэг моддыг үрээр үржүүлж нөхөн сэргээлтэнд ашиглана.	Биелсэн	Нөхөн сэргээлтэд үржүүлгийн талбай байгуулах шаардлагатай. Мод үржүүлгийн талбайд нарс, шинэс, хус, улиас, агч, бургас зэрэг моддыг	EF4 БОА-ын ажиглалт
FF5	БОННУ-ний зөвлөмж Жил бүр ургамлын зүйлийн бүрдэл, ховор, нэн ховор, унаган ургамлын жагсаалтыг гарган тэдгээрийн байршлыг тогтоох, гол бүлгэмдлийг тогтоох, биомассын хэмжилт судалгааг сэргээлтийн ургалт, биомассын хэмжилт судалгааг хийх.	Биелсэн	Ургамлын зүйлийн бүрдэл, ховор, нэн ховор, унаган ургамлын жагсаалт, байршлыг тогтоох, гол бүлгэмдлийг тогтоох, биомассын хэмжилт судалгааг мэргэжлийн байгууллага хийж байна.	EF5 БОА-ын ажиглалт
FF6	БОННУ-ний зөвлөмж Шонгийн загвар, стандарт хийц болон цахилгаан дамжуулах утас хоорондын зай нь түүн дээр суух том шувуудын хөл хооронд богино холболт үүсгэхээргүй байх шийдэл стандарттай байх.	Биелсэн	Цахилгаан дамжуулах утас хоорондын зай нь шувуудад эзлээгүй, богино холболт үүсгэхээргүй байх шийдэл стандарттай.	EF6 Хандгайт гол ХХК-ийн БО-ны мэргэжилтэн Б.Батчимэгтэй хийсэн ярилцлага

## ДӨРӨВ. БОА-ЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### 4.1 ДҮГНЭЛТ

#### ***Байгаль орчны удирдлагын тогтолцоо***

Байгаль орчны менежментийн тогтолцоотой холбоотой 16 шалгуур үзүүлэлтийн 16 нь биелсэн буюу 100% үнэлэмжтэй байна. Хандгайт гол” ХХК нь төмрийн хүдрийг баяжуулж боловсруулах үйл ажиллагаанд химийн бодисыг ашигладаггүй. Орчны хяналт шинжилгээ мониторингийн ажилд 2024 онд Сэлэнгэ аймгийн ус цаг уур орчны шинжилгээний газартай гэрээ байгуулан агаарын 4 цэгт, ШТС-ийн хөрснөөс нефтьийн бүтээгдэхүүний шинжилгээг хийж гүйцэтгүүлсэн. Хөрсний хүнд метал, эрүүл ахуйн шинжилгээг Грийн лаб ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораториар, усны ерөнхий химийн шинжилгээг Газарзүй гео-экологийн усны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Орон нутгийн байгууллага, иргэдийн хүсэлтээр дараах ажлуудыг хийж, гүйцэтгэсэн байна. Хандгайтгол ХХК нь Ерөө сумын нутгийн иргэдийн хүсэлтээр үнд ахуйн зориулалттай 2 гүний худгийг 2024 оны 06-р сарын 05-ны өдрөөс 2024 оны 06-р сарын 10-ны өдрийн хүртэлх хугацаанд Сойл инженеринг ХХК-ийн цооног 1 нь 30 м гүнтэй цооног усны статик түвшин 15 м гүнд байна. Цооног 2 нь 30 м гүнтэй усны статик түвшин 18 м гүнд байна. Малчны худгийн гаргуулахад 26 499 000 төгрөг зарцуулсан. Ордын гидрогеологийн зориулалтаар мэргэжлийн байгууллагаар 70 м, 130 м, 60 м гүнтэй цоонгийг мэргэжлийн байгууллагаар өрөмдүүлсэн. Нийт 260 т.метр ажил гүйцэтгэж, 83 707 030 төгрөг зарцуулсан. Сумын төвд 600 урттай замын түрж тэгшилсэн. 2024 оны 05 сарын 09нд Сэлэнгэ аймгийн 5 сумын залуу бөхчүүдийн сорил барилдааныг “Хандгайт гол” компаниас ивээн тэтгэж шагнал гардуулах үйл ажиллагаанд оролцсон байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2024 оны 05 сарын 12нд Ерөө суманд нийт 4.8км 5 гудамжны зам дэвсэлтийн ажил хийсэн байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд Сүрийн аварга шалгаруулах тэмцээний талбай руу явах голын гарам засварын ажилд шаардлагатай материал буулгасан. Нийгмийн хариуцлагын хүрээнд Улаан давааны баруун талд малчдын хүсэлтээр гарам зассан. Орон нутгийн хөгжилд 2024 оны 06 сарын 09-ний өдөр нийгмийн хариуцлагын хүрээнд газар шорооны ажилд туслан, морины зам гарган өгсөн байна. Түүнчлэн 2024 оны 07 сард автогрейдерээр 20 км замын тохижилт хийж, ковшоор хурдны морь уралдах зам талбайг янзалж, Ерөө сумын 100 жилийн ойд хандив 60 сая төгрөг хандивласан зэргээс нийгмийн хариуцлагаа хангалттай сайн гүйцэтгэж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, болзошгүй ослын үед бэлэн байдлыг хангаж ажиллах талаар дотоод хэм хэмжээг боловсруулж, мөрдөж байна. Байгаль орчны удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж байна гэж дүгнэв.

***Агаарын чанар***

Төслийн гадаад орчны агаарын чанарын менежментийг холбогдох 12 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 11 биелсэн буюу 91% үнэлэмжтэй байв. Биелээгүй нэг зүйл нь дуу шингээх ба тусгаарлах хэрэгсэл ашиглан шуугианы тархалтыг хязгаарлах БОННУ-ний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байв. Тээврийн болон уурхайн дотоод замыг тээвэрлэлтийн өмнө усалгаа хийж хэвшсэн нь ажиглагдав. Төмрийн хүдэр ачиж буулгах талбайгаас уурхай хүртэлх 40 км замд замын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагатай байршилд байршуулсан байв. Гадаад орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Төсөл хэрэгжүүлэгч компани агаарын чанарын менежментийг амжилттай хэрэгжүүлж байна.

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

**Газар ашиглалт, нөхөн сэргээлт**

Газар ашиглалт, нөхөн сэргээлттэй холбоотой 20 шалгуураас 16 нь биелсэн буюу 78% хэрэгжилттэй байв. БОННУ-ний зөвлөмжөөс шалгуур үзүүлэлт болгон сонгож авсан хоёр шалгуурыг үнэлээгүй бөгөөд эдгээр ажлыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй байв. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд байдаг мод үржүүлгийн талбайгаас Нийт 350 мод кемпид тарьсан шилжүүлсэн тарьжээ. Төсөл хэрэгжүүлэгч компани санаачлан 100 ширхэг нарсны үржүүлгийн талбайг байгуулж арьчилгаа, үсалгааг хийж байна. “МОДОО УРГУУЛЦГААЯ” уриан дор ажилчид болон тэдний гэр бүлийн хүмүүсийг хамруулан тарих арга хэмжээг 10 сарын 12-нд зохион байгуулсан. Үржил шимт хөрс хуулсан хэмжээг дараах байдлаар харуулж байна. Эдгээр шимт хөрсний овоолгыг MNS 5916: 2008 стандартад нийцүүлж, 5 м-ээс өндөргүй байгуулсан боловч 2 жилээс дээш хадгалах хөрсөнд олон наст ургамлын үр цацаж, шимт байдал алдагдуулахгүй байх арга хэмжээ аваагүй байна.

Д/д	Байршил	Талбайн хэмжээ м2	Ажлын хэмжээ, м3	Хугацаа	
				Эхэлсэн огноо	Дууссан огноо
1	Уурхайн хэсэг	60,000	18,000.0	2022.08.22	2022.08.29
2	ШТС-ийн зам, талбай	1,100	330.0	2022.08.30	2022.08.30
3	Хөрсний гадаад овоолго	35,000	10,500.0	2022.08.31	2022.09.09
4	Хаягдлын овоолго	11,000	3,300.0	2022.09.09	2022.09.11
5	Баяжмалын овоолго	12,412	3,723.6	2022.09.11	2022.09.13
6		16,297	4,900.0	2024.05.01	2024.06.20
	НИЙТ	135,809	40,754		

Газрын хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд уурхайн ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламж байгуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн нь сайшаалтай зүйлсийн нэг байв. Төслийн үйл ажиллагааны 2024 онд уурайн үйл ажиллагаа шинээр эхэлж байгаа тул уурхайн ашиглалтын карьерт техникийн нөхөн сэргээлт болон биологийн нөхөн сэргээлт хийгдээгүй байв.

***Хог хаягдлын менежментийн талаар***

Хог хаягдлын менежментийн 14 шалгуурын 14 нь буюу 100 хувь биелсэн байна. Уурхайн хогийн цэг, бие засах газруудад ариутгал халдваргүйжүүлэлтийг 7 хоног тутам хийдэг талаар тус төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланд тусгажээ. БОА-ын газар дээрх үзлэгээр кемпийн талбайд, гал тогоо, шаардлагатай цэгүүдэд ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байршуулан, ил задгай хог хаягдахаас урьдчилан сэргийлж ажилладаг нь ажиглагдав. Хог хаягдлыг цаг тухайд нь Ерөө сумын хогийн цэгт гэрээгээр тээвэрлэн хүргэсэн, хог хаягдлын хураамжийг тухай бүр төлж ажилласан байв. Аюултай хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хадгалж байна. Сэлэнгэ аймгийн БОАЖ-ийн газраас үүсгэгчийн Ү-001963 дугаар авсан байна. Хандгайт гол ХХК нь үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлын хэмжээг аль болох бага байлгах, дахин ашиглах дахин боловсруулах зарчмыг баримтлан холбогдох арга хэмжээг БОМТ-ний Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгаж ажиллаж байна. Цаашид хог хаягдлын менежментийг ялангуяа аюултай хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой зөвлөмжийг тайланд тусгасан болно.

**Усны менежмент**

Ус ашиглалттай холбоотой 15 шалгуур үзүүлэлтийн 15 биелсэн буюу 100% биелэлттэй байна. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Баянголын нэртэй газарт үнд ахуйн усан хангамжийн зориулалтаар 1 худгийг мэргэжлийн байгууллага Сойл инженеринг ХХК-иар гаргуулж уснытоолуурын баталгаажуулалтын гэрчилгээг авсан байв. Худаг нь 70 м гүнтэй усны статик түвшин 18 м, усны ундарга 3.0 л/с байна. Ашиглагдаж байгаа худагт СВМ32х загварын 6 мЗ/цхэмжих хязгаартай 32 мм-ийн голчтой №12189-ын халуун, хүйтэн усны тоолуурыг №022 лацаар битүүмжилж 2025 оны 06-р сарын 04-ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын тоолуур суурьлуулсан байв. Уурхайн олборлолтын түвшин шүүрлийн усны түвшинд хүрээгүй учир шүүрлийн ус илрээгүй болно. 2024 онд ашигласан усны зориулалтаар ангилбал:

- Кемпийн үнд ахуйд 588.0 м<sup>3</sup>
- Ногоон байгууламж 56 м<sup>3</sup>
- Зам усалгаа 4620 м<sup>3</sup>
- Өрөмдлөгө 77.6 м<sup>3</sup>

"ТОПЛОС-ЦИКЛОН" бохир ус цэвэрлэх нэмэлт байгууламж нь хамгийн бага өртөгтэй, ахуйн бохир усыг боловсронгуй болгох шийдэл, биологийн цэвэршүүлэх системээр дамжсан бохир усыг хүлээн авдаг. "ЦИКЛОН 1" төхөөрөмж нь ахуйн бохир усыг цэвэрлэхдээ бохир усыг газар эсвэл усан сан руу цутгахаас өмнө нэмэлт төхөөрөмж ашиглах шаарддаг. Төхөөрөмжийг цэвэрлэх байгууламжид нэмэлтээр ашигладаг бөгөөд биологийн цэвэрлэгээний эцсийн шатыг хангадаг бөгөөд тэгш өнцөгт хэлбэртэй, их бие нь полипропиленээр хийгдсэн байдаг. Шүүлтүүртэй зэрэгцэн систем нь биологийн цэвэрлэгээний цогцолбороор дамжсаны дараа хаягдал усанд үлддэг органик гаралтай бохирдлыг устгах ажлыг гүйцэтгэдэг. Бохирдлын түвшинг хүссэн үзүүлэлт рүүгээ бууруулахад түсалж, ахуйн бохир усны 50 гаруй хувийг үлдэгдэл бохирдлоос цэвэрлэдэг байна. Ахуйн бохир усыг цэвэршүүлж, Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-т нийлүүлж байна. Хандгайт гол ХХК-ийн худгийн усны ерөнхий химийн шинжилгээг Газарзүй гео-экологийн усны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байна. Эдгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс төсөл хэрэгжүүлэгч ус ашиглалтын менежментийг амжилттай хэрэгжүүлж байна гэж дүгнэв.

***Биологийн олон янз байдлын хамгааллын менежмент***

Биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн холбогдох 6 шалгуур, үзүүлэлтийн 6 нь биелсэн нь 100 хувийн хэрэгжилттэй байна. Төслийн талбайн үс-намгархаг талбай болон ойн сан бүхий хэсгийг 2009 оны Монгол Улсын Их Хурлаас баталсан “Гол, мөрний үрсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн холбогдох заалтуудыг үндэслэн Баян голын хөндий, талбайн баруун болон өмнө хэсгийн ой бүхий хэсгүүдийг хассан байна. Байгаль орчин аялал жуулчлалын яамны ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн 2021 оны 04.20 өдрийн лавлагаагаар Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289-р тогтоолоор батлагдсан гол мөрний үрсац бүрэлдэх эхтэй давхцалгүй, ойн сантай давхцалгүй, усны сан бүхийн газрын энгийн хамгаалалтын бүстэй давхцалгүй, усны тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна. Төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан Биологийн олон янз байдлын хамгааллын менежменттэй холбоотой зөвлөмжийг амжилттай хэрэгжүүлж байна.

## 4.2 ЗӨВЛӨМЖ

### ***Байгаль орчны удирдлагын тогтолцоо***

RA1. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хуульд заасан нэмэлт, тодотгол хийх хугацаа болсон тул нэмэлт, тодотгол хийлгэх.

RA2. Гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

RA3. Дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг залруулах арга хэмжээ авах.

RA4. БОА-ын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэн, энэ тухай биелэлтийн тайланг 2027 оны 4 дүгээр улиралд багтаан Сэлэнгэ аймгийн БОАЖГ-т хүргүүлэх.

### ***Агаарын чанарын талаар***

RB1. Дүү шингээх ба тусгаарлах хэрэгсэл ашиглан шуугианы тархалтыг хязгаарлах.

### ***Газар ашиглалт, нөхөн сэргээлтийн менежментийн талаар***

RC1. Хөрсөн дээр машин техник, тоног төхөөрөмжийг боломжийн хэрээр хучлагатай талбайд байршуулах. Ил хөрсөн дээр байрлуулах тохиолдолд аль болох талбай бага эзлүүлэн эмх цэгцтэй хурааж, өртөх талбайг багасгах, хөрсний бохирдол, эзлэх талбайг нэмэгдүүлэхгүй байх.

RC2. Шатах тослох материал ашиглах, хадгалж буй агуулахын орчимд нэг цэг сонгон хөрсний бохирдолтой хэсгээс дээж авч, лабораторид хөрсний хүнд металлын шинжилгээ хийлгэх.

RC3. Төслийн талбайд газрын төлөв байдал, чанарын үлсын хянан баталгааны хугацаа дуусч байх тул шинээр хийлгэх.

RC4. Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарих.

RC5. Хөрс бохирдуулагч жорлон ашиглахаас татгалзаж, био жорлон ашиглах.

**Хог хаягдлын менежментийн талаар**

RD1. Хог хаягдлын нэгдсэн цэгийг салхи, хур тундасны усаар хөрс бохирдох, хамгаалсан халхавч дээвэртэй болгож, тохижуулах.



RD2. Ашигласан эмнэлэгийн хог хаягдал болон хугацаа нь дууссан батерей, автомашины аккумулятор зэргийг түсд нь хадгалж, устгуулах акт үйлдэж хэвших.

RD3. Ажилтнуудыг хамруулан аюултай хог хаягдлын сургалт зохион байгуулах.

RD4. Ашигласан тос, масло бүхий аюултай хог хаягдал хадгалах газар, талбайгаас ашигласан тос, маслыг авах, зөөх үед хөрсөнд асгарч хөрс бохирдохоос сэргийлэх журам баталж, сэргийлэх үзлэг хийх, бохирдол асгаралтыг илрүүлэх, цэвэрлэх ажлыг зохион байгуулж байх.

RD5. Одоо ашиглаж байгаа аюултай хог хаягдал хадгалах талбай буюу завсар, үйлчилгээний хэсэгт асгаралтаас сэргийлсэн, хальж урсахаас хамгаалсан ирмэг, хашлагатай болгох.

RD6. Аюултай хог хаягдлыг хадгалахдаа “Аюултай хог хаягдал” гэх бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэж байх.

RD7. Аюултай хог хаягдлын бүртгэл хөтөлж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгөхдөө акт үйлдэж хэвших.

**Ус ашиглалтын менежментийн талаар**

RE1. Бохир усыг цэвэрлэж, нэгдсэн цэвэрлэх системд нийлүүлэхийн өмнө холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэх хяналтыг тогтмол давтамжтай хийх.

**ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

**4.3 ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 7. Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө*

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
<b>Богино хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай (БОА хийснээс хойш 1-2 улиралд багтаан)</b>			
1	Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хуульд заасан нэмэлт, тодотгол хийх хугацаа болсон тул нэмэлт, тодотгол хийлгэх.	2025.IV	ХАБЭА, БО-ны нэгж, мэргэжилтэн
<b>Дунд хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай (БОА хийснээс хойш 3-5 улиралд багтаан)</b>			
2	Аюултай хог хаягдлын талаар сургалт зохион байгуулах.	2026.II	БО-ны мэргэжилтэн
3	ШТС болон шатах тослох материалын талбайд хөрсний бохирдолтой хэсгээс дээж авч, лабораторид хөрсний хүнд металлын шинжилгээ хийлгэх.	2026.III	БО-ны мэргэжилтэн
4	Эмнэлэгийн хог хаягдал, хугацаа дууссан батерей, автомашины аккумулятор, ашигласан тос, масло зэргийг тусд нь хадгалж, устгуулах, акт үйлдэж хэвших.	2026.IV	ХАБЭА, БО-ны нэгж, мэргэжилтэн
5	Хоёр жилээс дээш хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст ургамал тарих.	2026.IV	БО-ны мэргэжилтэн
6	Хөрс бохирдохоос сэргийлэх журам баталж, хэрэгжүүлэх.		БО-ны мэргэжилтэн
7	Хог хаягдлын нэгдсэн цэгийг салхинд хог хаягдал хийсэх, хүр тундасны усаар хөрс бохирдохоос хамгаалсан халхавч дээвэртэй болгож, тохижуулах.	2026.IV	ХАБЭА, БО-ны нэгж, мэргэжилтэн
8	Төслийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайланд нэмэлт, тодотгол хийлгэх.	2026.IV	БО-ны нэгж, мэргэжилтэн
9	Одоо ашиглаж байгаа аюултай хог хаягдал хадгалах талбайг асгаралтаас сэргийлсэн, хальж урсах аас хамгаалсан ирмэг, хашлагатай болгох.	2026.IV	Удирдлагын баг
10	Аюултай хог хаягдлыг хадгалахад "Аюултай хог хаягдал" гэх бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй, ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэж байх.	2026.IV	ХАБЭА, БО-ны нэгж, мэргэжилтэн
<b>Урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай (БОА хийснээс хойш 6-7 улиралд багтаан)</b>			
11	БОА-ын тайлангийн зөвлөмж хэрэгжүүлж, 2027 оны 4-р улиралд багтаан биелэлтийн тайланг Сэлэнгэ аймгийн БОАЖГ-т хүргүүлэх.	2027. IV	Удирдлагын баг

## ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- (ISO-19011:2018 Guidelines for Auditing Management Systems)
- (MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага)
- (MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ)
- (MNS 900:2010 Ундны усны эрүүл ахуйн шаардлагын хүлцэх дээд агууламж)
- (MNS 6200: 2010 Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт)
- (MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага)
- (Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2012)
- (Агаарын тухай хууль, 2012)
- (Зөвшөөрлийн тухай хууль, 2022)
- (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/809 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”)
- (Эко-Акюрэси ХХК-ийн захирлын 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 20/02 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Байгаль орчны аудиторын ажиллах журам”)
- (Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалын хавсралт)
- (Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам. Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт)
- (Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995)
- (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012)
- (Газрын тухай хууль, 2002)
- (Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах “Хандгайт гол” ХХК-ийн MV-021595 тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, Эм И Си Эс Зэт Би ХХК, 2022)
- (Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянголын эх хөндий газарт байрлах “Хандгайт гол ХХК” ХХК-ийн эзэмшил MV-021595 төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан, 2021)
- (Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хандгайт гол ХХК-ийн MV-021595 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Баянголын эх хөндийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө)
- (Хог хаягдлын тухай хууль, 2017)
- (Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012)
- (Усны тухай хууль, 2012)
- (Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын хавсралт)

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ийн ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

ТАВ. ХАВСРАЛТУУД

5.1 ГЭРЭЛ ЗУРАГ



Тайлбар:


Авто зогсоолын орчны гэрэл зураг

Огноо:

2025.09.06

Зургийн дугаар:

EC6



6 Sept 2025 11:16:37  
176° S  
Nergui Zam  
Yeroo  
Selenge  
Altitude: 763.0m asl  
Speed: 0.0km/h  
Index number: 61

Тайлбар:

Ажилдчын кемп, түүний орчны гэрэл зураг

Зургийн дугаар:

EC4

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН



Тайлбар:  
Зургийн дугаар

Үерийн хамгаалалтын далан  
EE13, 14



Тайлбар:  
Зургийн дугаар:

Засварын талбайн гэрэл зураг  
EC14

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ийн ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН



Аюултай хог хаягдлын цэгийн гэрэл зураг  
ED9

Тайлбар:  
Зургийн дугаар:



Тайлбар:  
Зургийн дугаар:

Ахуйн бохир үс түр хадгалах байгууламж  
EC5

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН



Тайлбар:  
Зургийн дугаар

Төслийн талбайд хогийг эх үүсвэр дээр нь ангилж ялгасан байдал ED12



Тайлбар:  
Огноо:  
Зургийн дугаар:

Шимт хөрсний овоолго  
2025.09.06  
EC9

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ийн ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН



Тайлбар:  
Огноо:  
Зургийн дугаар


Хог хаягдлын цэгийн гэрэл зураг  
2025.09.06  
EC8



Тайлбар:  
Зургийн дугаар:

Хог хаягдлын нэгдсэн цэгийн гэрэл зураг  
ED14

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ийн ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН



Тайлбар:  
Зургийн дугаар:

Хандгайт гол ХХК-ийн уурхайн замын орчны гэрэл зураг  
EB6



Тайлбар:  
Зургийн дугаар:

Уурхайн замын гэрэл зураг  
EC19

ХАНДГАЙТ ГОЛ ХХК-ИЙН ЭЗЭМШИЛ MV-021595 ДУГААРТАЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН


 СТАНДАРТ, КЭМЖИЛ ЭГҮЙН ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**  
 № ЭУ 251520

.....Д  
 (хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXSG загварын 63 м/ц  
 хэмжих хязгаартай, 25 мм-ийн голмтой № 202312132 -ын  
 халуун, хүйтэн усны тоолуурыг № 018 ..... лацаар битүүмжилж  
 (доогуур зураг)

2027 оны 07 -р сарын 30 -ны өдөр хүртэл улсын  
 баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000001 м


Лабораторийн тэмдэг  
 2025 оны 07 -р сарын 30 -ны өдөр

Улсын шалгагчийн  
 гарын үсэг, тэмдэг

Тайлбар: Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ, № ЭУ 251520

Байршил: Хандгайт гол ХХК-ийн Төмрийн хүдэр ил аргаар ашиглах төслийн талбай

Зургийн дугаар: EE8



Тайлбар: Гал унтраах хэрэгсэл байршуулсан байдал

Зургийн дугаар: ED6

## ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

2025.10.22

Улаанбаатар хот

Гэрээний нэр	Байгаль орчны аудит хийх үйлчилгээний гэрээ Дугаар: КНГ-2025-08-27
Захиалагч байгууллага	Хандгайт гол ХХК
Гүйцэтгэгч байгууллага	Эко-Акюрэси ХХК
Гэрээний эхлэх хугацаа	2025.08.27
Гэрээний дуусах хугацаа	Байгаль орчны аудитын газар дээрх үзлэгийг зохион байгуулсан өдрөөс хойш гэрээний хугацаанд багтаан эцсийн тайланг хүлээлгэн өгсөн.
Гэрээний үнийн дүн	9,000,000 /Есөн сая/ төгрөг
Гүйцэтгэл	Олгосон санхүүжилт: 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөг Олгох санхүүжилт: 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөг
Гэрээний биелэлт, тайлбар, шийдвэрлэлт:	
<p>Байгаль орчны аудит хийх үйлчилгээний КНГ-2025-08-27 тоот гэрээний дагуу 2025 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Эко-Акюрэси ХХК нь төслийн газар дээр очиж, байгаль орчны гүйцэлтэй танилцаж, "Баянголын ордын Баруун хүдрийн биетийн VI орд" нэртэй төслийн байгаль орчны аудитын тайлангийн төслийг гэрээний хугацаанд багтаан хүргүүлж, захиалагчаас ирүүлсэн саналд залруулах боломжтой зүйлсийг хүлээн авч, тайланд холбогдох сайжруулалт хийж, тайланг эцсийн байдлаар хүлээлгэн өгсөн. Иймд гэрээний санхүүжилтийн үлдэх 50 хувь буюу 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгийг үйлчилгээ үзүүлэгч Эко-Акюрэси ХХК-д олгохоор захиалагч шийдвэрлэв.</p>	

Гэрээг дүгнэсэн талууд:

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгч:

Хандгайт гол ХХК -ийн .....

Эко-Акюрэси ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Ахлах аудитор





М.Отгонцэцэг

АЖИЛ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2025 оны 10-р сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Ажлын нэр: Байгаль орчны аудит хийх үйлчилгээний гэрээ  
Ажлын захиалагч: Хандгайт гол ХХК  
Ажлын гүйцэтгэгч: Эко-Акюрэси ХХК

№	Ажлын нэр	Хүлээлгэн өгсөн
1	Гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний дагуу Захиалагчид Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт дахь "Баянголын ордын Баруун хүдрийн биетийн VI орд" нэртэй ил уурхайн төслийн байгаль орчны аудитыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэж, эцсийн тайланг файл/ цаасан хэлбэрээр хүлээлгэн өгөв.	Ажлын тайланг файл хэлбэрээр /pdf өргөтгөлөөр/ 1 хувь, хэвлэмэл хэлбэрээр 2 хувь

Ажил хүлээлцсэн талууд:

Захиалагчийг төлөөлж:

Хандгайт гол ХХК -ийн *Молчин*

*Молчин*  
*М.Отгонцэцэг*

Гүйцэтгэгч:

Эко-Акюрэси ХХК-ийн гүйцэтгэх захирал, Ахлах аудитор



М.Отгонцэцэг